

МОНГОЛ УЛСЫН АРВАН ДОЛООДУГААР БУЮУ 2022 ОНЫ НЭГТГЭЛ ТАЙЛАН

Олборлох үйлдвэрлэлийн
ил тод байдлын
санаачилга



МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН АРВАН ДОЛООДУГААР БУЮУ 2022 ОНЫ НЭГТГЭЛ ТАЙЛАН

Захиалагч: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын ОҮИТБС-ын Ажлын алба

Гүйцэтгэгч: “Эс Ай Си Эй” ХХК, “Гроут Финанс аудит” ХХК

Тайланг олон нийт ажлын хэрэгцээнд зориулан бүтэн болон хэсэгчлэн авч ашиглах нь нээлттэй тул ашигласан тохиолдолд эх сурвалж нь Монгол Улсын ОҮИТБС-ын 17 дугаар буюу 2022 оны нэгтгэл тайлан болохыг дурдана уу.

Монголын ОҮИТБС-ын Ажлын алба

Утас: 7011 0525

Факс: 7011 0155

Цахим хуудас: www.eitimongolia.mn

Facebook хуудас: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

Цаасны хэмжээ: 210 x 297 мм

Хэвлэлийн хуудас: 19.5 хх

_____ХХК-д хэвлэв.

Улаанбаатар хот

2023 он

Энэхүү тайлан болон хавсралтуудыг Монголын ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын албаны хүсэлтээр, ОУИТБС-ын санаачилгын зорилгын үүднээс Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт ажлын хэсэг болон олон нийтэд зориулсан болно.

ОУИТБС-ын шаардлага болон ажлын даалгаврын дагуу ил тод болох шаардлагатай мэдээллүүдийг хавсралтаар харуулсан. Зарим хавсралт их хэмжээний мэдээлэл агуулсан тул энэхүү тайланд иж бүрнээр оруулахад хүндрэлтэй байсан тул хураангуйлж оруулсан. Дэлгэрэнгүй хавсралтуудыг ашиглахад хялбар байх үүднээс ОУИТБС-ын ажлын албаны цахим хуудаст Ms Excel форматаар ил тод болгосон.

“Эс Ай Си Эй” ХХК, “Гроут финанс” ХХК

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА	10
1.1. Холбогдох мэдээлэл	10
1.2. Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг	11
1.3. Оролцогчид	11
1.4. Хүндрэл бэрхшээл	11
1.5. Талархал	12
БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ.....	13
2.1. Салбарын тойм	13
2.2. ОУИТБС-ын оролцоо	13
2.3. Тайлангийн цар хүрээ.....	13
2.4. Засгийн газрын нийт орлого	14
2.5. Нэгтгэлийн үр дүнгийн хураангуй.....	16
2.6. Мэдээллийн үнэн зөв байдал.....	19
2.7. Мэдээллийн чанар, тайлангийн баталгаажуулалтын талаар	19
БҮЛЭГ 3. ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ	23
3.1. Танилцуулга	23
3.2. Мэдээллийн хамрах хүрээг тодорхойлох нь.....	23
3.3. Аргачлал	26
3.4. Баталгаажуулалт	28
БҮЛЭГ 4. ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН.....	29
4.1. Анхлан тайлагнасан урсгалуудын хураангуй	29
4.2. Анхны тохируулаагүй зөрүү болон тайлагнаагүй компаниуд.....	29
4.3. Тохируулаагүй үлдсэн зөрүү	30
4.4. Тайлагнаагүй компани	33
4.5. Нэгтгэлийн дэлгэрэнгүй үр дүн.....	34
БҮЛЭГ 5. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАР	40
5.1. Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (Шаардлага 2.1)	40
5.2. Уул уурхай.....	53
5.3. Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл, экспорт (Шаардлага 3.1).....	72
5.4. Газрын тос болон байгалийн хий	78
5.5. Олборлох салбараас эдийн засагт оруулсан хувь нэмэр	98
5.6. Засгийн газрын байгууллагууд.....	103
5.7. Олборлох салбар дахь төрийн оролцоо	107
5.8. Төсвийн үйл явц болон орлогын хуваарилалт	123
БҮЛЭГ 6. БУСАД АСУУДАЛ	130
6.1. Эцсийн өмчлөгч (Шаардлага 2.5).....	130
6.2. Гэрээний ил тод байдал	133
6.3. Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо (Шаардлага 4.3)	136

6.4. Тээвэрлэлтийн орлого (Шаардлага 4.4)	137
6.5. Нөхөн сэргээлтийн мэдээлэл	137
6.6. Цахим тайлагналын систем	143
6.7. Ашигласан усны мэдээлэл	145
6.8. Хог хаягдлын мэдээлэл	145
6.9. ОУИТБС-ын тайлангийн задаргааны төвшин, хэлбэр (Шаардлага 4.7).....	146
БҮЛЭГ 7. ЗӨВЛӨМЖ	148
7.1 Өмнөх жилийн нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	148
7.2 ОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж.....	155
ХАВСРАЛТУУД	157

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Засгийн газрын хүлээн авсан орлого, байгууллагаар, сая төгрөгөөр	14
Хүснэгт 2. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга, сая төгрөгөөр	15
Хүснэгт 3. Засгийн газар, компанийн орлогын урсгалын тохируулга, сая төгрөгөөр	16
Хүснэгт 4. 2018-2022 онуудын нэгтгэл тайлангийн үр дүн, сая төгрөгөөр	17
Хүснэгт 5. Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас топ 20 компанийн төлбөр, сая төгрөгөөр, хувиар	17
Хүснэгт 6. ТББ-ын санал болгож нэгтгэл тайланд хамруулсан ААН-ын төлбөр, сая төгрөгөөр	18
Хүснэгт 7. Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас хамгийн бага татвар төлсөн 20 ААН-ын төлбөр, сая төгрөгөөр хувиар	18
Хүснэгт 8. Компаниудын мэдээлэл ирүүлэлт	19
Хүснэгт 9. Маягтаар цуглуулсан мэдээлэл, ААНБ-ын тоо, оноор	20
Хүснэгт 10. Засгийн газрын тайлагнасан орлого болон компанийн тоо, сая төгрөгөөр	24
Хүснэгт 11. Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, орлого, сая төгрөгөөр	25
Хүснэгт 12. ТОП татвар төлөгчдөөс хүлээн авсан орлого, оноор	25
Хүснэгт 13. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр	29
Хүснэгт 14. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр	29
Хүснэгт 15. Тохируулаагүй зөрүү, сая төгрөгөөр	29
Хүснэгт 16. Тохируулаагүй үлдсэн зөрүү, орлогын урсгалаар /сая төгрөгөөр/	30
Хүснэгт 17. Тохируулаагүй үлдсэн зөрүү, компаниар	31
Хүснэгт 18. Орон нутгийн хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр	34
Хүснэгт 19. Улсын хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр	35
Хүснэгт 20. Улсын хэмжээний нэгтгэл, орлогын урсгалаар, сая төгрөгөөр	36
Хүснэгт 21. Олборлох үйлдвэрлэлийн гол хуулиудад 2022 онд орсон нэмэлт өөрчлөлтүүд	42
Хүснэгт 22. Олборлох үйлдвэрлэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн гол зохицуулалт	47
Хүснэгт 23. Салбарын бусад хуулиуд	48
Хүснэгт 24. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ	53
Хүснэгт 25. Уул уурхайн салбарын үндсэн үзүүлэлтүүд	53
Хүснэгт 26. Уурхайн салбарын гол бүтээгдэхүүнүүдийн олборлолт	53
Хүснэгт 27. Хүчин төгөлдөр байгаа Ураны тусгай зөвшөөрлүүд	54
Хүснэгт 28. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд	54
Хүснэгт 29. Монгол банканд иргэдийн тушаасан алт	57
Хүснэгт 30. Бичил уурхайгаар олборлох дүгнэлт гарсан талбай, га	57
Хүснэгт 31. Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр	60
Хүснэгт 32. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд	62
Хүснэгт 33. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц	63
Хүснэгт 34. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц	63
Хүснэгт 35. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц	64
Хүснэгт 36. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц	65
Хүснэгт 37. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын техникийн саналын үнэлгээний хуудас	65
Хүснэгт 38. Цацрагт идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	66
Хүснэгт 39. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	68
Хүснэгт 40. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	69
Хүснэгт 41. 2022 онд шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүд	71
Хүснэгт 42. Тусгай зөвшөөрлийн ил тод байдал	72
Хүснэгт 43. 2022 онд эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан компаниуд	72

Хүснэгт 44. Геологи, хайгуулын ажилд зарцуулсан, гүйцэтгэсэн ажлын төрлөөр, сая төгрөгөөр	73
Хүснэгт 45. Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая төгрөгөөр	73
Хүснэгт 46. Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспорт	74
Хүснэгт 47. Уул уурхайн голлох бүтээгдэхүүний олборлолт	74
Хүснэгт 48. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ /ам.доллар/	75
Хүснэгт 49. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/	75
Хүснэгт 50. Уул уурхайн гол бүтээгдэхүүнүүдийн сүүлийн 10 жилийн үйлдвэрлэл	76
Хүснэгт 51. Экспортоор тэргүүлэгч бүтээгдэхүүний 2022 оны экспортын тоо хэмжээ	78
Хүснэгт 52. Газрын тосны бүтээгдэхүүний сүүлийн 2 жилийн нөөц /тн/	81
Хүснэгт 53. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц	82
Хүснэгт 54. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл сунгах үйл явц	83
Хүснэгт 55. Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц	83
Хүснэгт 56. Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц	84
Хүснэгт 57. Тусгай зөвшөөрөл олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд	84
Хүснэгт 58. БХГ-тэй холбоотой хууль тогтоомж	86
Хүснэгт 59. БХГ байгуулсан компаниуд	89
Хүснэгт 60. 2022 оны байдлаар ил тод болсон БХГ-үүдийн жагсаалт	90
Хүснэгт 61. Ил тод болгосон эрлийн ажил гүйцэтгэх гэрээ	92
Хүснэгт 62. 2022 оны газрын тосны олборлолт экспорт	94
Хүснэгт 63. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ 2021, 2022 оны сар бүрээр /төгрөгөөр/	95
Хүснэгт 64. Газрын тосны бүтээгдэхүүний үнийг улс аймаг бүсээр /төгрөгөөр/	96
Хүснэгт 65. Сүүлийн 3 жилийн ДНБ болон ДНБ-ий өсөлт	98
Хүснэгт 66. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт	100
Хүснэгт 67. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/	100
Хүснэгт 68. Эрдсийн бүтээгдэхүүний импорт	101
Хүснэгт 69. Нефтийн бүтээгдэхүүний импортын гүйцэтгэл /сая ам.доллар/	101
Хүснэгт 70. Уул уурхай олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	102
Хүснэгт 71. Төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр	103
Хүснэгт 72. ТӨААН-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	109
Хүснэгт 73. ТӨААН-ийн 2022 онд төлсөн өр төлбөр, зээлийн хэмжээ (сая.төг)	116
Хүснэгт 74. ТӨААН хоорондын гүйлгээний ил тод байдал	116
Хүснэгт 75. ТӨААН-үүдийн тайлангаа ил тод болгосон эсэх	117
Хүснэгт 76. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн ил тод байдал	118
Хүснэгт 77. ТӨААН-үүд аудитын тайлангаа ил тод болгосон эсэх	119
Хүснэгт 78. ТӨААН-ийн дүрэм ил тод болгосон эсэх	119
Хүснэгт 79. 2022 онд Шилэн дансны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт	120
Хүснэгт 80. Шилэн дансанд ил тод болгосон эсэх	120
Хүснэгт 81. Худалдан авалтын ил тод байдал	121
Хүснэгт 82. ТӨААН-ийн шилэн дансны мэдээлэл	122
Хүснэгт 83. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2022 оны орлогын шилжүүлгийн мэдээлэл /мян.төг//	124
Хүснэгт 84. Монгол улсын 2022 оны төсөвт аймгуудад олгохоор батлагдсан санхүүгийн дэмжлэгийн дүн /мян.төг/	124
Хүснэгт 85. Уул уурхайн салбарын 2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	125
Хүснэгт 86. Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны нээлттэй мэдээлэл	128
Хүснэгт 87. Эцсийн өмчлөгчийг ил тод болгох талаар хэрэгжүүлж байсан арга хэмжээ ..	130
Хүснэгт 88. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эцсийн өмчлөгч	132
Хүснэгт 89. Гэрээний ил тод байдал	134
Хүснэгт 90. Мэдээллийн санд байршуулсан гэрээ	135
Хүснэгт 91. 2022 оны ус ашиглалтын мэдээлэл	145
Хүснэгт 92. 2022 онд усны төлбөр төлсөн ТОП 10 компани	145
Хүснэгт 93. Хог хаягдлын өндөр төлбөр төлсөн 10 компани	146

Хүснэгт 94. ОҮИТБС-ын 2018, 2019, 2020, 2021 оны нэгтгэл тайлангуудад болон 2022 оны Баталгаажуулалтын тайланд тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа.....	148
--	-----

Зураг 1. Нэгтгэл тайланд хамруулсан компаниудын үйл ажиллагааны чиглэл	25
Зураг 2. Цахим тайлангийн систем дэх талуудын оролцоо	27
Зураг 3. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул ашиглалтын талбайн байршил	81
Зураг 4. Газрын тосны олборлолт экспорт, төсөвт төвлөрүүлсэн орлого	94
Зураг 5. 2022 онд олборлох үйлдвэрлэлийн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт	99
Зураг 6. Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр мөрдөгдөж буй хуулиуд.....	138
Зураг 7. Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх хуулиудын хүрээнд мөрдөгдөж буй журмууд	139
Зураг 8. БОТБҮ хийх үйл явц.....	140
Зураг 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үе шат.....	141
Зураг 10. Цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмууд.....	144
Зураг 11. ОҮИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага	144
Зураг 12. Хог хаягдлын мэдээлэл, м ³	146

График 1. ТОП татвар төлөгчдөөс хүлээн авсан орлого, оноор.....	26
График 2. Нөхөн сэргээлт хийсэн байдал.....	58
График 3. Уул уурхайн гол бүтээгдэхүүний сүүлийн 10 жилийн үйлдвэрлэл.....	77
График 4. 2022 оны уул уурхайн салбарын экспортын гүйцэтгэл	78
График 5. Газрын тосны экспорт болон газрын тосны бүтээгдэхүүний импорт.....	79
График 6. Монгол Улсын хэмжээнд ашиглалтад шилжсэн орд газруудын газрын тосны нөөц, сая тонн	80
График 7. Сүүлийн 4 жилийн газрын тосны олборлолт экспорт, мян.бар.....	94
График 8. ДНБ болон уул уурхай , олборлох салбарын орлогын сүүлийн 7 жилийн харьцуулалт /их наяд төгрөгөөр/	98
График 9. 2018 оноос 2022 он хүртэлх Монголбанкны худалдан авсан үнэт металлын мэдээ /кг/	128
График 10. 2020-2022 оны эцсийн өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн байдал.....	132
График 11. Мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо	135
График 12. Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, үнэлгээний чиглэлээр.....	142
График 13. Батлагдсан нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, оноор	142
График 14. Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, оноор.....	142

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	Entity
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Corporate Income Tax
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар)	United States Dollars
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар	Mineral Resources and Petroleum Authority
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	License fee for exploitation and exploration of mineral resources
АНУ	Америкийн нэгдсэн улс	United States of America
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт	International Standards on Auditing
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс	Republic of Korea
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард	Republic of China
БО	Байгаль орчин	Environment
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Ministry of Environment and Tourism
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Ministry of Environment, Green Development and Tourism
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Environmental protection plan
ЭӨ	Эцсийн өмчлөгч	Beneficial owner
БУУ	Бичил уул уурхай	Micro mining
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Product Sharing Agreement
ГЕГ	Гаалийн ерөнхий газар	Customs General Administration
ГТГ	Газрын тосны газар	Petroleum Authority
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Gross Domestic Product
ДЦС	Дулааны цахилгаан станц	Thermal Power
ЗГ	Засгийн газар	Government
ЗДТГ	Засаг даргын тамгын газар	Governor's office
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Mongolia Extractive Industry Transparency Initiative
МУ	Монгол улс	Mongolia
МУУА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци	Mongolian National Mining Association
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	State Professional Inspection Agency
Мян.тн	Мянган тонн	Thousand tonnes
НББ	Нягтлан бодох бүртгэл	Accounting
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт	International Accounting Standards
НДС	Нийгмийн даатгалын сан	Social Insurance Fund
ННФ	Нээлттэй нийгэм форум	Open Society Forum
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Value Added Tax
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	Local Development Consolidated Fund
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан	Local Development Fund
ОТАХ	Олон талт оролцогчдын ажлын хэсэг	Multi-Stakeholder Working Group
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Extractive Industry Transparency Initiative
ОХУ	Оросын холбооны улс	Russia Federation
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт	International Standards on Financial Reporting
СЯ	Сангийн яам	Ministry of Finance
ЦТС	Цахим тайлангийн систем	Electronic reporting system
ТАН	Төлсөн Авсанаа Нийтэл	Publsih What You Pay
ТББ	Төрийн бус байгууллага	Non-governmental Organization
ТБУ	Тогтвортой бичил уурхай	Sustainable artisanal mining
ТЕГ	Татварын ерөнхий газар	General Department of Taxation
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч	General budget governor

ТЕХ	Татварын ерөнхий хууль	General Law of Mongolia on Taxation
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж	State-Owned Entities
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Government agency for policy coordination on state property
ТӨК	Төрийн өмчит компани	State-Owned Companies
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	State-Owned Joint Stock Company
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл	Board of Directors
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл	Technical and Economic Feasibility Study
УИХ	Улсын их хурал	Parliament of Mongolia
УУХҮЯ	Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яам	Ministry of Mining and Heavy Industry
ҮАГ	Үндэсний аудитын газар	Mogolian National Audit office
ҮАҮТ	Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө	National action plan
ҮСХ	Үндэсний статистикийн хороо	National statistics of Mongolia
ХБ	Хөрөнгийн бирж	Stock Exchange
ХК	Хувьцаат компани	Joint Stock Company
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ministry of labor and social protection
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Limited Liability Company
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Mineral Professional Council

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) гэдэг нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм.

ОҮИТБС нь нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлсөн төлбөрөө, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнадаг ба хоёр талаас ирүүлсэн тайланг Хараат бус хянагч-нэгтгэгч хянан нэгтгэж, ОҮИТБС-ын стандартад заасан шаардлагуудын дагуу орлогын бус мэдээллийг хамруулан, олборлох салбарын тайлан гаргаж, түүнийг олон нийтэд ил тод болгоно. Энэхүү үйл явцыг төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлэг удирдан явуулж, хянан зохицуулна.

1.1. Холбогдох мэдээлэл

ОҮИТБС бол газрын тос, байгалийн хий, олборлох салбарт ил тод байдал, тайлагналыг сайжруулахад зориулсан глобал стандарт юм. Монгол Улсын Засгийн газар ОҮИТБС-ыг хүлээн авч байгаа тухайгаа 2006 онд зарласан бөгөөд дагалдан хийгдэх ажлуудыг хэрэгжүүлж, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл болон Олон талт оролцогчдын ажлын хэсэг (ОТАХ)-ийг Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан байгуулсан юм.

Монгол Улс ОҮИТБС-д нэгдсэнээс эхлэн ОҮИТБС-ын 16 удаагийн тайланг бэлтгэн гаргасан бөгөөд энэхүү арван долоо дахь удаагийн тайлангийн Хараат бус хянагч-нэгтгэгчээр “Эс Ай Си Эй” ХХК болон “Гроут Финанс аудит” ХХК-ын хамтарсан баг 2 дэх удаагаа сонгогдсон болно.

ОҮИТБС-ын Стандарт (Стандарт) нь түүнийг хэрэгжүүлэх зарчмууд болон шаардлагуудыг 2016 оны 2-р сарын 24-25-нд Лима хотод хуралдсан ОҮИТБС-ын олон улсын хуралдаанаар баталсан ба 2016, 2019 онуудад 2 удаа шинэчлэн баталсан.

Уг стандарт нь ОҮИТБС-ын мэдээллийг цуглуулахад улс орнуудын тайлан гаргалтын одоогийн системүүдийг ашиглах, үр дүнг ил тод байлгахыг дэмждэг ба олборлох үйл ажиллагааг эзэмшиж, ашиг хүртэж байгаа хувь хүмүүсийн тухай мэдээллийг ил болгохыг шаарддаг. Олборлох төслүүдийн тендерт оролцож, хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт хийж буй компаниуд өөрсдийн эцсийн өмчлөгчид буюу ашиг хүртэгч эздийг ил тод мэдээлдэг байхыг бүх улс орнууд баталгаажуулах шаардлагатай юм.

ОҮИТБС-ын шаардлагуудыг улс орнууд баримталж байгаа эсэхийг шалгаж тогтоодог баталгаажуулалтыг 2016 оны ОҮИТБС-ын Стандартын хүрээнд улам боловсронгуй болгосон юм. Энэ Стандартыг дагаж мөрдөх журмыг өөрчлөөгүй боловч гишүүнчлэл бүхий улс орнуудын харилцан адилгүй байдал, минимум шаардлагуудыг давуулан биелүүлэх чармайлтууд, хэрэгжүүлэх явцаа үргэлжлүүлэн сайжруулж байгаа зэргийг үнэлгээ дүгнэлтэд өргөн хүрээнд харгалзан авч үзэх юм.

ОҮИТБС-ын 2019 оны Стандартад дэлхийн хэмжээний асуудал болоод буй байгаль орчин, нийгэм, жендерийн тэгш байдлын үр нөлөөг хамруулсан ба өмнө ил тод болоогүй

ашигт малтмалын борлуулалт, төслөөр тайлагнах болон 2022 оноос хойш байгуулагдах бүх гэрээнүүдийг ил тод болгохыг санаачилгад нэгдсэн орнуудад үүрэг болгожээ.

1.2. Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг

Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг нь ажлын даалгаварт заасны дагуу дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ.

- ОТАХ-ийн шийдвэр гаргах үйл явцад зориулж Монгол улсын 2022 оны нэгтгэл тайлангийн цар хүрээг тодорхойлох судалгаа хийх.
- ОУИТБС-ын стандарт болон энэ ажлын даалгаврын 2-т заасны дагуу Монгол Улсын ОУИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланг боловсруулах.
- Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын хувьд салбарын засаглалыг сайжруулах, олон улсын жишигт хүрэхүйц хэмжээнд салбарыг удирдахад анхаарах бүтээлч дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах.

1.3. Оролцогчид

Уг тайлан нэгтгэлд оролцогч талууд нь:

- Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас материаллаг хэмжээний орлого хүлээн авч байгаа төрийн болон орон нутгийн төрийн байгууллагууд,
- Олборлох салбарыг хянах, зохицуулах, тайлан гаргуулах хариуцлага бүхий Засгийн газрын яамд, агентлагууд
- Олборлох салбарт ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд
- Холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу төрийн байгууллагуудад материаллаг төлбөр төлж байгаа, олборлох салбарын компаниуд зэрэг юм.

Нэгтгэл тайланд оролцож байгаа төрийн байгууллагууд, компаниудын тухай мэдээллийг 3.2 бүлэг болон Хавсралт 1-ээс үзнэ үү.

1.4. Хүндрэл бэрхшээл

Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хоёр дахь жилдээ энэхүү тайланг хийж байна. Нэгтгэл хийх явцад өмнөх жилүүдтэй ижил сонгогдсон компаниудтай холбогдоход холбоо барих мэдээлэл дутмаг, мэдээлэл өгөхдөө хойрго хандах зэрэг асуудал хэвээр байсан бөгөөд ЗГ-ын холбогдох байгууллагуудтай ажиллахад шат дараалал ихтэйгээс шалтгаалан шаардлагатай мэдээллийг цуглуулахад цаг хугацаа их орж байсан. Нөгөө талаар олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН болон Засгийн газрын тайлагнах мэдээллийг ирүүлсэн төрийн байгууллагын зүгээс мэдээллийн санд мэдээллийг алдаатай оруулах байдал байсаар байлаа. Өмнө жилийг бодоход анхны нэгтгэлийн зөрүү бага гарсан хэдий ч тайланд хамрагдаж байгаа ААН-дийн тоо нэмэгдсэн, бичил жижиг олборлолт явуулдаг ААН-үүд ихээр нэмэгдсэнтэй холбоотойгоор холбогдож мэдээлэл авахад хүндрэлтэй байсан. Үүнтэй холбоотой анхны тохируулгын үйл ажиллагаанд цаг хугацаа их орох, тодруулга авах үйл ажиллагааг дахин давтан хийгдэх байдал гарч байлаа.

Мөн ОУИТБС-ын нэгтгэл тайланд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд хамрагдах ёстой гэсэн эрх зүйн орчин нөхцөл байхгүй. Өөрөөр хэлбэл ямар нэгэн хууль, журам байхгүй учир арван долоодугаар нэгтгэл тайланд хамрагдаж байгаа тодорхой хэдэн байгууллагууд хамрагдахаас татгалзаж, тайланг бэлтгэхэд хүндрэл учруулж байсан.

1.5. Талархал

“Эс Ай Си Эй” ХХК-ийг төрийн байгууллагууд, агентлагууд болон олборлох салбарын компаниудаас зөвшөөрөл, албан бичиг, баримтууд авах, хүргүүлэхэд тусалж, шаардлагатай бусад ажлуудад дэмжлэг үзүүлсэн МОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон-д чин сэтгэлийн талархал илэрхийлье.

БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

2.1. Салбарын тойм

Олборлох үйлдвэрлэл нь Монгол Улсын эдийн засгийн голлох салбар бөгөөд эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болсоор ирсэн. Уул уурхайн салбар нь 2022 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, экспортын орлогын 90 хувь, төсвийн орлогын 30 гаруй хувийг бүрдүүлсэн байна.

Мөн уг салбар нь аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн 57.7 хувийг, нийт борлуулалтын 66.7 хувийг эзэлдэг. Харин уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2022 онд 25.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.3 их наяд (26.6%) төгрөгөөр, нийт борлуулалт 44.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.7 их наяд (60.3%) төгрөг болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2.2. ОУИТБС-ын оролцоо

Монгол Улсын Засгийн газар нь 2005 оны 12 сард ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдэж, 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс ОУИТБС-ын нэр дэвшигчээр элссэн. Баталгаажуулалтыг амжилттай давснаар 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдөр бүрэн нийцсэнд тооцогдсон.

ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхэлснээс хойш Монгол Улс нь 16 удаагийн тайлан гаргасан. Энэхүү ОУИТБС-ын 17 дахь удаагийн тайлангийн зорилго нь тайлагналыг хялбаршуулж, цаг хугацааны хувьд уян хатан ил тод болгох, зардал багатайгаар, нүсэр бус төсөр байх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.

2.3. Тайлангийн цар хүрээ

Энэхүү тайлан нь олборлох салбар дахь дараах сэдвүүдийг хамарсан. Үүнд:

- Олборлох үйлдвэрлэлийн төлбөр, орлого
- Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого
- Олборлох үйлдвэрлэлийн зүгээс эдийн засагт оруулсан хувь нэмэр
- Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл болон экспорт
- Олборлох үйлдвэрлэл дахь төрийн оролцоо
- Тусгай зөвшөөрөл болон гэрээний ил тод байдал
- Ашигт малтмал, газрын тосны нөөцийн тойм
- Нийгмийн зардал болон байгаль орчны нөхөн сэргээлт
- Ашиг хүртэгч жинхэнэ эзэд

Мөн уул уурхайн салбарт Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлсөн талаарх мэдээллийг тодорхой сэдэв тус бүр дээр товч тоймлон оруулсан.

ОУИТБС-ын шаардлагуудын хэрэгжилт нь ТӨААН-үүдийн хувьд тодорхойгүй байна гэж баталгаажуулалт хийсэн өмнөх шинжээчдийн дүгнэлтэд тулгуурлан Стандартад шаардлагууд нэмэгдсэн. Стандартад ОТАХ нь жендерийн эрх тэгш тэнцвэртэй байдал болон нийгмийн оролцоог сайжруулахад хүчин чармайлт гаргаж, баримтжуулах шаардлагатай гэж заасны дагуу эрдэс баялгийн салбарт ажиллаж буй ажиллах хүчний мэдээлэлд жендерийн мэдээллийг оруулж, эмэгтэйчүүдийн оролцоо эрдэс баялгийн салбарт хэр байгааг харуулсан.

Түүнчлэн байгаль орчны асуудал нь байгалийн нөөцийн засаглалын чухал хэсэг тул олборлох салбарын байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа, байгаль орчны нөлөөллийн мониторинг, үнэлгээний үр дүнг тайланд тусгав.

Ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг ажлын даалгаварт заасны дагуу Хавсралт 20.6-д тусгасан болно.

ОҮИТБС-ын нэгтгэлд хамруулахаар ОТАХ-ийн баталсан алт, зэс, нүүрсний 104 компани (14 ТӨААН-ийг оруулаад)-ийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг түүнийг хүлээн авсан Засгийн газрын 26 байгууллагын (20 орон нутгийн байгууллагыг оруулаад) хүлээн авсан орлоготой харьцуулж, тохируулсан бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг энэхүү тайлангийн Бүлэг 4 болон Хавсралт 12, 13-т тусгасан.

2.4. Засгийн газрын нийт орлого

2.4.1. Нийт олборлох үйлдвэрлэлийн салбараас 2022 онд Засгийн газрын хүлээн авсан орлого

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 3,077 компани бүртгэлтэйгээс 2,043 компанид тусгай зөвшөөрөл олгожээ. Эдгээр 2,043 компаниас хүлээн авсан 5.5 их наяд төгрөг нэгтгэлд хамрагдсан 104 компаниас хүлээн авсан 5.3 их наяд төгрөгийг хүлээн авсан төрийн байгууллага тус бүрээр дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 1. Засгийн газрын хүлээн авсан орлого, байгууллагаар, сая төгрөгөөр

№	Засгийн газрын байгууллага	Засгийн газрын орлого			
		Олборлох салбарын бүх компани		Нэгтгэлд хамруулсан компаниуд	
		2021	2022	2021	2022
1	АМГТГ	1,566,651.70	174,656.7	1,522,449.1	147,348.0
2	ТЕГ	1,208,453.40	4,076,954.3	1,138,337.0	4,008,888.7
3	НДЕГ	356,170.60	438,159.0	301,148.0	394,528.6
4	ГЕГ	88,547.00	202,271.1	75,984.5	90,425.6
5	БОАЖЯ	1,407.90	5,155.7	384.1	3,505.4
6	Бусад	94,878.60	482,667.2	58,344.3	482,667.2
7	Орон нутаг	161,309.70	187,545.5	155,946.8	177,471.8
Нийт		3,477,418.90	5,567,409.5	3,252,593.8	5,304,835.1

2.4.2. Тохируулгын цар хүрээ

Цар хүрээг тодорхойлох шатанд ЗГ болон компаниудын зүгээс тайлагнасан урсгалуудыг тохируулах зорилгоор уян хатан тайлагналын хүрээнд ЗГ-ын хүлээн авсан орлого, тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нийт дүнд эзлэх хувь өндөр байгаа эсэхийг нь харгалзан үзэж сонгов. Сонголтыг хэрхэн хийсэн талаар 3.2-р бүлэгт тайлбарлав. Эдгээр сонгосон компаниудаас ЗГ-ын хүлээж авсан орлогыг тохируулгын дараах байдлаар, мөн салбарын хэмжээний нийт урсгалтай харьцуулж, цар хүрээг дараах хүснэгтэд харуулав.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас харна уу.

2.4.3. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга

Нэгтгэлийн явцад сонгогдсон компаниудтай холбоотойгоор ЗГ-ын анх тайлагнасан дүнгүүдийг тохируулж, тохируулгын дараах дүнтэй харьцуулж харууллаа.

Хүснэгт 2. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга, сая төгрөгөөр

Засгийн газрын байгууллага	Нэгтгэлд хамрагдсан компаниудын ЗГ-ын орлого								
	Тохируулгын өмнөх			Тохируулга			Тохируулгын дараах		
	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022
Ашигт малтмал, газрын тосны газар	8,178.0	1,529,689.4	140,872.8	1,365.0	-12,210.9	6,475.1	9,543.0	1,517,478.5	147,348.0
Татварын ерөнхий газар	1,885,497.0	1,134,329.5	3,919,766.4	63,302.0	10,987.0	89,122.3	1,948,799.0	1,145,316.5	4,008,888.7
Нийгмийн даатгалын ерөнхий газар	246,587.0	304,193.8	394,514.9	-24,764.0	-4,102.9	13.7	221,823.0	300,090.9	394,528.6
Гаалийн ерөнхий газар	158,105.0	73,599.1	90,425.6	-7,975.0	3,624.2	0.0	166,080.0	77,223.3	90,425.6
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	-	981.6	3,505.4	-	-639.5	0.0	-	342.1	3,505.4
Бусад	635.0	3,849.6	1,986.4	55,482.0	55,277.7	480,680.8	56,117.0	59,127.2	482,667.2
Орон нутаг	18,932.0	99,911.9	136,791.5	115,307.0	53,084.2	40,680.3	134,239.0	152,996.0	177,471.8
Нийт дүн	2,322,057.0	3,146,554.8	4,687,862.9	373,680.0	106,019.7	616,972.2	2,695,737.0	3,252,574.5	5,304,835.1

Компанийн дутуу тайлагнасан буюу алдаатай илгээсэн томоохон зөрүүнээс танилцуулбал:

Анхны нэгтгэлийн үед Засгийн газрын тайланд Өмнөговь, Сэлэнгэ, Дундговь, Увс аймаг, Багахангай, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн мэдээлэл дутуу зэрэг нь орон нутгийн зөрүүгийн дийлэнх хэсгийг эзэлж байлаа. Нийт 104 компаниас нийт 93 компани нь хувь хүний орлогын албан татварыг тайлагнаагүйгээс компани талаас мэдээлэл дутуу зөрүү үүсгэсэн. Мөн зарим компанийн өгсөн хандивын мэдээллийг ЗГ талаас бүртгэж аваагүй алдаа гарсан байна.

Компанийн дутуу тайлагнасан буюу алдаатай илгээсэн томоохон зөрүүнээс дурдвал:

- Нийт 104 компаниас нийт 93 компани нь хувь хүний орлогын албан татварыг тайлагнаагүйгээс компани талаас мэдээлэл дутуу зөрүү үүсгэсэн. Үүнд, Оюу толгой компани 68 тэрбум, Эрдэнэт үйлдвэр 41 тэрбум, Эрдэнэс таван толгой компани 7.8 тэрбум зэрэг дүнгүүдийг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
- Петровича Дачин Тамсаг компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлогын 133.9 тэрбум төгрөгийн дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
- Си Өү Эй Эл компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 24.5 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 59.3 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
- Шинь шинь ХХК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 23.3 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 41.8 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
- Хангад Эксплорейшн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 25 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
- Баян Айраг Эксплорейшн нэмэгдсэн өртгийн албан татвар болон ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг нэг орон алдаж 5 тэрбум төгрөгийн дүнгээр багаар тайлагнасан байсан.

Тохируулгын дэлгэрэнгүйг Бүлэг 4.2-оос үзнэ үү.

2.5. Нэгтгэлийн үр дүнгийн хураангуй

2.5.1. Засгийн газар ба компанийн урсгалуудын харьцуулалт, тохируулгын дараах байдлаар

Доорх хүснэгтэд Засгийн газар болон компаниудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн, зохих тохируулгуудыг хийснээр тохируулгын дараах үр дүнг нэгтгэн харуулав.

Хүснэгт 3. Засгийн газар, компанийн орлогын урсгалын тохируулга, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Дүн		
	2020	2021	2022
ЗГ-ын дүн(тохируулгын дараа)	2,695,737	3,252,574.5	5275365.6
Компанийн дүн(тохируулгын дараа)	2,696,264	3,252,593.8	5282472.2
Нийт зөрүү	-527	-19.3	-7106.6
Тохируулгын хүсэлтэд хариу ирүүлээгүй компани	545	-	9
Тайлбарлагдаагүй цэвэр зөрүү	18	-19.3	-7106.6
ЗГ компаниудаас илүү тайлагнасан	-860	6,778.90	136,725.1
ЗГ компаниудаас дутуу тайлагнасан	878	-6,798.20	(129,618.5)

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр, 136,725.1 сая төгрөгийн цэвэр зөрүү Хараат бус хянагч-нэгтгэгч нь ЗГ-ын тайланд 600,444.5 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга, компанийн дүнд 470,826.1 сая төгрөгийн хасагдах тохируулгыг хийснээр цэвэр зөрүүг 7,106.6 сая төгрөг хүртэл буурууллаа. 9 компани огт хариу ирүүлээгүй болно.

Өмнө онуудын нэгтгэл тайлангийн үр дүнг энэ жилийнхтэй харьцуулан дор харуулав.

Хүснэгт 4. 2018-2022 онуудын нэгтгэл тайлангийн үр дүн, сая төгрөгөөр

Топ татвар төлөгчид	2018	2019	2020	2021	2022	Нийт
Эрдэнэт	600,439	922,713	984,198	965,261	1,785,363.4	5,257,974.37
Оюу Толгой	466,940	520,320	532,245	916,185	589,259.7	3,024,949.73
Эрдэнэс Таван толгой	415,180	710,227	468,569	294,949	1,052,562.8	2,941,487.76
Петрочайна Дачин Тамсаг	283,319	273,161	-	7,970	139,439.2	703,889.20
Энержи Ресурс	-	221,988	182,244	50,975	308,384.7	763,591.69
Монголын Алт МАК	165,334	-	75,515	122,587	103,807.9	467,243.87
Тавантолгой	-	-	-	51,864	289,419.0	341,282.99
Топ татвар төлөгчийн нийт дүн	1,931,212	2,648,409	2,242,771	2,409,791	4,268,236.6	13,500,419.61
Өсөлтийн хувь	18%	27%	-13%	7%	77%	-
Олборлох салбарын нийт орлого	2,817,019	3,722,505	3,211,790	3,466,680	4,841,234	-
Өсөлтийн хувь	-	24%	-16%	7%	39%	-

2.5.2. Олборлох салбарын орлогын хураангуй

Компанийн тайлагнасан төлбөрийн мэдээг Засгийн газрын тайлагнасан орлогын дүнтэй тохируулсны дараа шинжилж үзэхэд 2022 онд олборлох үйлдвэрлэлийн нийт компаниудын төлбөрийн 91.7 хувь (2021 онд 80.9%)-ийг топ 10 компани, Засгийн газар хүлээж авсан орлогын 87.1 хувь (2021 онд 89.9%)-ийг топ 20 компанийн төлсөн төлбөр бүрдүүлсэн байна. Өмнө жилийн үзүүлэлттэй харьцуулахад топ татвар төлөгчдийн үзүүлэлт өссөн байгаа нь 2022 онд тус салбар дахь Ковид-19 цар тахлын нөлөө багасаж эдийн засаг сэргэх хандлагатай байгааг илтгэж байна.

Хүснэгт 5. Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас топ 20 компанийн төлбөр, сая төгрөгөөр, хувиар

№	РД	Компани	Дүн	Дүнд эзлэх хувь
1	2074192	Эрдэнэт	1,790,187.1	35.8
2	5435528	Эрдэнэс Таван толгой	1,038,597.3	20.8
3	2657457	Оюу Толгой	592,606.8	11.8
4	2887746	Энержи Ресурс	289,252.1	5.8
5	2016656	Тавантолгой	283,199.6	5.7
6	2075385	Петрочайна Дачин Тамсаг	164,890.6	3.3
7	5141583	МоЭнКо	116,000.6	2.3
8	5261198	Си Өү Эй Эл	107,659.5	2.2
9	2095025	Монголын Алт МАК	105,491.2	2.1
10	2548747	Цайртминерал	102,334.6	2.0
11	2830213	Шинь шинь ХХК /ГХО/	79,101.9	1.6
12	5084555	Саусгоби Сэндс	62,944.7	1.3
13	2094533	Бороо Гоулд	57,231.6	1.1

№	РД	Компани	Дүн	Дүнд эзлэх хувь
14	2855119	Болдтөмөр Ерөө гол	42,846.7	0.9
15	2697947	ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ	34,129.6	0.7
16	5199077	ӨСӨХ ЗООС	30,472.5	0.6
17	2887134	Хангад Эксплорейшн	29,273.3	0.6
18	5830974	МАК Цемент	26,069.9	0.5
19	2641984	Цементшохой ТӨХК	25,548.9	0.5
20	2008572	Багануур	25,533.2	0.5
21	Бусад 84 компани		279100.2	5.3

МОУИТБС-ын 2022 оны буюу 17 дугаар энэхүү нэгтгэл тайланг боловсруулах эхлэлийн тайлангийн хурлын үеэр Төлсөн авснаа нийтэл (ТАН) эвсэл, Нээлттэй нийгэм форум, Ховдын толь, хил хязгааргүй алхам зэрэг холбогдох 9 төрийн бус байгууллагуудаас нэгтгэл тайланд оролцуулах хүсэлтэй байгаа ААН-үүдийн санал авахад давхардсан тоогоор 12 ААН-ийн санал ирүүлсэн ба 3 ААН нь ТОП-20 татвар төлөгчид байсан тул холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5-д харуулсан болно

Үлдсэн 9 ААН-ийн дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 6. ТББ-ын санал болгож нэгтгэл тайланд хамруулсан ААН-ын төлбөр, сая төгрөгөөр

№	Регистрийн дугаар	Компанийн нэр	Дүн	Дүнд эзлэх хувь	Нийт нэгтгэлд эзлэх хувь
1	2807459	Төфис майнинг	6,255.0	76%	0.118%
2	5774047	Талстмолор	495.0	6%	0.009%
3	4065115	Вестернхолд ХХК	296.6	4%	0.006%
4	5369223	Биг Могул Коул Энд Энержи	1,069.3	13%	0.020%
5	5095638	Болд фо ар да	69.3	1%	0.001%
6	5493781	Элбэг Орд	26.4	0%	0.001%
7	5364884	Хорикаваметал	-	0%	0.000%
8	5938953	Будар минералс	-	0%	0.000%
9	5185874	Геопро монгол	-	0%	0.000%

Мөн нэгтгэл тайланд хамруулсан 104 ААН-ээс хамгийн бага татвар төлсөн 20 ААН-ийн татвар төлсөн байдлыг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар харууллаа.

Хүснэгт 7. Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас хамгийн бага татвар төлсөн 20 ААН-ын төлбөр, сая төгрөгөөр хувиар

№	Регистрийн дугаар	Компанийн нэр	Дүн	Дүнд эзлэх хувь	Нийт нэгтгэлд эзлэх хувь
1	5467268	Инфинити спэйс	1,369.3	11%	0.026%
2	5482046	Цэцэнс Майнинг энд Энержи	1,185.5	9%	0.022%
3	5452503	Эм Эл Цахиурт Овоо	1,036.5	8%	0.020%
4	5098297	Зонхэнютиан	-	0%	0.000%
5	2801299	БМНС	1,501.9	12%	0.028%
6	5097282	Фийлдсаплай	72.9	1%	0.001%
7	5073189	ИЛТ ГОУЛД	821.4	6%	0.016%
8	5197325	Шанжин-Орд ХХК /ГХО/	53.9	0%	0.001%
9	5513618	Тахь Ресурс	871.0	7%	0.016%
10	5906865	Баянгол эко заамар	735.4	6%	0.014%
11	2867095	Петро Матад	776.0	6%	0.015%
12	2057573	Макс Импэкс	870.8	7%	0.016%
13	2003821	Эрчимбаян өлгий ХК	856.8	7%	0.016%
14	6192939	Батбродерс Майнинг	516.5	4%	0.010%

№	Регистрийн дугаар	Компанийн нэр	Дүн	Дүнд эзлэх хувь	Нийт нэгтгэлд эзлэх хувь
15	5396786	Ирмүүн босго	1,123.5	9%	0.021%
16	2661128	Хотгор	689.9	5%	0.013%
17	5898749	Эм Жи Жи И Си	358.7	3%	0.007%
18	5118344	Алтайн Хар Азарга групп	124.7	1%	0.002%
19	5097517	Азаргын гол чонот	7.3	0%	0.000%
20	5722616	Жамц Давс	22.1	0%	0.000%

Компаниудаас ирүүлсэн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 10-д харуулав.

2.6. Мэдээллийн үнэн зөв байдал

ОУИТБС-ын тайлан гаргаж буй төрийн байгууллагууд, төрийн болон хувийн компаниудын тайлангаа баталгаажуулсан байдал, олон улсын стандартын дагуу хариуцлагатай хараат бус аудитораар баталгаажуулсан эсэхэд үнэлгээ хийв.

Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас 31 нь ил тод байдлын тайланг баталгаажуулж, удирдлагын хариуцлагын захидал илгээсэн бол 73 компани илгээгээгүй байна.

Өмнөх нэгтгэлүүдийн үед компаниудаас аудитлагдсан санхүүгийн тайланг шаардаж авдаг байсан боловч компаниудын аудитлагдсан санхүүгийн тайлангаас ОУИТБС-д тайлагнасан мэдээллийг аудитлагдсан санхүүгийн тайланг голлон ашиглаж байна. Учир нь санхүүгийн тайлан аккрузал суурийн дагуу бэлтгэгддэг бол ОУИТБС-ын тайлан мөнгөн сууриар бэлтгэгддэг. Доорх хүснэгтээр нэгтгэлд хамрагдсан 104 компанийн мэдээлэл ирүүлэлтийг харуулсан бөгөөд аудитын тайланг 63 компани, нөхөн сэргээлтийн мэдээллийг 40 компани, удирдлагын захидлыг 31 компани ирүүлсэн байна. Эдгээр компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-с үзнэ үү.

Хүснэгт 8. Компаниудын мэдээлэл ирүүлэлт

Мэдээ ирүүлсэн эсэх	Нэгтгэлийн залруулгын маягт		Нөхөн сэргээлтийн мэдээлэл		Аудитын тайлан		Удирдлагын захидал	
	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
Ирүүлсэн	63	95	51	40	45	63	42	31
Ирүүлээгүй байгаа	0	9	12	64	18	41	21	73
Нийт	63	104	63	104	63	104	63	104

Арван зургаа дугаар нэгтгэл тайланд нийт 63 ААН хамрагдаж байсан бол арван долоодугаар нэгтгэл тайланд 104 ААН нэгж байгууллага хамруулсан. 2021 оны ААН-үүдийн мэдээлэл ирүүлэлт 100 хувьтай байсан бол энэ жилийн нэгтгэл тайланд 9 ААН мэдээлэл ирүүлээгүй бөгөөд 91.3 хувьтай нэгтгэл тайланд хамрагдсан байна.

2.7. Мэдээллийн чанар, тайлангийн баталгаажуулалтын талаар

ОУИТБС-ын стандартад өгөгдөл мэдээллийн чанарын асуудлыг чухлаар авч үздэг ба цаашид ЗГ болон компаниуд мэдээллээ системтэйгээр тайлагнах, Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хийх тохируулгын хэрэгцээг багасгах, мэдээллийн араас шалгахаас зайлсхийх олон улсын жишгийг дагаж мөрдөхийг зорьж байгаа юм.

Төрийн байгууллагууд, ТӨААН-үүд болон компаниуд нь цахим тайланд тайлагнасан төлбөр орлогын мэдээлэл болон нэмэлтээр ирүүлсэн мэдээллээ үнэн зөв гэдгийг

баталгаажуулж, Удирдлагын хариуцлагын захидал ирүүлж байгаа боловч тайлангууд аль аль талдаа алдаатай байгаа нь нэгтгэлээс харагдаж байна.

Иймд ОУИТБС-ийн тайланг буруу тайлагнасан оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлэх, шаардлага 4.9-д заасны дагуу төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллагаар ил тодын тайланг нь баталгаажуулахад анхаарч ажиллах хэрэгтэй байна.

2.7.1. Тайлан тушаалт, хариу ирүүлэлтийн байдал

ОУИТБС-ын 2022 оны тайланд зарим орон нутгийн байгууллагууд цахим тайлангийн системд хүлээн авсан татвар, төлбөрийн мэдээг оруулаагүй нь нэлээд өндөр зөрүүг үзүүлж байсан бөгөөд нэгтгэлийн явцад тайланд шаардлагатай мэдээллээ шинээр бүрдүүлэх тохиолдол цөөнгүй байсан нь нэгтгэлд хийхэд хүндрэл үүсгэж байсан. Компани талаас тайланд хамрагдсан бүх газар тодруулгад хариу ирүүлж хамтран ажилласан бол төрийн байгууллага талаас БОАЖЯ хариу ирүүлээгүй болно. ОУИТБС-ын стандартын дагуу шаардлагатай мэдээллийг хүсэж нийт 26 яам, төрийн байгууллага руу албан бичиг явуулснаас БОАЖЯ болон УУХҮЯ-аас бусад газрууд хариу ирүүлж холбогдох мэдээллийг өгсөн.

Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил бүрийн нэгтгэлийн тайланд зөвлөмж өгдөг боловч ахиц харагдахгүй байгаа талаар өмнөх 16-р тайланд дурдсан байсан. Энэ жилийн тайлангийн үр дүнд ч ахиц гараагүй байна. Засгийн газар болон компаниуд алдаатай тайлагнах, дутуу тайлагнах алдаа түгээмэл байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарахгүй байна. Энэ нь уг тайлангийн ач холбогдлыг бууруулж байна.

Нийт 25 төрлийн мэдээллийг компаниуд шинэ маягтаар цахим тайланд оруулах ёстой. Цахим тайлангийн системд эдгээр мэдээллийг маягтаар оруулсан бөгөөд бүх маягт тодорхой хэмжээнд бөглөгдсөн байна. Маягтуудын мэдээлэлд доорх алдаа илэрч байна. Үүнд:

- Мэдээлэл оруулаагүй
- Өөр мэдээлэл оруулсан
- Хэмжих нэгж тодорхойгүй
- Тоон утгуудын орон нарийвчлал зөрүүтэй
- Мэдээллийг давхардуулан оруулсан

Дээрх алдаанаас шалтгаалан дутуу боловсруулагдсан мэдээллийг олон нийтэд хүргэх, цаашлаад тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэл үүсч байгаа учраас мэдээллийг хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох үүрэгтэй. Дараагийн хүснэгтээр маягтаар цуглуулсан мэдээллийг ирцийг харуулсан бөгөөд өмнө жилүүдтэй харьцуулахад мэдээллээ ирүүлсэн компанийн тоо нэмэгдэж байгаа нь сайшаалтай байна.

Хүснэгт 9. Маягтаар цуглуулсан мэдээлэл, ААНБ-ын тоо, оноор

№	Мэдээллүүд	2019	2020	2021	2022
1	Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл	556	1133	1105	818
2	Ажиллагчдын мэдээлэл	-	548	600	443
3	Ашигласан усны мэдээлэл	-	227	224	185

№	Мэдээллүүд	2019	2020	2021	2022
4	Ашигт малтмалын бүтээгдэхүүн олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл	76	220	237	187
5	Ашигласан эрчим хүч, түлш шатахуун, хүнсний бүтээгдэхүүн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтээгдэхүүний мэдээлэл	73	200	200	535
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар мэдээлэл	-	-	2	-
7	Байгууллагад өгсөн хандив дэмжлэг	93	204	238	254
8	Баяжуулах үйлдвэрлэл эрхлэгч ААНБ-уудын ашигласан химийн бодисын мэдээлэл	24	71	60	181
9	Газрын тосны олборлолт, борлуулалтын мэдээлэл	-	1	2	-
10	Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт болон бартерын гэрээ	-	38	34	73
11	Нөөцийн мэдээлэл	-	292	300	215
12	Нөлөөллийн бүсийн мэдээлэл	54	129	134	214
13	Нөхөн сэргээсэн талбайн мэдээлэл	-	248	254	204
14	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр хураамж ногдол ашиг	-	333	355	331
15	Орон нутгийн захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээний мэдээлэл	-	130	144	159
16	Оператор, туслан гүйцэтгэгч ААНБ-ын мэдээлэл	-	111	103	252
17	Санхүүгийн тайлангийн чанар	342	456	719	552
18	Төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-уудын ногдол ашгийн мэдээлэл	23	63	55	70
19	Төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-уудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл	13	39	38	87
20	Төслийн түвшний мэдээлэл	247	141	134	111
21	Төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-ын зээл болон зээлийн мэдээлэл	10	37	38	31
22	Төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-ын тээврийн төлбөр	21	-	58	33
23	Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр хураамж, ногдол ашиг	403	1046	1060	800
24	Хог хаягдлын мэдээлэл	-	232	227	205
25	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл	335	893	733	598

2.7.2. Төрийн оролцоо, шаардлагыг ил тод болгох

ОУИТБС-ын стандартын дагуу ТӨБЗГ-с дараах мэдээллүүдийг хүссэн:

- Төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын хоорондын харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчны мэдээлэл
- Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан дүрэм журмын талаарх мэдээлэл
- 2022 онд олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит аж ахуйн нэгжийн эзэмшилд гарсан өөрчлөлтүүд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төрд ногдох хэсгийг хувьчилсан байдлын талаарх мэдээлэл
- 2022 онд олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг нийт төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс хүлээн авсан ногдол ашгийн мэдээлэл
- Засгийн газраас Хөгжлийн банкаар дамжуулан уул уурхай, газрын тосны төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл, гаргасан баталгааны талаарх мэдээлэл
- Төрийн өмчит ААН-ийн төрийн оролцоо, бодлогын өөрчлөлтүүдийн мэдээлэл
- Төрийн өмчит ААН оператор, туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл, тэдгээртэй байгуулсан гэрээ

- Компанийн ногдол ашиг тооцох, хуваарилах аргачлал, дүрэм журам, түүний хэрэгжилт, 2022 онд олгосон болон зарласан ногдол ашгийн дүнгийн мэдээлэл
- Олборлох салбарын компаниудад олгосон ямар нэгэн зээл, түүний үлдэгдэл эсвэл гаргасан зээлийн баталгаа бий юу?
- Төрийн өмчит ААН-ийн засаглах удирдлага, бүтэц, зохион байгуулалт, өмчлөл, засаглалын талаарх мэдээлэл
- Төрийн өмчит ААН-ийн өмчлөлийн бүтцэд 2022 онд гарсан өөрчлөлтүүдийн зураглал, тэдгээртэй холбоотой шийдвэрүүд
- 2022 онд төрөөс олборлох салбарын төрийн өмчит ААН-д өгсөн татаас, хөрөнгө оруулалтын мэдээлэл
- 2022 онд төрийн өмчит ААН-ээс өөр компанид хувьцаагаар хөрөнгө оруулалт хийсэн эсэх талаарх мэдээлэл
- 2022 онд олборлох салбарын төрийн өмчит ААН нь гуравдагч тал /гадаад болон дотоодын ААН/-аас авсан татаас, хөрөнгө оруулалтын мэдээлэл
- Төрийн өмчит ААН-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилох үйл явц, тавих шаардлага, түүнтэй холбоотой дүрэм журмын талаарх мэдээлэл

ТӨБЗГ-аас ТӨААН-үүдийн ТУЗ-ийн гишүүд болон сонгон шалгаруулалтын мэдээлэл, хамаарах хууль тогтоомж, ЗГ болон ТӨААН-ын хоорондын санхүүгийн харилцаа, 2022 онд төрөөс олборлох салбарын төрийн өмчит ААН-д өгсөн татаас, хөрөнгө оруулалтын мэдээлэл зэргийг бидэнд ирүүлсэн. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу ТӨААН-үүд нь Санхүүгийн байдлын тайлан, Дэлгэрэнгүй орлогын тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах ёстой байдаг.

ҮАГ, шилэн дансны цахим хуудас болон ТӨААН-үүдийн цахим хуудсанд ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дараах мэдээллүүд нийтлэгдсэн байдаг.

- Санхүүгийн байдлын тайлан,
- Дэлгэрэнгүй орлогын тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Аудитын дүгнэлт.

БҮЛЭГ 3. ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

3.1. Танилцуулга

“Эс Ай Си Эй” ХХК болон “Гроут Финанс Аудит” ХК-ын хамтарсан баг нь нэгтгэл тайланг гэрээт ажлын даалгаварт тодорхойлсон шаардлагын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Энэхүү нэгтгэлээр олборлох салбарын компаниудын төлсөн төлбөрийг, ЗГ-ын хүлээн авсан орлоготой тохируулах ажил хийдэг бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлэгт оруулсан болно. Тохируулгыг хийхдээ мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан гүйцэтгэв.

Хэрэв цахим тайлагналын системд төлсөн болон хүлээн авсан байгууллагуудын аль аль нь материаллаг хэмжээний төлбөр эсвэл орлого орхигдуулсан бол бидний ажил эдгээрийг шийдэх бололцоогүй бөгөөд энэ нь тайланд орохгүй байх эрсдэлтэй юм. Харин ЗГ болон компанийн аль нэг нь тайлагнасан бол нөгөө талын орхигдсон мэдээллийг олж авч, нэгтгэлд хамруулах бүрэн боломжтой. Үүнээс бусад тохиолдолд тэдгээр орхигдсон төлбөр, орлогын мэдээллүүд бидний тайланд багтаагүй болно.

Бид тайлагнагч байгууллагуудаас бөглөж ирүүлсэн маягт, мэдээлэл ба тэднээс өгсөн тайлбарт үндэслэн нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн ба тоо мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд аудит хийгээгүй бөгөөд энэхүү ажлыг гүйцэтгэх явцад тайлагнагч байгууллагуудаас хүлээн авсан тайлбар, мэдээлэл үнэн зөв гэдэгт бид найдаж байна.

3.2. Мэдээллийн хамрах хүрээг тодорхойлох нь

3.2.1. Танилцуулга

Монгол Улсын ОУИТБС-ын 2022 оны 17 дугаар нэгтгэл тайланд хамрагдах ААН-ын цар хүрээг тодорхойлохдоо ОТАХ-тэй хамтран дараах асуудлуудыг харгалзаж үзсэн. Үүнд:

- Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,
- Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий санхүүгийн урсгалуудыг тодорхойлох,
- Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд.

3.2.2. Мэдээллийн хамрах хүрээг тодорхойлох ба Эхлэлийн тайлан

Эхлэлийн шатанд ОУИТБС-ын 2022 оны тайланд шаардагдах агуулгын талаарх мэдээлэл, ажлын даалгаврын Хүснэгт 1-т орсон шаардлагууд, цахим тайлагналын иж бүрэн байдлыг хянасан. Түүнчлэн тайланд хамрагдах компани, төрийн байгууллагууд, төлбөр орлогын урсгалуудыг тодорхойлох, оролцогч талуудын системтэйгээр ил тод болгосон байдал зэргийг нягталж, мэдээллийг тодруулах ажлуудыг зохион байгуулсан.

Эхлэлийн үе шатны зорилго нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын хамрах хүрээг зөв тодорхойлох, тайлагнах маягтууд, мэдээлэл цуглуулах үйл явц, ОУИТБС-ын тайлан боловсруулах, эцэслэх, хэвлэх хуваарь зэргийг баталгаажуулах явдал юм.

2023 оны 10 дугаар сарын 03-нд зохион байгуулсан ОТАХ-ийн гишүүдийг хамруулсан эхлэлийн тайлангийн хурлаар 2022 оны ОУИТБС-ын тайлангийн агуулга, цар хүрээг тогтоосон байдал болон материаллаг хэмжээний төлбөр, орлогын үзүүлэлтүүдийг авч хэлэлцсэн. Энэхүү семинарын үеэр оролцогч талуудаас гарсан саналыг тусгаж, ТББ-аас хамруулах хүсэлтэй байгаа 12 аж ахуйн нэгжийн саналыг авч, ОУИТБС-ын 2022 оны тайлангийн хамрах хүрээг ОТАХ-ийн гишүүд баталсан.

3.2.3. Төлбөр орлогын бодит байдал (Материаллаг байдал)

Олборлох үйлдвэрлэлээс Засгийн газрын хүлээн авсан төлбөр, орлогын урсгалын мэдээллийг ашиглан төлбөр орлогын бодит байдал (материаллаг байдал) тодорхойлсон. Энэхүү мэдээллийг шинжилж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 10. Засгийн газрын тайлагнасан орлого болон компанийн тоо, сая төгрөгөөр

№	Ангилал	Компанийн тоо		ЗГ-ын тайлагнасан дүн тэрбум.төгрөг		Дүнд эзлэх хувь	
		2021	2022	2021	2022	2021	2022
1	100 тэрбум дээш	8	9	2,886.9	3,947.6	77.2	81.5
2	1 тэрбум-100 тэрбум	79	85	750.7	794.2	20.1	16.4
3	500 сая-1 тэрбум	51	56	37.3	39.4	1.0	0.8
4	300сая-500 сая	43	57	16.5	22.0	0.4	0.4
5	300 сая хүртэл	1,922	977	47.2	37.8	1.3	0.7
Нийт		2,103	1,184	3,738.7	4,841.2	100	100

Төлбөр орлогын бодит байдлыг (материаллаг байдал) тооцохдоо ЗГ-ын тайланд тусгагдсан нийт төлбөр, орлогын дүнгийн 98%-аас дээш төлбөр, орлогыг заавал хамруулна гэсэн шалгуураар тооцох үндсэн зарчмыг баримталсан.

Үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус компаниудын төлбөр, орлогын дүнг нийт Засгийн газрын тайлагнасан дүнгээс хасаж, дээр дурдсан аргачлалын дагуу буюу 300 сая төгрөгөөс дээш орлогын дүнтэй компаниудыг сонгоход нийт төлбөр, орлогын 98.7 хувийг хамрахаар байна.

ОУИТБС-ын тайланд хамрагдах төлбөр, орлогын материаллаг байдлыг эхлэлийн семинараар хэлэлцэж ОТАХ зөвшөөрсөн ба ТББ-ын саналаар 12 компанийг нэмсэн. Ингэхдээ алт, зэс, нүүрсний үйл ажиллагаа эрхлэгч 74 компанийг нэн түрүүнд сонгож, нэмэлтээр бусад үйл ажиллагаа эрхлэгч 18 компани,ТББ-ын саналаар 12 компани буюу нийт 104 компанийг сонгосон.

3.2.4. Тайланд хамруулах компаниудын сонголт

Улсын түвшний нийт 24 төрлийн татвар төлбөр, орон нутгийн түвшний 16 төрлийн татвар, төлбөр, хураамжийг компаниуд төлж, ЗГ хүлээн авсан байна. 2022 оны нэгтгэлийн тайланд бүх төрлийн төлбөр, орлогын урсгалыг ямар нэгэн босго тавилгүй нийтэд нь хамруулж, зөрүүг тохируулахаар шийдвэрлэсэн.

Орлогын төвлөрөлтэй холбоотой ОУИТБС-ын шаардлагын 4.1-д татвар болон орлогыг цогцоор нь ил тод болгох, 4.5-д Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ, 4.6-д орон нутгийн төлбөрийг ил тод болгохыг шаарддаг.

Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, татварыг тохируулгын өмнөх болон дараах байдалтай харьцуулахад зөрүү нь 5.2 хувь байлаа.

Хүснэгт 11. Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, орлого, сая төгрөгөөр

№	Төрийн байгууллагууд	Дүн	Дүнд эзлэх хувь
1	Ашигт малтмал, газрын тосны газар	174,656.7	3.1
2	Татварын ерөнхий газар	4,076,954.3	73.2
3	Нийгмийн даатгалын ерөнхий газар	438,159.0	7.9
4	Гаалийн ерөнхий газар	202,271.1	3.6
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	5,155.7	0.1
6	Бусад	482,667.2	8.7
7	Орон нутаг	187,545.5	3.4
Нийт		5,567,409.5	-

ОУИТБС-ын тайланд хамрагдах компаниудын төлбөр, орлого, материаллаг байдлыг харгалзан нэгтгэлд хамруулахаар 104 компанийн жагсаалтыг эхлэлийн семинар дээр хэлэлцэж, ТББ-ын зүгээс 12 компанийг санал болгож эцэслэсэн. Уг санал болгосон компаниудын “Геопро монгол”, “Хорикаваметал” компаниудыг тайланд хамруулахаар сонгосон боловч тусгай зөвшөөрөл эзэмшдэг ч үйл ажиллагаа огт явуулаагүй, ямар нэгэн татвар төлбөр хураамж төлөөгүй тул нийтдээ 102 компани нэгтгэл тайланд хамрагдсан.

Зураг 1. Нэгтгэл тайланд хамруулсан компаниудын үйл ажиллагааны чиглэл



Мөн нэгтгэлд хамрагдсан ТОП 7 татвар төлөгчдийн ЗГ-т төлсөн төлбөрийг дараагийн хүснэгтээр дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 12. ТОП татвар төлөгчдөөс хүлээн авсан орлого, оноор

Топ татвар төлөгчид	2018	2019	2020	2021	2022	Нийт
Эрдэнэт	600,439	922,713	984,198	965,261	1,785,363.4	5,257,974.37
Оюу Толгой	466,940	520,320	532,245	916,185	589,259.7	3,024,949.73
Эрдэнэс Таван толгой	415,180	710,227	468,569	294,949	1,052,562.8	2,941,487.76
Петрочайна Дачин Тамсаг	283,319	273,161	-	7,970	139,439.2	703,889.20
Энержи Ресурс	-	221,988	182,244	50,975	308,384.7	763,591.69
Монголын Алт МАК	165,334	-	75,515	122,587	103,807.9	467,243.87
Тавантолгой	-	-	-	51,864	289,419.0	341,282.99
Топ татвар төлөгчийн нийт дүн	1,931,212	2,648,409	2,242,771	2,409,791	4,268,236.6	13,500,419.61
Өсөлтийн хувь	18%	27%	-13%	7%	77%	
Олборлох салбарын нийт орлого	2,817,019	3,722,505	3,211,790	3,466,680	4,841,234	

Топ татвар төлөгчид	2018	2019	2020	2021	2022	Нийт
Өсөлтийн хувь		24%	-16%	7%	39%	

Дараах зургаас ТОП татвар төлөгчдийн төлсөн нийт татвар, төлбөрийн дүнгээс шалтгаалан олборлох салбарын жилийн нийт орлого хэлбэлзэж байгааг харах боломжтой байна.

График 1. ТОП татвар төлөгчдөөс хүлээн авсан орлого, оноор



Олборлох үйлдвэрлэлийн салбарын нийт орлого нь топ татвар төлөгч 7 компанийн үйл ажиллагааны шууд хамаарч байна. Топ татвар төлөгч 7 компаниуд сүүлийн 5 жилд нийт 13.5 их наяд төгрөгийн татварыг улсад төлсөн байна.


3.3. Аргачлал

3.3.1. Мэдээллийн цуглуулалт

Хараат бус хянагч-нэгтгэгч нь МОҮИТБС-ын цахим тайлагналын системийг ашиглан төлбөр орлогын мэдээлэл болон орлогын бус мэдээллийг цуглуулсан ба анхны зөрүүг тодруулсан. Сонгогдсон компаниудаас анхны зөрүүгийн шалтгааныг тодруулсан нэмэлт мэдээлэл, нөхөн сэргээлтийн мэдээлэл, 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайлангийн материалыг цуглуулсан ба эдгээр мэдээлэл нь үнэн зөв гэсэн баталгаа болох Удирдлагын хариуцлагын захидлыг гаргуулан авсан.

Цахим тайлангийн систем дэх талуудын оролцооны байдлыг харуулбал дараах байдалтай байна.

Зураг 2. Цахим тайлангийн систем дэх талуудын оролцоо



3.3.2. 2022 оны нэгтгэлд ашигласан маягтууд

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сард хуралдсан 18 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу ажлын албанаас ОУИТБС-ын компанийн тайлагналын маягтыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Холбогдох техникийн ажлын хэсгийг ҮСХ, АТГ, АМГТГ, Эрдэнэт үйлдвэр, Нүүрс ассоциаци, Хил хязгааргүй алхам, Захиргааны шинэ санаачилга, Трансперенси Интернейшнл Монгол ТББ-ын төлөөллөөр байгуулж, ОУИТБС-ын шинэ стандарт болон Монгол Улсын өөрийн онцлог шаардлагад үндэслэн шинэчилж, зарим маягтыг шинээр боловсруулсан байна.

Шинэ маягтыг ҮСХ-ны зөвшөөрснөөр УУХҮЯ-ны сайдын 2020 оны 3 дугаар сарын 5-ны А/37 тоот тушаалаар баталсан. Уг маягтуудын дагуу бидний нэгтгэл тайлангийн мэдээллүүд цугларч, шинжилгээ хийгдсэн.

3.3.3. Задаргааны төвшин

ОУИТБС-ын стандарт 4.7-д “Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд ямар төвшинд хүртэл задлах боломжтой байх асуудлыг зөвшилцөх шаардлагатай. ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь дэлгэн харуулах боломжтой байх ёстой” гэж заасан байна.

3.4. Баталгаажуулалт

3.4.1. Монгол Улсын аудит, баталгаажуулалтын орчин нөхцөл

Монгол Улсын төрийн аудитын ажиллагааг хэрэгжүүлэх дээд байгууллага нь Үндэсний Аудитын газар юм. Үндэсний аудитын газар нь олон улсын аудитын ИНТОСАЙ байгууллагын гишүүн бөгөөд тус байгууллагын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь яам, агентлагууд болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлан болон ЗГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж улмаар УИХ-аар батлуулдаг. Орон нутгийн төрийн байгууллагууд (аймаг, сумд) санхүүгийн тайлангаа жил тутам гаргаж, ҮАГ-н харьяа орон нутгийн аудитын байгууллагаар аудит хийлгэдэг.

Төрийн өмчит компаниудын хувь жил тутмын санхүүгийн тайланд аудит хийх ажиллагааг Үндэсний Аудитын газар хариуцдаг ба аудитыг гүйцэтгүүлэхийн тулд зохих хэмжээний туршлага, чадвартай хөндлөнгийн аудитын байгууллагуудыг сонгон шалгаруулах журмаар томилж ажиллуулахыг зөвшөөрдөг. Тэдгээр аудитын байгууллагууд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (АДБОУС) болон АОУС-ын дагуу аудитын ажлыг гүйцэтгэж байна.

3.4.2. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц

Олборлох үйлдвэрлэлийн салбараас орлого хүлээн авсан Засгийн газрын байгууллагууд, татвар, хураамж төлсөн ТӨААН-үүд болон компаниуд өөрсдийн мэдээллийг цахим тайлангийн системд жил бүр оруулах шаардлагатай байдаг. ОУИТБС-ын стандартын дагуу ил тод болох нэмэлт мэдээллийг шаардлагатай тохиолдолд хараат бус хянагч-нэгтгэгчид өгч байх ёстой. Тайлагнаж буй тоо мэдээний үнэн бодит, найдвартай байдлыг тайлагнагч байгууллага хариуцна.

Үндэсний Аудитын газраас баталсан санхүүгийн тайланд аудит хийх журамд “Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийг ОУИТБС-ын Ажлын алба болон орлого хүлээн авсан Засгийн газрын байгууллагуудтай тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах” үүрэгтэй байсан боловч эдгээр ажил өмнөх жилүүдэд хийгдэж байгаагүй байна. Өмнөх жилүүдэд тайлан гаргаж байгаа компаниудын гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн тайлан, мэдээлэлд ТУЗ-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баталгааг бичгээр гаргаж өгөхийг, мөн компани бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг цахим тайлангийн системээр мэдээлж байхыг ОТАХ-тай тохиролцсон байсны дагуу энэ жил адил зохион байгуулагдсан.

БҮЛЭГ 4. ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Энэхүү бүлэгт нэгтгэлд хийсэн тохируулга бол тохируулгын дараах үр дүнг дэлгэрэнгүй задалж тайлбарлана.

4.1. Анхлан тайлагнасан урсгалуудын хураангуй

Тайлангийн эхний нэгтгэлээр ЗГ-ын хүлээн авсан орлого болон компанийн тайлагнасан төлбөрийн зөрүү 136,725.1 сая төгрөг байсан. Нэгтгэлийн явцад ЗГ-ын талд 600,444.5 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга, компанийн талд 470,826.1 сая төгрөгийн хасагдаж тохируулга хийснээр зөрүүг 7,106.6 сая хүртэл буурууллаа.

Хүснэгт 13. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр

Зөрүүгийн тохируулга	Засгийн газар	Компани	Зөрүү
Залруулахаас өмнөх	4,674,921.1	4,811,646.1	-136,725.1
Залруулгын дүн	600,444.5	470,826.1	129,618.5
Нийт залруулгын дараах дүн	5,275,365.6	5,282,472.2	-7,106.6

Сонгогдсон 104 компанийн 14 нь төрийн өмчит, 90 нь хувийн компани байна. Анхлан тайлагнасан төлбөр, орлого болон нэгтгэлийн тохируулгыг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр

Тайлан гаргагч	Компанийн тоо	Улсын хэмжээнд	Орон нутгийн хэмжээнд	Нийт
Анхны тайлан				
ЗГ-н байгууллага, орлого	104	4,547,566.1	127,355.0	4,674,921.1
Хувийн компаниуд, Төлбөрүүд	90	3,181,848.1	109,076.9	3,290,925.0
ТӨААН-үүд, Төлбөрүүд	14	1,365,718.0	18,278.1	1,383,996.0
Анхны нэгтгэлийн зөрүү		-91,646.9	-45,078.1	-136,725.1
Нэгтгэл				
ЗГ-н тохируулга		576,291.9	24,152.7	600,444.5
Компанийн тохируулга		488,137.3	-17,311.2	470,826.1
ЗГ-н дүн тохируулгын дараа		5,123,858.0	151,507.6	5,275,365.6
Компанийн дүн тохируулгын дараа		5,127,350.3	155,121.9	5,282,472.2
Эцсийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү		-3,492.3	-3,614.3	-7,106.6

Тохируулаагүй үлдсэн зөрүүг компани тус бүрээр Хавсралт 10-с харна уу.

4.2. Анхны тохируулаагүй зөрүү болон тайлагнаагүй компаниуд

Анхны нэгтгэлийн зөрүү нь дараах хүснэгтэд үзүүлсэн үндсэн шалтгаануудаас үүдэж байна.

Хүснэгт 15. Тохируулаагүй зөрүү, сая төгрөгөөр

№	Орлогын урсгал	Засгийн газрын хүлээн авсан орлого		Компани тайлагнасан төлбөр	
		Компанийн тоо	Дүн	Компанийн тоо	Дүн
1	Анхны тайланд дутуу тайлагнасан	100	568,698.1	99	518,283.7
2	Анхны тайланд илүү тайлагнасан	2	(41,078.6)	46	(95,479.4)
3	ЗГ талаас мэдээлэл ирээгүй	1	75.5	-	-
4	НӨАТ-ийн нөхөн төлбөрийн дүн багтсан	3	(407.9)	-	-
5	Суутган татварын дүнгээр зөрүүтэй	10	73,156.9	-	-
6	Мөнгөн сууриар бүртгээгүй	-	-	39	31,758.4

№	Орлогын урсгал	Засгийн газрын хүлээн авсан орлого		Компани тайлагнасан төлбөр	
		Компанийн тоо	Дүн	Компанийн тоо	Дүн
7	Гаальд төлсөн НӨАТ-ийг НӨАТ-ийн баганад бичээгүй	-	-	47	16,263.3
Нийт дүн		-	600,444.1	-	470,826.1

Анхны нэгтгэлийн үед Засгийн газрын тайланд Сэлэнгэ, Дундговь, Увс аймаг, Багахангай, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн мэдээлэл дутуу зэрэг нь орон нутгийн зөрүүгийн дийлэнх хэсгийг эзэлж байлаа. Нийт 104 компаниас нийт 93 компани нь хувь хүний орлогын албан татварыг тайлагнаагүйгээс компани талаас мэдээлэл дутуу зөрүү үүсгэсэн. Мөн зарим компанийн өгсөн хандивын мэдээллийг ЗГ талаас бүртгэж аваагүй алдаа гарсан байна.

Компанийн дутуу тайлагнасан буюу алдаатай илгээсэн томоохон зөрүүнээс дурдвал:

1. Нийт 104 компаниас нийт 93 компани нь хувь хүний орлогын албан татварыг тайлагнаагүйгээс компани талаас мэдээлэл дутуу зөрүү үүсгэсэн. Үүнд, Оюу толгой компани 68 тэрбум, Эрдэнэт үйлдвэр 41 тэрбум, Эрдэнэс таван толгой компанийн 7.8 тэрбум зэрэг дүнгүүдийг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
2. Петрочайна Дачин Тамсаг компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлогын 133.9 тэрбум төгрөгийн дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
3. Си Өү Эй Эл компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 24.5 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 59.3 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
4. Шинь шинь ХХК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 2.3 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 41.8 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
5. Хангад Эксплорейшн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 25 тэрбум төгрөгөөр дүнг анхны нэгтгэлд тайлагнаагүй байсан.
6. Баян Айраг Эксплорэйшн нэмэгдсэн өртгийн албан татвар болон ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг нэг орон алдаж 5 тэрбум төгрөгийн дүнгээр багаар тайлагнасан байсан.

4.3. Тохируулаагүй үлдсэн зөрүү

Тохируулгын дараа 7,106.6 сая төгрөг зөрүү үлдсэн бөгөөд ААНОАТ, АМНАТ, НӨАТ, гаалийн үйлчилгээний хураамж зэрэг нь өндөр дүнг эзэлж байна.

Хүснэгт 16. Тохируулаагүй үлдсэн зөрүү, орлогын урсгалаар /сая төгрөгөөр/

№	Орлогын урсгал	Засгийн газар илүү тайлагнасан	Засгийн газар дутуу тайлагнасан
Улсын хэмжээний төлбөрийн урсгал			
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	-	(5,446.4)
2	Гаалийн албан татвар	-	(5,928.0)
3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	(7,613.8)
4	Авто дизелийн түлшний онцгой албан татвар	127.5	-
5	АМНАТ	3,277.5	-
6	Тусгай зөвшөөрлийн төлбөр	1,455.1	-

№	Орлогын урсгал	Засгийн газар илүү тайлагнасан	Засгийн газар дутуу тайлагнасан
7	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын төлбөр	-	(557.2)
8	Гадаад ажилчдын ажлын байрны төлбөр	-	(11,443.9)
9	Агаарын бохирдлын төлбөр	-	(509.2)
10	Ажилчдын НДШ	25,122.5	-
11	Гаалийн үйлчилгээний хураамж	-	(1,617.5)
12	Торгууль	-	(1,838.7)
13	Бусад	213.5	-
14	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төвлөрүүлсэн сургалтын урамшуулал	390.7	-
15	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	679.9	-
16	ХХОАТ	195.6	-
Орон нутгийн хэмжээний төлбөрийн урсгал			
17	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,705.1	-
18	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	374.5	-
19	Газрын төлбөр	-	(3,835.2)
20	Ус ашигласны төлбөр	-	(4,699.5)
21	Ус бохирдуулсны төлбөр	-	(1,410.6)
22	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	(60.6)
23	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	(522.4)
24	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	-	(1,849.0)
25	Торгууль	-	(67.7)
26	Нөхөн төлбөр	-	(249.8)
27	Бусад	3,242.2	-
28	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн хэмжээ	1,789.9	-
29	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн тэмдэгтийн хураамж	-	(31.1)
Цэвэр тохируулаагүй зөрүү		(7,106.6)	

Тохируулгын дараах тайлбарлагдаагүй зөрүүг компаниар харуулбал дараах байдалтай байгаа бөгөөд “Энержи Ресурс” ХХК, “Петрочайна Дачин Тамсаг” ХК нь бусдаас өндөр зөрүүг эзэлж байна.

Хүснэгт 17. Тохируулаагүй үлдсэн зөрүү, компаниар

№	РД	Компанийн нэр	Залруулгын дараах зөрүү
1	2074192	Эрдэнэт	-4,823.80
2	5435528	Эрдэнэс Таван толгой	13,965.50
3	2657457	Оюу Толгой	-3,347.10
4	2887746	Энержи Ресурс	19,132.60
5	2016656	Тавантолгой	6,219.30
6	2075385	Петрочайна Дачин Тамсаг	-25,451.40
7	5141583	МоЭнКо	-2,004.30
8	5261198	Си Өү Эй Эл	48.8
9	2095025	Монголын Алт МАК	-1,683.40
10	2548747	Цайртминерал	1,485.20
11	2830213	Шинь шинь ХХК /ГХО/	37.1
12	2855119	Болдтөмөр Ерөө гол	5,293.90
13	5084555	Саусгоби Сэндс	75.7
14	2094533	Бороо Гоулд	-1,443.20
15	2697947	ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ	188
16	5199077	ӨСӨХ ЗООС	-1,653.30
17	2887134	Хангад Эксплорейшн	-568.3
18	2008572	Багануур	374.1

№	РД	Компанийн нэр	Залруулгын дараах зөрүү
19	5830974	МАК Цемент	-438.4
20	2641984	Цементшохой ТӨХК	-2,161.40
21	2708701	Баян Айраг Эксплорэйшн	-883
22	2550466	Монголросцветмет	-1,325.60
23	2051303	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	374
24	2076675	Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам ХХК /ГХО/	14,036.70
25	5106567	Монцемент билдинг материалс	-23
26	6101615	Степ Голд	-11,466.90
27	5124913	Эрдэнэс Монгол	297
28	5671833	ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ	-622.9
29	6436226	Эрдэнэс силвер ресурс	-958.1
30	2050374	Шарын гол	-510.9
31	5051304	Монголжүюаньли ХХК /ГХО/	2.2
32	2807459	Тефис майнинг	34.6
33	2004879	Шивээ-Овоо ТӨХК	28.7
34	6413811	Хан Алтай Ресурс	0.2
35	5352827	Цагаан Өвөлжөө	-1,170.80
36	5295858	Спейшлмайнз/Наран Мандал Энтерпрайзес	622.2
37	2819996	Уулсзаамар	112.3
38	2839717	Тэн Хун	-3,298.50
39	2766337	Доншен газрын тос (Монгол)	-1,189.40
40	2029278	Монполимет	-2,020.60
41	5095549	Алтайн Хүдэр	-152.5
42	2872943	Тод-Ундрага	-1,677.10
43	5722942	Бүрдэл майнинг	-4,116.80
44	5502977	Бадрах Энержи	-3,682.10
45	5877288	Фриендшип ресурсис	0.7
46	5217652	Жавхлант орд	21.7
47	6268048	Топ ган дриллинг ХХК	2,265.80
48	5809797	Ай Би Би Ай	-1,542.30
49	6463932	Говийн шандаст хүлэг	-199.5
50	6195598	Хаан булаг интернэйшнл ХХК	97.1
51	5439183	Баатарван транс	-4.8
52	5253535	Монгол Майнинг энд Эксплорэйшн	0.1
53	2014491	Баянтээг	72.2
54	5292638	РЭДВУЛКАН	5.4
55	2034859	Могойн гол	-23.3
56	5824826	Эрдэнэс Цагаан Суварга	-79.1
57	5396662	Лут чулуу	-319.9
58	2784165	Алтангол эксплорэйшн	636.2
59	5118115	Мөнхийн баян гал	1,150.60
60	4065115	Вестернхолд ХХК	1,150.90
61	2100231	Хос-Хас	103.1
62	5051134	Монголчех металл	286.4
63	2075768	Ариг гал	-126.6
64	2010097	Гантулга трейд	747
65	2718243	Эрдэнэ Монгол	187.4
66	5849314	Юбиксолюшн	-531.3
67	2009765	Хэрлэн-Импэкс	1,291.50
68	2011239	Адуунчулуун	139.6
69	2801299	БМНС	-571.9
70	2868687	Уулс-ноён	-7.3
71	2166631	Хунт өгөөж	1.3
72	5288703	Си Эм Кэй Ай	-136.2
73	2344343	Улз гол	-12.1
74	2618621	Шар Нарст	-332.3

№	РД	Компанийн нэр	Залруулгын дараах зөрүү
75	5294088	Билэгт баялаг	-37.2
76	2643987	Хэнтий-Ус	-1.3
77	2621169	Эс Жи Групп	723.5
78	5369223	Биг Могул Коул Энд Энержи	-64.3
79	5467268	Инфинити спэйс	-385.9
80	5452503	Эм Эл Цахиурт Овоо	-96.5
81	5482046	Цэцэнс Майнинг энд Энержи	-228.2
82	5098297	Зонхэньютиан	936.2
83	5906865	Баянгол эко заамар	103.7
84	5073189	ИЛТ ГОУЛД	60
85	5097282	Фийлдсаплай	819.9
86	5197325	Шанжин-Орд ХХК /ГХО/	822.8
87	2867095	Петро Матад	49.9
88	5513618	Тахь Ресурс	-30.1
89	5396786	Ирмүүн босго	-428.6
90	2010895	Найнги	0.3
91	2003821	Эрчимбаян өлгий ХК	-84
92	2661128	Хотгор	3.2
93	2057573	Макс Импэкс	-50
94	5898749	Эм Жи Жи И Си	189.3
95	6192939	Батбродерс Майнинг	254.6
96	5118344	Алтайн Хар Азарга групп	-60.7
97	5097517	Азаргын гол чонот	49.1
98	5095638	Болд фо ар да	-45.5
99	5493781	Элбэг Орд	11.4
100	5722616	Жамц Давс	0.6
101	5185874	Геопро монгол	3.3
102	5364884	Хорикаваметал	4.6
103	5938953	Будар минералс	10.5
104	5774047	Талстмолор	-3.1
Нийт дүн			-7,546.60

4.4. Тайлагнаагүй компани

Нэгтгэлд хамрагдсан 104 компаниас 95 компани нь цахим тайлагналын системд тайлангаа тайлагнасан төдийгүй нэгтгэлийн тодруулгад хариу ирүүлсэн. Харин үлдсэн 9 компани нь тодорхой шалтгааны улмаас тодруулгад хариу өгөөгүй болно. Хэдий анхны нэгтгэл алдаа ихтэй байсан хэдий ч тодруулга хийх хүрээнд явуулж байсан олон удаагийн тодруулгад хариу ирүүлж хамтран ажиллах талд хичээл зүтгэл гаргаж байсан. Энэ нь олборлох ОУИТБС-ын дэмжин компаниуд хариуцлагатай ажиллаж байгаагийн нэг илрэл гэж үзэж байна.

4.5. Нэгтгэлийн дэлгэрэнгүй үр дүн

Анхны нэгтгэл тайлангаарх төлбөрүүдийн зөрүү болон тохируулга, түүний дараах зөрүүг орон нутгийн хэмжээний төлбөр бүрээр доорх хүснэгтээр харууллаа. Орон нутгийн хэмжээний 3,614.3 сая төгрөгийн төлбөр тайлбарлагдаагүй үлдсэнээс хамгийн өндөр зөрүүг ус ашигласны төлбөр, газрын төлбөр, эд хөрөнгийн албан татвар, бусад төлбөрүүд эзэлж байна.

Хүснэгт 18. Орон нутгийн хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр

Орон нутгийн хэмжээний гол урсгалууд	Тохируулгын өмнө			Тохируулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	23,720.40	51,393.30	-27,672.90	34,539.20	3,161.20	58,259.60	54,554.50	3,705.10
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	223.2	522.9	-299.7	731.8	57.5	954.9	580.4	374.5
Газрын төлбөр	29,373.80	41,813.60	-12,439.90	9,953.30	1,348.70	39,327.10	43,162.30	-3,835.20
Ус ашигласны төлбөр	19,776.30	42,962.50	-23,186.20	18,823.70	337	38,600.00	43,299.50	-4,699.50
Ус бохирдуулсны төлбөр	173.2	1,587.10	-1,413.90	0.6	-2.6	173.8	1,584.40	-1,410.60
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	382.4	27,296.40	-26,914.00	1,182.20	-25,671.20	1,564.70	1,625.20	-60.6
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	502.2	-502.2	-	20.2	-	522.4	-522.4
Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	-	3,167.00	-3,167.00	-	-1,318.00	-	1,849.00	-1,849.00
Торгууль	1,488.00	69.2	1,418.80	0.4	1,486.90	1,488.40	1,556.10	-67.7
Нөхөн төлбөр	-	249.4	-249.4	-	0.4	-	249.8	-249.8
Бусад	48,605.50	2,869.50	45,736.00	-41,078.60	1,415.20	7,526.90	4,284.70	3,242.20
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн хэмжээ	3,505.40	-	3,505.40	-	1,715.50	3,505.40	1,715.50	1,789.90
Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн тэмдэгтийн хураамж	62.9	-	62.9	-	94	62.9	94	-31.1
Нийт	127,311.00	172,433.10	-45,122.10	24,152.70	-17,355.20	151,463.70	155,078.00	-3,614.30

Улсын хэмжээний гол урсгалын тайлбарлагдаагүй зөрүү 3,492.3 сая бөгөөд ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл, гадаад ажилчдын ажлын байрны төлбөр, ААНОАТ, НӨАТ, гаалийн албан татвар зэрэг нь тус зөрүүнд өндөр дүнг эзэлж байна.

Хүснэгт 19. Улсын хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр

Улсын хэмжээний гол урсгалууд	Тохируулгын өмнө			Тохируулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	977,772.7	1,024,617.5	(46,844.9)	73,156.9	31,758.4	1,050,929.6	1,056,376.0	(5,446.4)
Гаалийн албан татвар	40,652.7	69,184.5	(28,531.9)	-	(22,603.9)	40,652.7	46,580.7	(5,928.0)
Нэмэгдсэн өртгийн албан татвар	234,354.1	202,692.9	31,661.3	(407.9)	38,867.2	233,946.3	241,560.0	(7,613.8)
Авто дизелийн түлшний онцгой албан татвар	166.8	-	166.8	-	39.3	166.8	39.3	127.5
АМНАТ	2,508,899.5	2,386,031.3	122,868.2	16,373.2	135,963.9	2,525,272.7	2,521,995.2	3,277.5
Тусгай зөвшөөрлийн төлбөр	1,370.6	5,589.1	(4,218.5)	6,475.1	801.6	7,845.7	6,390.6	1,455.1
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын төлбөр	-	632.7	(632.7)	75.5	-	75.5	632.7	(557.2)
Гадаад ажилчдын ажлын байрны төлбөр	-	5,449.5	(5,449.5)	-	5,994.4	-	11,443.9	(11,443.9)
Агаарын бохирдлын төлбөр	21,923.0	21,301.2	621.7	0.1	1,131.0	21,923.0	22,432.3	(509.2)
Ажилчдын НДШ	394,514.9	321,389.9	73,125.1	13.7	48,016.2	394,528.6	369,406.1	25,122.5
Гаалийн үйлчилгээний хураамж	49,772.9	49,620.1	152.8	-	1,770.3	49,772.9	51,390.4	(1,617.5)
Төрийн өмчийн ногдол ашиг	-	450,773.8	(450,773.8)	450,773.8	-	450,773.8	450,773.8	-
Торгууль	500.6	16,375.2	(15,874.6)	6,902.8	(7,133.1)	7,403.4	9,242.1	(1,838.7)
Бусад	1,485.8	62,391.6	(60,905.8)	-	(61,119.3)	1,485.8	1,272.3	213.5
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төвлөрүүлсэн сургалтын урамшуулал	1,158.9	-	1,158.9	-	768.2	1,158.9	768.2	390.7
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	1,211.8	-	1,211.8	-	531.8	1,211.8	531.8	679.9
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	137,080.2	-	137,080.2	-	137,080.2	137,080.2	137,080.2	-
ХХОАТ	176,650.3	-	176,650.3	-	176,454.7	176,650.3	176,454.7	195.6
Нийт	4,547,514.7	4,616,049.2	(68,534.5)	553,363.1	488,321.0	5,100,877.8	5,104,370.2	(3,492.3)

Харин зөрүүг компаниар нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд: бөгөөд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Энержи Ресурс” ХХК, “Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам” ХХК зэрэг компаниуд бусад компанитай харьцуулахад өндөр зөрүүтэй үлдсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээс харна уу.

Хүснэгт 20. Улсын хэмжээний нэгтгэл, орлогын урсгалаар, сая төгрөгөөр

№	Компанийн нэр	Анхны нэгтгэл			Тохируулга		Тохируулгын дараах нэгтгэл		
		ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
1	Эрдэнэт	1,373,273.2	1,749,264.5	(375,991.3)	412,090.2	40,922.7	1,785,363.4	1,790,187.1	(4,823.8)
2	Эрдэнэс Таван толгой	1,019,200.8	1,021,151.7	(1,950.9)	33,361.9	17,445.6	1,052,562.8	1,038,597.3	13,965.5
3	Оюу Толгой	521,510.8	586,226.5	(64,715.7)	67,748.9	6,380.3	589,259.7	592,606.8	(3,347.1)
4	Энержи Ресурс	299,790.2	296,049.8	3,740.4	8,594.5	(6,797.8)	308,384.7	289,252.1	19,132.6
5	Тавантолгой	268,507.2	295,993.5	(27,486.3)	20,911.8	(12,793.9)	289,419.0	283,199.6	6,219.3
6	Петрочайна Дачин Тамсаг	139,274.8	32,764.3	106,510.4	164.5	132,126.3	139,439.2	164,890.6	(25,451.4)
7	МоЭнКо	113,966.6	115,071.7	(1,105.2)	29.7	928.8	113,996.3	116,000.6	(2,004.3)
8	Си Өү Эй Эл	107,682.4	21,446.5	86,235.9	25.9	86,213.0	107,708.3	107,659.5	48.8
9	Монголын Алт МАК	100,630.5	101,302.6	(672.1)	3,177.4	4,188.6	103,807.9	105,491.2	(1,683.4)
10	Цайртминерал	90,684.3	100,467.9	(9,783.5)	13,135.5	1,866.8	103,819.8	102,334.6	1,485.2
11	Шинь шинь ХХК /ГХО/	79,101.9	-	79,101.9	37.1	79,101.9	79,139.1	79,101.9	37.1
12	Болдтөмөр Ерөө гол	48,087.5	40,949.8	7,137.7	53.1	1,896.9	48,140.6	42,846.7	5,293.9
13	Саусгоби Сэндс	46,748.3	61,711.7	(14,963.4)	16,272.0	1,232.9	63,020.3	62,944.7	75.7
14	Бороо Гоулд	39,174.1	56,180.3	(17,006.2)	16,614.3	1,051.3	55,788.4	57,231.6	(1,443.2)
15	ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ	34,096.7	33,591.4	505.3	220.9	538.2	34,317.6	34,129.6	188.0
16	ӨСӨХ ЗООС	28,002.1	30,283.0	(2,280.9)	817.1	189.5	28,819.1	30,472.5	(1,653.3)
17	Хангад Эксплорейшн	27,292.2	28,195.5	(903.3)	1,412.8	1,077.8	28,705.0	29,273.3	(568.3)
18	Багануур	25,881.3	19,318.4	6,562.9	26.1	6,214.8	25,907.3	25,533.2	374.1
19	МАК Цемент	25,609.9	24,275.7	1,334.2	21.7	1,794.2	25,631.5	26,069.9	(438.4)
20	Цементшохой ТӨХК	23,386.1	-	23,386.1	1.4	25,548.9	23,387.5	25,548.9	(2,161.4)
21	Баян Айраг Эксплорэйшн	21,842.2	15,073.2	6,769.0	218.5	7,870.5	22,060.7	22,943.6	(883.0)
22	Монголросцветмет	20,965.7	15,693.6	5,272.0	237.0	6,834.6	21,202.7	22,528.3	(1,325.6)
23	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	20,004.8	-	20,004.8	203.3	19,834.2	20,208.1	19,834.2	374.0
24	Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам ХХК /ГХО/	14,936.7	-	14,936.7	1.5	901.5	14,938.2	901.5	14,036.7
25	Монцемент билдинг материалс	14,511.9	16,980.6	(2,468.7)	4.4	(2,441.3)	14,516.4	14,539.3	(23.0)

№	Компанийн нэр	Анхны нэгтгэл			Тохируулга		Тохируулгын дараах нэгтгэл		
		ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
26	Степ Голд	6,366.7	17,111.6	(10,745.0)	120.8	842.7	6,487.5	17,954.4	(11,466.9)
27	Эрдэнэс Монгол	8,617.7	-	8,617.7	65.2	8,385.9	8,682.9	8,385.9	297.0
28	ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ	8,419.9	1,628.3	6,791.6	13.7	7,428.1	8,433.6	9,056.5	(622.9)
29	Эрдэнэс силвер ресурс	7,581.0	21,660.5	(14,079.5)	1.9	(13,119.5)	7,582.8	8,540.9	(958.1)
30	Шарын гол	7,269.6	6,943.6	326.1	13.2	850.2	7,282.9	7,793.8	(510.9)
31	Монголжүюаньли ХХК /ГХО/	6,809.3	-	6,809.3	2.2	6,809.3	6,811.5	6,809.3	2.2
32	Төфис майнинг	6,255.0	408.4	5,846.6	34.6	5,846.6	6,289.5	6,255.0	34.6
33	Шивээ-Овоо ТӨХК	6,105.9	-	6,105.9	521.4	6,598.6	6,627.3	6,598.6	28.7
34	Хан Алтай Ресурс	5,419.4	4,572.0	847.4	147.8	995.0	5,567.1	5,567.0	0.2
35	Цагаан Өвөлжөө	5,550.4	6,495.0	(944.6)	446.8	673.0	5,997.2	7,168.0	(1,170.8)
36	Спейшлмайнз/Наран Мандал Энтерпрайзес	5,496.3	3,798.9	1,697.4	378.3	1,453.5	5,874.6	5,252.3	622.2
37	Уулсзаамар	3,719.7	1,594.5	2,125.2	222.6	2,235.5	3,942.3	3,830.0	112.3
38	Тэн Хун	4,526.7	7,586.7	(3,060.1)	8.2	246.5	4,534.8	7,833.3	(3,298.5)
39	Доншен газрын тос (Монгол)	4,080.4	-	4,080.4	2.4	5,272.2	4,082.8	5,272.2	(1,189.4)
40	Монполимет	3,874.3	6,477.5	(2,603.2)	51.3	(531.2)	3,925.7	5,946.3	(2,020.6)
41	Алтайн Хүдэр	3,635.4	2,398.0	1,237.3	17.8	1,407.7	3,653.2	3,805.7	(152.5)
42	Тод-Ундрага	3,414.7	4,370.3	(955.6)	18.1	739.5	3,432.7	5,109.8	(1,677.1)
43	Бүрдэл майнинг	3,328.7	7,029.3	(3,700.5)	63.8	480.1	3,392.6	7,509.4	(4,116.8)
44	Бадрах Энержи	2,470.3	6,565.8	(4,095.5)	1,056.5	643.2	3,526.9	7,209.0	(3,682.1)
45	Фриендшип ресурсис	2,928.4	3,810.6	(882.2)	0.7	(882.2)	2,929.1	2,928.4	0.7
46	Жавхлант орд	2,746.6	3,246.0	(499.4)	594.9	73.9	3,341.6	3,319.9	21.7
47	Топ ган дриллинг ХХК	2,709.9	-	2,709.9	106.8	550.9	2,816.7	550.9	2,265.8
48	Ай Би Би Ай	2,693.9	3,280.3	(586.4)	76.3	1,032.2	2,770.2	4,312.5	(1,542.3)
49	Говийн шандаст хүлэг	2,673.1	12,486.7	(9,813.6)	39.8	(9,574.3)	2,712.9	2,912.3	(199.5)
50	Хаан булаг интернэйшнл ХХК	2,005.3	-	2,005.3	27.2	1,935.5	2,032.5	1,935.5	97.1
51	Баатарван транс	2,000.9	949.8	1,051.1	1.0	1,056.8	2,001.9	2,006.6	(4.8)
52	Монгол Майнинг энд Эксплорэйшн	1,934.9	-	1,934.9	0.0	1,934.8	1,934.9	1,934.8	0.1
53	Баянтээг	1,653.6	1,025.4	628.3	4.2	560.3	1,657.9	1,585.7	72.2
54	РЭДВУЛКАН	1,748.4	-	1,748.4	5.4	1,748.4	1,753.8	1,748.4	5.4
55	Могойн гол	1,680.5	1,548.2	132.3	(8.2)	147.4	1,672.4	1,695.6	(23.3)
56	Эрдэнэс Цагаан Суварга	1,625.6	-	1,625.6	2.9	1,707.6	1,628.5	1,707.6	(79.1)
57	Лут чулуу	1,589.5	1,074.3	515.2	4.2	839.3	1,593.7	1,913.7	(319.9)
58	Алтангол эксплорэйшн	1,563.5	793.4	770.1	27.8	161.7	1,591.3	955.1	636.2
59	Мөнхийн баян гал	1,471.1	64.6	1,406.4	8.5	264.3	1,479.6	328.9	1,150.6

№	Компанийн нэр	Анхны нэгтгэл			Тохируулга		Тохируулгын дараах нэгтгэл		
		ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
60	Вестернхолд ХХК	1,445.9	-	1,445.9	1.6	296.6	1,447.5	296.6	1,150.9
61	Хос-Хас	1,394.4	1,009.5	384.9	(58.8)	223.0	1,335.6	1,232.5	103.1
62	Монголчех металл	1,381.1	713.0	668.1	7.8	389.6	1,388.9	1,102.5	286.4
63	Ариг гал	1,380.4	-	1,380.4	0.3	1,507.3	1,380.7	1,507.3	(126.6)
64	Гантулга трейд	1,313.1	196.9	1,116.2	-	369.2	1,313.1	566.1	747.0
65	Эрдэнэ Монгол	1,312.0	274.0	1,038.0	161.5	1,012.2	1,473.5	1,286.2	187.4
66	Юбиксолушн	1,188.2	1,405.2	(217.0)	16.4	330.7	1,204.6	1,735.9	(531.3)
67	Хэрлэн-Импэкс	1,295.4	3.4	1,292.0	0.7	1.2	1,296.0	4.6	1,291.5
68	Адуунчулуун	1,275.1	2,258.7	(983.6)	0.8	(1,122.4)	1,275.9	1,136.3	139.6
69	БМНС	877.3	913.6	(36.3)	52.7	588.3	930.0	1,501.9	(571.9)
70	Уулс-ноён	1,162.1	906.4	255.7	(11.8)	251.1	1,150.3	1,157.5	(7.3)
71	Хунт өгөөж	1,096.2	918.3	177.9	8.2	184.8	1,104.4	1,103.1	1.3
72	Си Эм Кэй Ай	1,116.3	466.5	649.8	3.2	789.2	1,119.5	1,255.8	(136.2)
73	Улз гол	1,065.5	13.9	1,051.6	13.9	1,077.6	1,079.4	1,091.5	(12.1)
74	Шар Нарст	1,032.8	1,148.9	(116.0)	11.0	227.2	1,043.8	1,376.1	(332.3)
75	Билэгт баялаг	1,013.6	1,037.7	(24.1)	1.3	14.3	1,014.9	1,052.1	(37.2)
76	Хэнтий-Ус	1,005.9	-	1,005.9	-	1,007.2	1,005.9	1,007.2	(1.3)
77	Эс Жи Групп	961.2	226.6	734.6	39.2	50.3	1,000.4	277.0	723.5
78	Биг Могул Коул Энд Энержи	981.5	2,752.3	(1,770.8)	23.5	(1,683.0)	1,005.0	1,069.3	(64.3)
79	Инфинити спэйс	965.4	889.1	76.3	18.0	480.2	983.4	1,369.3	(385.9)
80	Эм Эл Цахиурт Овоо	934.2	430.1	504.1	5.7	606.3	939.9	1,036.5	(96.5)
81	Цэцэнс Майнинг энд Энержи	954.9	582.1	372.9	2.4	603.4	957.3	1,185.5	(228.2)
82	Зонхэнюутиан	936.2	-	936.2	-	-	936.2	-	936.2
83	Баянгол эко заамар	831.1	676.3	154.8	8.0	59.1	839.1	735.4	103.7
84	ИЛТ ГОУЛД	821.4	-	821.4	60.0	821.4	881.4	821.4	60.0
85	Фийлдсаглай	886.4	50.5	835.9	6.4	22.4	892.8	72.9	819.9
86	Шанжин-Орд ХХК /ГХО/	875.0	-	875.0	1.7	53.9	876.7	53.9	822.8
87	Петро Матад	789.1	779.2	9.9	36.8	(3.2)	825.9	776.0	49.9
88	Тахь Ресурс	840.7	29.9	810.8	0.2	841.1	840.9	871.0	(30.1)
89	Ирмүүн босго	676.8	1,595.2	(918.4)	18.1	(471.7)	694.9	1,123.5	(428.6)
90	Найинги	846.6	652.2	194.5	208.0	402.2	1,054.7	1,054.3	0.3
91	Эрчимбаян өлгий ХК	768.0	-	768.0	4.9	856.8	772.9	856.8	(84.0)
92	Хотгор	692.0	640.0	52.0	1.1	49.8	693.1	689.9	3.2
93	Макс Импэкс	768.6	692.6	76.0	52.2	178.2	820.8	870.8	(50.0)
94	Эм Жи Жи И Си	541.1	236.7	304.4	6.9	122.1	548.0	358.7	189.3
95	Батбродерс Майнинг	764.5	495.4	269.1	6.6	21.1	771.0	516.5	254.6
96	Алтайн Хар Азарга групп	57.7	113.1	(55.5)	6.3	11.6	64.0	124.7	(60.7)

№	Компанийн нэр	Анхны нэгтгэл			Тохируулга		Тохируулгын дараах нэгтгэл		
		ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
97	Азаргын гол чонот	7.3	-	7.3	49.1	7.3	56.4	7.3	49.1
98	Болд фо ар да	23.0	69.3	(46.3)	0.8	-	23.8	69.3	(45.5)
99	Элбэг Орд	26.4	-	26.4	11.4	26.4	37.8	26.4	11.4
100	Жамц Давс	13.5	-	13.5	9.3	22.1	22.8	22.1	0.6
101	Геопро монгол	-	-	-	3.3	-	3.3	-	3.3
102	Хорикаваметал	-	-	-	4.6	-	4.6	-	4.6
103	Будар минералс	2.6	-	2.6	7.9	-	10.5	-	10.5
104	Талстмолор	471.88	557.37	(85.49)	19.99	(62.41)	491.86	494.96	(3.10)

БҮЛЭГ 5. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАР

5.1. Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (Шаардлага 2.1)

5.1.1. Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт

5.1.1.1. Уул уурхай, газрын тос, цөмийн энергийн салбарын эрх зүйн тогтолцооны өнөөгийн байдал

Олборлох үйлдвэрлэл нь 30 гаруй хууль 40 гаруй журмаар зохицуулагдаж байгаа ч дэлхий нийтийн уул уурхайн чиг хандлага тогтвортой, харилцан ашигтай, ногоон хөгжлийн чиг хандлагад тулгуурлаж, тасралтгүй хөгжиж буй энэ цаг үед төрийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын тогтвортой орчин, орон нутгийн иргэдтэй харилцах зэрэг асуудлуудыг илүү нарийвчилж зохицуулах шаардлагатай байна. 2022 онд Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд нь дараах зорилгын дагуу хэрэгжиж байна.

Ашигт малтмалын тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Газрын хэвлийн тухай хууль:

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох, тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Газрын тосны тухай:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай:

Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цөмийн энергийн тухай:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

5.1.1.2. Салбарын гол хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт

Тус салбарын гол хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийг оноор харуулав. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль, 2006 (2017 онд 2 удаа, 2018 1 удаа, 2019 онд 4 удаа, 2021 онд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013, (2015, 2017, 2020, 2021 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Газрын хэвлийн тухай хууль, 1988 (1994, 1995, 2015 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014 (2015, 2016, 2017 онуудад 1 удаа, 2021 онд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Цөмийн энергийн тухай хууль, 2009 (2012, 2013, 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа 2021 онд 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Газрын тосны тухай хууль, 2014 (2017, 2020 онд 1 удаа 2021 онд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005 (2013, 2015, 2016, 2017, 2019 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009 (2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009 (2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан).

Мөн эдгээр хуулиудад 2022 онд орсон нэмэлт өөрчлөлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 21. Олборлох үйлдвэрлэлийн гол хуулиудад 2022 онд орсон нэмэлт өөрчлөлтүүд

Голлох хууль	Огноо	Тайлбар
Ашигт малтмалын тухай хууль	2022 оны 04 сарын 22 өдөр	1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: "46.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл эрх бүхий хуулийн этгээдээр тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлнэ."
		2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
		2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрдэнэсийн сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	2022 оны 11 сарын 11 өдөр	1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн "байгууллага,мэргэжлийн хяналтын" гэснийг "асуудал эрхэлсэн" гэж, 25 дугаар зүйлийн 25.2.3 дахь заалтын "болон мэргэжлийн хяналтын" гэснийг ", хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын газарт" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад" гэж тус тус өөрчилсүгэй.
		2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн "байгууллага, мэргэжлийн хяналтын" гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын байгууллага," гэснийг тус тус хассугай.
		3 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 04 сарын 22 өдөр	1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн "Тэргүүлэгчдийн" гэснийг хассугай.
Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль	2022 оны 11 сарын 12 өдөр	1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т" гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.5, 15.10.6, 15.10.18, 15.10.20, 15.15.1, 15.18.5, 15.18.6-д" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.6-д, 8 дахь хэсгийн 8.7, 8.14, 8.15, 8.16, 8.19-д" гэж, мөн зүйлийн 16.1.2 дахь заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.4-т" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.2-т" гэж, 16.1.3 дахь заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14.6-д"

Голлох хууль	Огноо	Тайлбар
		гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1, 3.3, 3.5-д" гэж тус тус өөрчилсүгэй.
		2 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6, 11.1.7 дахь заалт болон" гэснийг хассугай.
		3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 06 сарын 17 өдөр	1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т" гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.5, 15.10.6, 15.10.18, 15.10.20, 15.15.1, 15.18.5, 15.18.6-д" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.6-д, 8 дахь хэсгийн 8.7, 8.14, 8.15, 8.16, 8.19-д" гэж, мөн зүйлийн 16.1.2 дахь заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.4-т" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.2-т" гэж, 16.1.3 дахь заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14.6-д" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1, 3.3, 3.5-д" гэж тус тус өөрчилсүгэй.
Газрын тосны тухай хууль	2022 оны 04 сарын 22 өдөр	2 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6, 11.1.7 дахь заалт болон" гэснийг хассугай.
		3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
		1 дүгээр зүйл.Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:
		"10 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын бүрэн эрх 10.1.Аймгийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдгээрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг хариуцах, дэмжлэг үзүүлэх; 10.1.2.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; 10.1.3.энэ хуулийн 10.1.2-т заасан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг жил бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт танилцуулах;

Голлох хууль	Огноо	Тайлбар
		10.1.4.хязгаарласан, эсхүл хориглосноос бусад тохиолдолд газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайд зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулахад бүх төрлийн дэмжлэг үзүүлэх; 10.1.5.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх; 10.1.6.газрын тосны тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах. 10.2.Сумын Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.2.1.харьяалах нутаг дэвсгэртээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэхэд хяналт тавих, зөрчил гаргавал зөрчлийг таслан зогсоох, арилгуулах; 10.2.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих; 10.2.3.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, харьяалах дээд шатны Засаг даргад тайлагнах; 10.2.4.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх; 10.2.5.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх. 10.3.Багийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.3.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцах; 10.3.2.энэ хуулийн 10.2.2-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дээд шатны Засаг даргад санал өгөх; 10.3.3.энэ хуулийн 11.2.17-д заасан гэрээнд санал өгөх. 10.4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.4.1.төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хэлэлцэн дүгнэлт гаргах; 10.4.2.энэ хуулийн 10.4.1-д заасан дүгнэлт гаргахдаа зөвхөн хуульд заасан үндэслэлээр татгалзах; 10.4.3.татан буулгалтын ажлын үр дүнг хүлээн авах комиссын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах; 10.4.4.газрын тосны тухай болон бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан орон нутгийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулах."
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	2022 оны 11 сарын 11 өдөр	1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "улсын мэргэжлийн хяналтын алба" гэснийг "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага" гэж өөрчилсүгэй.

Голлох хууль	Огноо	Тайлбар
		2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 06 сарын 17 өдөр	1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж тус тус өөрчилсүгэй. 2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
Цөмийн энергийн тухай хууль	2022 оны 11 сарын 11 өдөр	1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11 ^{1.1} дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 11 ^{1.1} дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэснийг "Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалтын, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж тус тус өөрчилсүгэй. 2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 11 сарын 12 өдөр	1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11 ^{1.1} дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 11 ^{1.1} дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэснийг "Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалтын, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж тус тус өөрчилсүгэй. 2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 06 сарын 17 өдөр	1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.3-т" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т" гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй. 2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Голлох хууль	Огноо	Тайлбар
Газрын хэвлийн тухай хууль	2022 оны 06 сарын 17 өдөр	1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай. 2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 04 сарын 22 өдөр	1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй: 1/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт: "Зулсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх."
		2/8 ¹ дүгээр зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх "1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг судлах ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлого, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих; 2/энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар баг, хорооны Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх. 2. Баг, хорооны Засаг дарга газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Засаг даргын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах; 2/нутаг дэвсгэртээ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бүх төрлийн геологийн судалгааны ажил болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлаар ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх."
		2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн хэсгийн 1 дэх заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 1 дэх заалтын "газрын хэвлийг" гэсний дараа "судлах," гэж тус тус нэмсүгэй.
		3 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: Хэвлэх 1/7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт: "З/нутаг дэвсгэртээ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;" 2/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалт: "2/нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газрыг Ашигт малтмалын болон Газрын тухай хуульд нийцүүлэн олгох; 3/нутаг дэвсгэртээ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бүх төрлийн геологийн судалгааны ажил болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлаар ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;" 3/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

Голлох хууль	Огноо	Тайлбар
		"5/нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.17, 59.1.18, 62.1.7-д заасан эрхийг хэрэгжүүлэх;"
Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль	2022 оны 12 сарын 09 өдөр	1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн "дамжуулан" гэсний дараа "агаарын хөлгийн түлшнээс бусад" гэж нэмсүгэй.
	2022 оны 11 сарын 11 өдөр	1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалтын, 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтын "мэргэжлийн хяналтын" гэснийг "холбогдох хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж тус тус өөрчилсүгэй.
		2 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн ", мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран" гэснийг хассугай.
		3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
	2022 оны 06 сарын 17 өдөр	1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т" гэж тус тус өөрчилсүгэй.
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	2022 оны 11 сарын 11 өдөр	2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
		1 дүгээр зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэснийг хассугай.
		2 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эх сурвалж: Legalinfo.mn

5.1.1.3. Олборлох үйлдвэрлэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн гол зохицуулалт

Олборлох үйлдвэрлэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн гол зохицуулалт буюу Засгийн Газрын тогтоолуудыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 22. Олборлох үйлдвэрлэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн гол зохицуулалт

Дугаар	Огноо	Гол агуулга, тайлбар	Төрөл
110	2022.08.10	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай	Засгийн газрын тогтоол

Дугаар	Огноо	Гол агуулга, тайлбар	Төрөл
379	2022.05.11	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах, эрх олгох тухай	Засгийн газрын тогтоол
296	2022.07.05	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах, эрх олгох тухай	Засгийн газрын тогтоол
166	2022.04.20	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай	Засгийн газрын тогтоол
165	2022.04.20	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай	Засгийн газрын тогтоол
195	2022.08.03	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэн батлах тухай	Засгийн газрын тогтоол
270	2022.10.19	Ашигт малтмал хайх талбайн солбилцол батлах, эрх олгох тухай	Засгийн газрын тогтоол
303	2022.03.09	Ашигт малтмал хайх талбайн солбилцол батлах, эрх олгох тухай	Засгийн газрын тогтоол

Эх сурвалж: Legalinfo.mn

5.1.1.4. Үйлдвэрлэлийн харилцааг зохицуулж буй бусад хуулиуд (багцлан үзүүлэв)

Олборлох салбарыг зохицуулж буй бусад хуулиудыг холбогдох чиглэлээр нь ангилан үзүүлэв.

Хүснэгт 23. Салбарын бусад хуулиуд

Байгаль орчны чиглэлийн	Төсөв, татварын чиглэлийн
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006
Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995	Гаалийн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2008
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2017
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012	Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012
Газрын тухай хууль, 2002	Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016
Газрын төлбөрийн тухай хууль, 1997	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006,2015
Ойн тухай хууль, 2012	Татварын ерөнхий хууль, 2008
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010
-	Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000
-	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010
Хариуцлагын чиглэл	Бизнесийн харилцаа, орчны чиглэлийн
Аудитын тухай хууль 1997,2015	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001
Зөрчлийн тухай хууль, 2017	Захиргааны ерөнхий хууль, 2015
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017	Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, 2015
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012	-

Дараах хуулиудад 2022 онд нэмэлт өөрчлөлт орсон байна.

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль

5.1.2. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогууд

5.1.2.1. Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого

Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг 2009 оны 06 сарын 25 өдөр 45 дугаар Улсын Их Хурлын тогтоолоор баталж байсан байна.

Уг тогтоолын гол зорилго нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино. 2009 оноос хойш ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд 8 хэсгээс бүрддэг байна.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын 1.1-т дараах зүйлийг тусгасан байдаг.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

5.1.3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд гарсан эрх зүйн баримт бичгүүд

Ашигт малтмалын тухай хууль (2006), Цөмийн энергийн тухай хууль (2009), Газрын тосны тухай хууль (2014), Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014), Зөрчлийн тухай хууль (2017), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017) зэрэг 6 хуульд өмнө нь ОҮИТБС-тай холбоотой хуулийн өөрчлөлт орж байсан бөгөөд 2022 онд ОҮИТБС-тай холбоотой нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

ОҮИТБС-ыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор дараах төрийн бодлогын баримт бичгүүд батлагдсан байна, үүнд:

- УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014)-д ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх,
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2016)-т олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2017)-нд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах 6 төрлийн арга хэмжээг 2017-2023 оны хугацаанд 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжин, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол болон 2017 оны 263 дугаар тогтоолуудаар

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах (зарим) арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 190 дүгээр тогтоолоор олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар, мөн 2015 оны 104 дүгээр тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан байна.

5.1.4. Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж (шаардлага 2.1)

5.1.4.1. Төсвийн бүрдэлт хуваарилалт

Төсөв нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд тухайн оны хугацаанд төрийн санд хуримтлагдах нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

Төсвийн орлого нь татварын болон татварын бус орлого, тусламжаас бүрддэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд ногдох хэсгийг хасаад үлдсэн орлогыг Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.

Татварын орлогод татварын ерөнхий хуулийн дагуу тогтоосон татвар болон төлбөр орно.

Татварын бус орлогод дараах орлогууд хамаарна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр;
- Төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээсэлсний орлого;
- Торгуулийн төлбөр;
- Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого;
- ЗГ-т олгосон зээл, тусламж;
- Хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлсэн бусад орлого орно

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Төсвийн зарлага нь төрөөс иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг.

Нийгмийн даатгалын сангийн төсөв. Нийгмийн даатгалын хуулийн дагуу ажилтан болон ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, улсын төсвөөс олгосон санхүүжилтээр бүрдүүлсэн орлогоор Нийгмийн даатгалын хуулиудад заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төр, иргэн, байгууллагаас төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

5.1.4.2. Төсвийн хууль тогтоомж

Төсвийн тухай хууль. Улсын нэгдсэн төсөв нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төсвийн тухай хуульд 2022 онд 6 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд дараах линкээр нэвтрэн танилцах боломжтой. / <https://legalinfo.mn/mn/detail/12254/>

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг хуульд 2022 онд нэмэлт өөрчлөлт ороогүй бөгөөд дараах линкээр нэвтрэн танилцах боломжтой. / <https://legalinfo.mn/mn/detail/503/>

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2022 онд энэхүү хуульд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд дараах линкээр нэвтрэн танилцах боломжтой. / <https://legalinfo.mn/mn/detail/14848/>

Ирээдүйн өв сангийн тухай хууль. Ирээдүйн өв сангийн тухай хууль нь УИХ-аар 2016 онд батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-с бүх нийтээр дагаж мөрдөхөөр болсон. Энэ хуулийн зорилт нь

- Нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах,
- Түүнд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн өгөөжийг хуваарилах, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах,
- Макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Энэхүү хуульд 2022 оны 04 сарын 29 өдөр нэмэлт өөрчлөлт хийгдсэн байна. /<https://legalinfo.mn/mn/detail/11707/>

5.2. Уул уурхай

5.2.1. Монголын ашигт малтмалын тухай тойм

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 18,593.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 4,337.9 тэрбум төгрөг буюу 30.4 хувиар өссөн байна. Үүнээс, Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 4,606.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 492.5 тэрбум төгрөг буюу 12.0 хувиар өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

Хүснэгт 24. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ

Уул уурхай, олборлох	4,390.2 тэрбум төгрөг буюу 23.6 хувь,
Газрын тос	161.0 тэрбум төгрөг буюу 0.9 хувь,
Тусгай зөвшөөрлийн төлбөр	35.6 тэрбум төгрөг буюу 0.2 хувь,
Бусад орлого	20.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувь.

Нийт экспорт 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,540.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3,299.3 сая ам.доллар буюу 35.7 хувиар өссөн байна. Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 11,754.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 3,133.9 сая ам.доллар буюу 36.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 25. Уул уурхайн салбарын үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2021	2022
Бүгд	Тусгай зөвшөөрлийн тоо	2,636	2,544
	Талбайн хэмжээ /мян.га/	6,151.5	5,950.6
	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	3.90	3.80
Ашиглалт	Тусгай зөвшөөрлийн тоо	1,745	1,713
	Талбайн хэмжээ /мян.га/	1,770.8	1,836.5
	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	1.10	1.20
Хайгуул	Тусгай зөвшөөрлийн тоо	891	831
	Талбайн хэмжээ /мян.га/	4,380.7	4,114.1
	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	2.80	2.60

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022, АМГТГ

2022 онд 5950 мянган га талбайг хамарсан 2544 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчинтэй ашиглагдаж байгаа нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 3.8 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн 2021 онтой харьцуулахад 0.1 пунктээр буурсан байна. Нийт тусгай зөвшөөрлийн 67.3 хувь буюу 1713 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бол 32.7 хувь буюу 831 нь хайгуулын тусгай зөвшөөрөл байна.

Хүснэгт 26. Уурхайн салбарын гол бүтээгдэхүүнүүдийн олборлолт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022
Зэсийн баяжмал	мян.тн	1,276.7	1,326.3	1,189.8
Молибдений баяжмал	тн	6,038.3	6,326.0	5,914.2
Алт	кг	20,225.5	19,054.4	19,382.7
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	мян.тн	212.3	178.6	120.1
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	13,940.9	12,848.7	9,388.0
Цайрын баяжмал	мян.тн	76.3	75.2	199.3
Нүүрс	мян.тн	40,486.1	30,124.3	37,282.0
Газрын тос	мян.бар	4,105.8	4,667.3	2,566.0

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022, АМГТГ

Уурхайн салбарын гол бүтээгдэхүүний олборлолтыг 2021 онтой харьцуулж үзэхэд зэсийн баяжмалын олборлолт 136.5 мян.тн, молибдений баяжмал 411.8 тн, хайлуур жоншны хүдэр болон баяжмал 58.5 мян.тн, төмрийн хүдэр болон баяжмал 3,460.7 мян.тн, газрын тос 2,101.3 мян.баррелиар тус тус буурчээ.

5.2.2. Ураны тухай тойм мэдээлэл

Цөмийн энергийн тухай хууль 2009 онд батлагдаж, 27 аж ахуйн нэгжид цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 164 тусгай зөвшөөрөл олгосон ба Монгол Улсын нутаг дэвсгэрийн 2.6 хувийг эзэлж байсан. Харин одоогоор монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмалын 13 орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсэжсэн цэг, цацраг идэвхт гажил илрүүлсэн байдаг. АМГТГ-аас 2022 оны зургаадугаар сарын байдлаар авсан мэдээллээр Монгол Улсад ураны 13 ордын хэмжээнд 192,241.02 тонн геологийн нөөц бүртгэн авчээ. Нийт нөөцийн 67 хувь нь газрын доор уусган олборлож (ГДУО) ашиглахад тохиромжтой.

Хүснэгт 27. Хүчин төгөлдөр байгаа Ураны тусгай зөвшөөрлүүд

Д/д	Жагсаалт	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Аймаг	Сум	Эзэмшигч
1	MV-020631	Гурвансайхан	2,810.44	Дундговь	Гурвансайхан	Гурвансайхан
2	MV-018916	Дулаан уул	27,697.26	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энерги
3	MV-018915	Зөөвч овоо	18,213.58	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энерги
4	MV-018914	Өмнөт	2,464.93	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энерги
5	MV-020629	Хайрхан	4,628.42	Дундговь	Өлзийт	Гурвансайхан
6	MV-020633	Чойр	10,386.24	Дундговь	Баянжаргалан, Өндөршил	Гурвансайхан

Ашигт малтмал, газрын тосны газарт дөрвөн аймгийн 10 сумын нутагт нийт 132.7 мянган гектар талбайд зургаан аж ахуйн нэгжийн цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын найм, хайгуулын таван тусгай 7 зөвшөөрлийг хүчин төгөлдөр бүртгэлтэй байна.

5.2.3. Стратегийн ач холбогдол бүхий ордууд

Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд эдийг засаг, нийгмийн хөгжилд нөлөөтэй байж болох эсвэл тухайн жилд нийт ДНБ-ний 5 хувиас илүү үйлдвэрлэх боломжтой болон үйлдвэрлэж байгаа зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27-р тогтоолоор дараах ордуудыг стратегийн ач холбогдолтой гэж үзсэн.

Хүснэгт 28. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд

№	Ордууд	Ашигт малтмалын төрлүүд	Байршил	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд	Эзэмшлийн хувь	
					ТӨР	ААН
1	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Эрдэнэс Монгол ХХК	100	-
2	Багануур	Нүүрс	Улаанбаатар, Багануур	Багануур ХХК	75	25
3	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Бороо гоулд	-	100
4	Бүрэнхаан	Фосфотит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Сутайхан цо ХХК Топруонхэнцо ХХК	-	100

№	Ордууд	Ашигт малтмалын төрлүүд	Байршил	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд	Эзэмшлийн хувь	
					ТӨР	ААН
				Талст Маргад ХХК		
5	Гурванбулаг	Уран	Дорнод, Дашбалбар	-	-	-
6	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар	-	-	-
7	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Адамасмайнинг ХХК	-	-
8	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монголын Алт МАК ХХК	-	100
				Чинхуа МАК НС ХХК		
				Саусгоби сэндс ХХК		
				Өсөх зоос ХХК		
9	Оюу толгой	Зэс, Алт	Өмнөговь, Ханбогд	Оюу толгой ХХК	34	66
				Онтрэ ХХК		
10	Таван толгой	Нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК	51	49
				Энержи Ресурс ХХК	-	100
				Эрдэнэс - Тавантолгой ХК	100	-
11	Төмөртэй	Төмөр	Сэлэнгэ, Хүдэр	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	100	-
12	Төмөртэйн овоо	Цайр	Сүхбаатар, Сүхбаатар	Цайрт минерал ХХК	-	100
13	Шивээ овоо	Нүүрс	Говьсүмбэр, Сүмбэр	Шивээ-Овоо ХК	90	10
				Эрдэнэс Монгол ХХК		
				Эйкүсора ХХК		
14	Цагаан суварга	Зэс, Молибден	Дорноговь, Мандах	Эрдэнэс Цагаан Суварга ХХК	-	100
				Монголын Алт МАК ХХК		
15	Эрдэнэтийн овоо	Зэс, Молибден	Орхон, Баян-Өндөр	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	100	-

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын зарим ордын талбайд хил заагийг тогтоох тухай” 300 дугаар тогтоолоор Нарийн сухайт, Тавантолгой, Шивээ-Овоо, Багануур зэрэг нүүрсний орд, Цагаан суваргын зэс, молибден, Бүрэнхааны Фосфорит, Эрдэнэтийн зэс, молибдений орд зэрэг 7 ордын талбайн хил заагийг 2018 онд Засгийн газар тодорхой болгосон байна.

5.2.4. Бичил уурхай

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уул уурхай

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг бичил уул уурхай олборлолт гэж тодорхойлдог.

5.2.4.1. Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсад хууль бус олборлолтоос үүдэлтэй хүний эрхийн зөрчил, хавчилга дарамтын он жилүүд өнгөрч, бичил уурхайчид албан эдийн засагт оролцох, эрхээ

баталгаажуулахад томоохон ахиц гаргаад байна. 10 гаруй жилийн өмнөхөн гар аргаар ашигт малтмал олборлох нь олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарах, хууль бусаар олборлолт явуулах, хүний эрхийг зөрчих, хууль бусаар хоригдох, бие махбодын хүчирхийлэлд өртөх, нийгмийн халамжийн наад захын үйлчилгээнээс тусгаарлагдах зэрэг байдалд хүргэдэг байлаа.

2010 оны 7-р сард Ашигт малтмалын тухай хууль болон Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлтүүд орж, 2010 оны 12-р сард “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсанаар бичил уурхайн эрх зүйн зохицуулалт бий болсон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон бусад бичил уурхайн салбарын хамтрагч байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” шинэчлэн баталсан. 2014 оны 1-р сард УИХ-ын 18-р тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” /2014-2025 он/ батлагдсан. Энэхүү бодлогын баримт бичигт тусгасны дагуу Монгол Улсын Засгийн газар нь холбогдох эрх зүйн зохицуулалтаар дамжуулан бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэд хууль ёсны бүтцээр хоршин ажиллахыг дэмжихээр болсон байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ерөнхий зүйл
- Ашигт малтмал олборлох өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх
- Бичил уурхай эрхлэгч этгээдийн үүрэг
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай
- Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг
- Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг
- Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүрэг
- Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг
- Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг
- Бичил уурхайн мэргэжлийн холбооны эрх үүрэг
- Талбайг буцааж хүлээлгэн өгөх
- Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

Уг журам хэрэгжиж эхэлснээр бичил уурхай эрхлэгчид төрийн үйлчилгээ авах боломжтой болж, нөхөн сэргээлт хийдэг болсон байна.

5.2.4.2. Бичил уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уурхай эрхлэгчид нь олборлосон алтаа албан ёсны сүлжээгээр дамжуулан борлуулснаар Монгол банкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаагаас гадна шууд болон шууд бусаар ажлын байрыг бий болгож үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна. Монгол улсын алтны нийлүүлэлтийн сүлжээ бүрэн албажаагүй хэвээр байгаа ч Монгол дахь алтны сүлжээний сүүлийн шат буюу Монголбанканд алт тушааснаар энэ сүлжээ нь албан ёсных болдог.

Хүснэгт 29. Монгол банканд иргэдийн тушаасан алт

Он/сар	Нийт тушаасан алт /г/	Иргэдийн тоо	Иргэдийн тушаасан алт /г/
2022/01	1,659,009.40	34	840,430.20
2022/02	795,308.10	32	260,404.40
2022/03	985,660.20	28	350,809.40
2022/04	358,900.50	15	41,208.60
2022/05	2,151,971.00	46	990,742.40
2022/06	1,962,605.60	53	817,767.00
2022/07	1,759,586.80	26	644,249.00
2022/08	2,915,481.30	34	1,028,306.80
2022/09	2,416,439.10	28	727,486.60
2022/10	2,196,840.40	19	880,752.80
2022/11	2,667,034.80	35	1,215,084.40
2022/12	3,032,223.80	42	1,128,884.40
Нийт	22,901,061.00	392	8,926,126.00

Эх сурвалж: Монгол банк

Монголбанканд нийт тушаасан алтны 39 хувийг иргэдийн тушаасан алт эзэлж байгаа бөгөөд энэхүү үзүүлэлт нь бичил уул уурхайн эдийн засагт үзүүлж байгаа нөлөө их гэдгийг харуулж байгаа юм.

5.2.4.3. Бичил уурхайн талаарх мэдээллийн тархац, эх сурвалж

Монголын бичил уурхай эрхлэгчдийн талаар болон дэлгэрэнгүй статистик мэдээллийг УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ болон Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооноос авах боломжтой.

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь 2013 оны 5 дугаар сарын 2-ны өдөр бичил уурхайчдын анхдугаар их хурлаар үүгэн байгуулагдаж өнөөг хүртэл тогтвортой, амжилттай ажиллаж байна. Уг байгууллага нь Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайн салбарыг хөгжүүлэх, тус салбарын эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой байдлыг хангах, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, тэдний чадавхжуулах зэрэг олон чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран байнгын идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Эдүгээ Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь 15 аймгийн 45 суманд 70 гишүүн байгууллагуудтай, 429 нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон нийт 6500 гаруй гишүүдтэй.

Хүснэгт 30. Бичил уурхайгаар олборлох дүгнэлт гарсан талбай, га

№	Аймгууд	Дүгнэлт гарсан талбай		Хэмжээ	
		Тоо	Хувь	Га	Хувь
1	Бүгд	262	100	1063.7	100
2	Архангай	1	0.4	4.7	0.4
3	Баян-Өлгий	2	0.8	53.7	5.1
4	Баянхонгор	57	21.8	152.2	14.3
5	Булган	29	11.1	126.	11.9
6	Говь-Алтай	1	0.4	5.7	0.5
7	Дархан-Уул	6	2.3	16.5	1.6
8	Дорноговь	2	0.8	9.5	0.9
9	Дорнод	2	0.8	26.2	2.5
10	Дундговь	13	5.0	104.5	9.8

№	Аймгууд	Дүгнэлт гарсан талбай		Хэмжээ	
		Тоо	Хувь	Га	Хувь
11	Өвөрхангай	20	7.6	39.7	3.7
12	Өмнөговь	20	7.6	86.2	8.1
13	Сэлэнгэ	52	19.8	220.0	20.7
14	Төв	12	4.6	78.3	7.4
15	Улаанбаатар	5	1.9	18.9	1.8
16	Ховд	4	1.5	11.2	1.1
17	Хэнтий	36	13.7	109.4	10.3

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022 он, АМГТГ

АМГТГ-ын 2022 оны статистикийн мэдээгээр Бичил уурхайгаар олборлох дүгнэлт гарсан талбай нийтдээ 1063.7 га бөгөөд хамгийн их хувь эзэлж байгаа нь Сэлэнгэ, Баянхонгор аймгууд байгаа бол хамгийн бага нь Архангай, Говь-Алтай зэрэг аймгууд байна.

5.2.4.4. Нөхөн сэргээлтийн байдал

Олборлолт эхлэхийн өмнө бичил уурхай эрхлэгч нь сумын нөхөн сэргээлтийн санд нөхөн сэргээлтийн барьцаа байршуулдаг (жишээ нь 3,000,000 төгрөг буюу 1,052 ам.доллар) бөгөөд бичил уурхайн байгууллага тухайн талбайг нөхөн сэргээлгүй хаяж явсан тохиолдолд тус хөрөнгийг ашиглана. Гэвч орон нутгийн удирдлага уг мөнгийг зориулалтаар нь зарцуулдаг эсэх, эсвэл бичил уурхайн байгууллагад нөхөн сэргээлтийн ажил хийхэд туслах зорилгоор цаг тухайд нь мөнгийг гаргаж өгсөн эсэх нь тодорхойгүй бөгөөд тухайн санд хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалтыг тайлагнадаггүй, мэдээлэл нь хаалттай байна.

2022 оны “Монгол улс дахь Алтны бичил уурхайн салбарын эрх зүйн орчны дүн шинжилгээ” бодлогын тайланд авсан судалгаагаар уурхайчдын 82% нь үйл ажиллагаа явуулсан уурхайн талбайд нөхөн сэргээлт хийдэг гэж хариулжээ. Зөвхөн 9% нь нөхөн сэргээлт хийгээгүй гэж хариулсан бол 2% нь нөхөн сэргээлт хараахан хийгээгүй үлдсэн 7% нь мэдэхгүй гэж хариулжээ. Бичил уурхайн талбайдаа нөхөн сэргээх ажилд оролцсон гэж хариулсан уурхайчдын, гуравны хоёр нь (69%), нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ухсан нүхийг дүүргэж, битүүлсэн гэж тэмдэглэжээ.

График 2. Нөхөн сэргээлт хийсэн байдал



Эх сурвалж: Монгол Улс дахь Алтны бичил уурхайн салбарын эрх зүйн орчны дүн шинжилгээ (хувилбар 3.0)

5.2.5. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа

2022 оны 4-р сарын 12-ны өдөр Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам (“Тусгай зөвшөөрөл олгох журам” гэх) шинэчлэгдэн батлагдаж, 2018 онд батлагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам хүчингүй болсон байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-ын хүрээнд геологийн судалгааг эрчимжүүлэх, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх зорилтын дор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахимжуулах замаар тендер сонгон шалгаруулалтын үйл явцыг шуурхай, ил тод явуулах орчныг бүрдүүлэх зорилгоор Тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн батлав. Тус Журам батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ уламжлалт хэлбэрээр гаргах буюу шаардлагатай бичиг баримтыг нэг бүрчлэн хэвлэн гарын үсэг зурж, битүүмжлэн хүргүүлдэг байхыг шаарддаг байсан.

Тусгай зөвшөөрөл олгох журмаар энэхүү консерватив аргыг халж, тендер сонгон шалгаруулалтын ажиллагааг бүхэлд нь ил тод, шударга ёсны зарчмын дагуу олон нийтийн хяналт дор цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна.

5.2.6. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Тайлант жилийн оны эцсийн байдлаарх ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр ангилан дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 31. Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр

№	Газар нутаг	Бүгд			Үүнээс					
		Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Ашиглалт			Хайгуул		
					Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Бүгд	2,544	5,950.6	3.9%	1,713	1,836.5	1.2%	831	4,114.1	2.6%
2	Архангай	30	29.9	0.5%	21	11.8	0.2%	9	18.0	0.3%
3	Баян-Өлгий	68	214.7	4.7%	30	16.7	0.4%	38	198.0	4.3%
4	Баянхонгор	133	308.7	2.7%	100	167.3	1.4%	33	141.4	1.2%
5	Булган	110	187.9	3.9%	82	41.9	0.9%	28	145.9	3.0%
6	Говь-Алтай	123	527.7	3.7%	60	105.3	0.7%	63	422.4	3.0%
7	Говьсүмбэр	16	44.6	8.1%	13	38.9	7.0%	3	5.8	1.0%
8	Дархан-Уул	64	13.6	4.2%	61	8.3	2.6%	3	5.3	1.6%
9	Дорноговь	338	999.9	9.1%	213	268.1	2.5%	125	731.8	6.7%
10	Дорнод	151	526.2	4.3%	73	68.2	0.6%	78	458.0	3.7%
11	Дундговь	188	547.9	7.3%	122	182.8	2.4%	66	365.1	4.9%
12	Завхан	41	154.3	1.9%	13	21.3	0.3%	28	133.0	1.6%
13	Орхон	14	17.6	21.0%	9	10.7	12.7%	5	6.9	8.2%
14	Өвөрхангай	54	150.9	2.4%	30	18.1	0.3%	24	132.8	2.1%
15	Өмнөговь	156	820.5	5.0%	107	486.1	2.9%	49	334.4	2.0%
16	Сүхбаатар	87	247.8	3.0%	68	56.1	0.7%	19	191.7	2.3%
17	Сэлэнгэ	172	90.5	2.2%	139	47.0	1.1%	33	43.5	1.0%
18	Төв	380	349.0	4.7%	304	160.7	2.2%	76	188.3	2.5%
19	Увс	98	248.9	3.6%	46	21.2	0.3%	52	227.7	3.3%
20	Улаанбаатар	96	10.0	2.1%	92	9.8	2.1%	4	0.2	0.05%
21	Хөвсгөл	21	10.3	0.1%	21	10.3	0.1%	0	0.0	0.0%

№	Газар нутаг	Бүгд			Үүнээс					
					Ашиглалт			Хайгуул		
		Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
22	Ховд	78	192.0	2.5%	36	29.5	0.4%	42	162.5	2.1%
23	Хэнтий	203	257.7	3.2%	128	56.5	0.7%	75	201.3	2.5%

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022 он, АМГТГ

Тусгай зөвшөөрлийн тоогоор Дорноговь, Төв, Хэнтий Дундговь аймгууд тэргүүлдэг бол ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг нийт нутаг дэвсгэрт харьцуулж үзвэл Дорноговь, Дундговь, Орхон аймгууд тэргүүлдэг байна.

5.2.6.1. Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрх, үүргийн зохицуулалтууд

Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан байдаг тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 32. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд

Хуулийн заалтын дугаар	Эрх, үүрэг бүхий талууд	Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх, үүрэг
8.1.5.	УИХ	Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох
9.1.11.	Засгийн газар	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх
11.1.13.	Төрийн захиргааны байгууллага, Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон сонгон шалгаруулалтын комисс	Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох, дүгнэлт гаргах
11.1.16.	Төрийн захиргааны байгууллага	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг өргөдлийг хүлээн авч бүртгэх
11.1.19	Төрийн захиргааны байгууллага	Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох
11.1.25	Төрийн захиргааны байгууллага	Энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах
20.1	Төрийн захиргааны байгууллага	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулах
26.1	Төрийн захиргааны байгууллага, АМГТГ	Энэ хуулийн 25.1-д заасан өргөдлийг хүлээн авч, хянан, шийдвэрлэх

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль

5.2.6.2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Хүснэгт 33. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгож, өргөдөл хүлээн авна.
2	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, боломжтой эсэхийг тогтооно.
3	Орон нутгийн засаг захиргаа	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.
4	АМГТГ	Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө.
5	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 удаа тус бүр 3 жилийн хугацаатай сунгаж болно.

Эх сурвалж: АМГТГ

Өөрийн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг байршилд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч нь бусад өргөдөл гаргагч талуудаас давуу эрхтэй байдаг.

Хүснэгт 34. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Хүсэлт хүлээн авна
2	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хуулиар хориглосон зүйлс байгаа эсэх эсвэл барагдуулаагүй төлбөр байгаа эсэхийг тодорхойлно
3	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Кадастрын системд хайгуулын тусгай зөвшөөрөл нь бүртгэгдсэн эсэхийг шалгана.
4	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Ашиглалтын талбай нь бусад тусгай зөвшөөрлийн газар, усны нөөц, улсын тусгай хэрэгцээний газар болон нөөцөд авсан талбай зэрэг газруудтай давхацсан эсэхийг шалгана.
5	АМГТГ-ын Уул Уурхайн болон Нүүрсний хэлтэс	Хүсэлт гаргагч нь олборлолтоос үүсэж болох экологийн хохирлыг нөхөн сэргээх боломжтой эсэхийг шалгана.
6	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хүсэлт гаргагч нь Кадастрын хэлтсийн даргын гаргасан төлөвлөгөө болон бусад хууль, дүрэм, журмуудыг дагаж мөрдөж буй эсэхийг шалгана
7	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Координатаар тогтоосон талбайн зургийг зөвшөөрөх: АМГТГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
8	АМГТГ	Мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө.
9	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд, дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатай сунгаж болно.

Эх сурвалж: АМГТГ

Дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг нийтэд нээлттэй болгож сонгон шалгаруулах замаар олгоно. Үүнд:

- Хайгуулын ажил хийсэн аж ахуйн нэгж нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй;
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбайд;
- Зохих хууль журмыг эсвэл шүүхийн шийдвэрийг зөрчсөнөөс үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг буцаан авсан;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан.

Хүснэгт 35. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Сонгон шалгаруулах үйл явцыг эхлүүлж захирамж гаргана.
2	АМГТГ	Олон нийтэд сонгон шалгаруулалтыг зарлана.
3	АМГТГ	Сонгон шалгаруулалтын саналыг авна. Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
4	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтын саналыг нээнэ
5	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад оролцогчдыг ирүүлсэн баримтуудад үндэслэн үнэлнэ
6	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг нээнэ.
7	АМГТГ	Сонгон шалгаруулалтын саналд үнэлээ хийж дууссанаас хойш 5 хоногийн дотор ялагчийг зарлана.
8	АМГТГ	Шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг 10 хоногт багтаан төлөх тухай мэдэгдэл өгнө. Бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг өгнө.
9	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГТГ-ын даргын болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг олгоно

Эх сурвалж: АМГТГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд аж ахуйн нэгжийн хооронд бүрэн буюу хэсэгчлэн шилжүүлж болно. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно
- Хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Аж ахуйн нэгж эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг худалдан авч, зохих албан татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Аж ахуйн нэгж нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт худалдан авч зохих татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

Хүснэгт 36. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Холбогдох бичиг баримтуудыг хүлээн авна
2	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Бичиг баримтууд болон бусад мэдээлэлд шалгалт хийнэ.
3	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Шалгах ажиллагаа дууссаны дараа 5 хоногт багтаан шийдвэр гаргана.

Эх сурвалж: АМГТГ

Тусгай зөвшөөрөл олгоход ашигладаг техникийн шалгуур үзүүлэлтүүд (Шаардлага 2.2..а)

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/275 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам" дахь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын техникийн саналын үнэлгээний хуудсыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 37. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын техникийн саналын үнэлгээний хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Огноо
1	Төслийн баримт бичгийн үнэлгээ	-	2-18
	Талбайн геологи, хайгуулын ажлын төлөвлөлт	12	-
1.1	Геологи, хайгуулын ажлыг оновчтой, гүйцэд төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг бүрэн судалж, байж болох бүх төрлийн ашигт малтмалын үнэлгээ өгсөн байх, арга аргачлалд судалгааны ажил зохимжтой зөв төлөвлөгдсөн байх.	10-12	-
	Геологи хайгуулын ажил төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг гүйцэт судлаагүй, хайгуулын шатны ажлуудыг ерөнхийд нь төлөвлөсөн байх.	6-9	-
	Геологи, хайгуулын ажлын төлөвлөлт хангалтгүй: Хайгуулын талбайн мэдээлэлтэй бүрэн танилцаагүй, судалгааны ажлын зорилго тодорхой бус, хайх ашигт малтмалын эрлийн ажил оновчтой бус.	2-5	-
1.2	БОХ, нөхөн сэргээх ажил, зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг тооцсон төлөвлөлт, мэдээлэл	0-6	-
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалттай/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалттай төлөвлөгдсөн байх	5-6	-

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Огноо
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг алдаатай төлөвлөсөн байх /төлөвлөсөн/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалтгүй, дутуу төлөвлөгдсөн байх	3-4	--
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалтгүй/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд буруу төлөвлөсөн зардал хангалтгүй байх	0-2	
2	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар		2-7
	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал	4	-
2.1	Төслийг гүйцэтгэх өөрийн үндсэн ажилтантай буюу ИТА болон Геологичид 100 хувь хангагдсан эсэх (НДШ төлөлтийн тодорхойлолт, бусад нотолгоотой байх).	4	-
	Төслийг гэрээгээр гүйцэтгүүлэх бол (ИТА болон Геологичид <99 хувь).	0-3	-
2.2	Мэргэжлийн боловсон хүчний туршлага, чадвар	3	-
	Монгол Улсын Зөвлөх геологич ажилладаг	3	-
	Монгол Улсын Мэргэшсэн геологич ажилладаг	2	-
	Аль аль нь байхгүй	1	-
3	Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжийн мэдээлэл үнэлгээ (Гэрээ болон хавсралтаар баталгаажсан байна.)		0-5
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өмчийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол (өрмийн нотлох хавсралтууд)	5	-
3.1	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг түрээсэлдэг эсвэл гэрээгээр хайгуулын ажил гүйцэтгүүлэх бол (Хамтран ажиллах гэрээ)	3-4	-
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх техник Тоног төхөөрөмжийн мэдээлэл ирүүлээгүй болон алдаатай, ирүүлсэн бол	0-2	-
Нийт оноо		30 хүртэл	

5.2.6.3. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Монгол Улсын Цөмийн энергийн тухай хуулиар энэ үйл ажиллагаа нь зохицуулагддаг ба тус хуулийн 18 дугаар зүйл “Тусгай зөвшөөрөл олгох журам”-аар нарийвчлан зохицуулагддаг ба дараах үе шатаар явагддаг.

Хүснэгт 38. Цацрагт идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Цөмийн энергийн комисс	Санал гаргана.
2	Тагнуулын төв байгууллага	Санал гаргана.
3	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Санал гаргана.
4	АМГТГ	Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичгүүдийг шалгаж, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага хангасан эсэхийг тодорхойлно.
5	АМГТГ	Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 1-3 сарын дотор, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 6-12 сарын дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
6	АМГТГ	Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.
7	АМГТГ	Шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлнэ.

Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;
- Бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачилгатай оролцдог байх;
- Компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;
- Үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх санхүүгийн чадавхтай байх;
- Байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхтай байх;
- Хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар зохих туршлага хуримтлуулсан байх;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.

Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Дээр дурдсан хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах бүх шаардлагуудыг хангах;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт хийх санхүүгийн чадавхтай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх;
- Цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх.

5.2.6.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь Монгол улсын Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар

зохицуулагддаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах үе шатаар явагддаг.

Хүснэгт 39. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэж, хүлээн авна.
2	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, өргөдлийн материалын иж бүрдлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд бүртгэсэн даруйд нь анхан шатны шүүлт хийж, шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
3	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон, түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоолгох өргөдлийг холбогдох материалын хамт төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.
4	Төрийн захиргааны байгууллага	Өргөдөлд дурдсан талбай, холбогдох баримтуудыг шалган үзээд, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой, эсхүл боломжгүй талаар мэдэгдэнэ.
5	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжгүй талаар хариу ирвэл өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
6	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжтой талаар хариу ирвэл тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
7	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдэгдвэл тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.
8	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдвэр гарснаас хойш өргөдөл гаргасан этгээд нэг сарын дотор тусгай зөвшөөрлийг аваагүй, эсхүл эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.
9	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлсөн бол ажлын таван өдөрт багтаан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.
10	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тухайн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай байрших аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад түгээмэл тархацтай ашигт

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
		малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон тухай мэдэгдэнэ.
11	Төрийн захиргааны байгууллага	Хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 40. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэж, хүлээн авна.
2	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрд бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгнө.
3	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийнэ.
4	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
5	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол өргөдөл гаргасан талбай нь хайгуулын талбайн хилийн дотор бүрэн багтаж байгаа эсэхийг тодруулна.
6	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэгэн байдлаар давхцаж байгаа эсэхийг тодруулна.
7	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсэж болох байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэхийг тодруулна.
8	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 15 өдөрт багтаан доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
9	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлүүлнэ.
10	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайн аль нэг хэсэгтэй

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
		давхацсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, татгалзсан шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн статистик мэдээлэл

2022 онд хүчингүй болсон 114 тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг энэ тайлангийн Хавсралт 15д-д харуулав.

5.2.6.5. 2022 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд (шаардлага 2.2.а)

Ашигт малтмал газрын тосны газраас ирүүлсэн 2022 онд шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 41. 2022 онд шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүд

ТЗ-ийн дугаар	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	Шинэ үүссэн Т/З	Регистр	Шинэ эзэмшигч
MV-021354	Буянт	177.41	ГААС	-	5878756	Хөх бишрэлт
MV-021088	Туулын полигоны зүүн дэнж	30.53	Голден хаммер	-	6047424	Булган майнинг
MV-018976	Дарцагт	1,304.81	Альшаа хайрхан	-	6723535	Вай эйч графит нэчүрал
MV-000203	Хүдэр	21.74	Уулсноён	-	5614546	Хайрхан уулын нөмөр
MV-021972	Туулын их тохойрол	31.75	Глиймстар	-	6171346	Вайнд Майнд
MV-021251	Мөнхтийн цагаан дөрвөлжин	239.68	Литиуммайнинг	-	6836437	Блүү вэйл ресурс
MV-000169	Дунд өлөнт	12.77	Улз гол	-	4286596	Өсөх билиг эрдэнэ
MV-007978	Цагаан гозгор	232.10	Хурай	-	5533538	Монгол экспресс Эм Эн
MV-005484	Хүйтэн	149.56	Амьюс	-	6159737	Майнинг энд оперэйшн
MV-021355	Бумбат-5	8.33	Заамар гоулд	-	6858422	Их асур
MV-017512	Их булаг	388.62	Ай Ай Жэй Эй Эй	-	5987652	Жю бан сеок
MV-016852	Салхит бор толгой	190.58	Резервоирмонголиа	-	6836437	Блүү вэйл ресурс
MV-021203	Тохой-1	50.83	Олз газар	-	5355141	Энхзоо
MV-000436	Өртөнт, Нарийн жалга	40.64	Царигшонхор	-	6862578	Эм Эс бэл майнинг
MV-001231	Улаан-Овоо	175.74	Рэдхилмонголиа	MV-022059	5002265	Юү Жи Эл интерпрайзис
MV-021068	Бумбат-5	175.78	Заамар гоулд	MV-022118	5835704	Тамсаг алт трейд

Эх сурвалж: АМГТГ

2022 онд хүчинтэй байгаа 2,043 тусгай зөвшөөрөл (Хавсралт 15а) байгаа бөгөөд хайгуулын 52 тусгай зөвшөөрөл шилжсэнийг Хавсралт 15в-д, 57 тусгай зөвшөөрөл шинээр олгосныг Хавсралт 15б-д харуулав.

5.2.6.6. Тусгай зөвшөөрлийн ил тод байдал (шаардлага 2.3)

АМГТГ-ын кадастрын цахим хуудсанд (<https://cmcs.mrpm.gov.mn/cmcs>) 2022 оны байдлаар 2,713 тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгосон байна.

Хүснэгт 42. Тусгай зөвшөөрлийн ил тод байдал

Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн мэдээлэл ил тод эсэх
АМГТГ	Үгүй
МОУИТБС-ын Ажлын алба	Үгүй

МОУИТБС-ын Ажлын алба цахим хуудсанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаар мэдээллийг ил тод болгох үүрэгтэй боловч 2019 оноос хойш ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл ороогүй байна.

5.3. Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл, экспорт (Шаардлага 3.1)

5.3.1. Ашигт малтмалын хайгуул

2022 онд эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан компаниудыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 43. 2022 онд эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан компаниуд

№	Гэрээт компанийн нэр	Төрөл	Гэрээ байгуулсан огноо
1	Жейд газ Монголиа ХХК	Нүүрсний давхаргын метан хий	2022.01.27
2	Баруун наран газ Монголиа ХХК	Нүүрсний давхаргын метан хий	2022.07.22
3	Ууганбулаг ХХК	Газрын тос	2022.12.23

Бүтээгдэхүүн хуваах гэрээт хайгуулын талбайнуудад 2022 онд хийгдсэн ажлууд:

- Эргэл XII талбайд 550,9 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа;
- Төхөм X урд талбайд 500 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа;
- Номгон IX талбайд 341 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 19 цооног нийт 11,133 тууш.м өрөмдлөг. Метан хийн туршилтын олборлолт;
- Тавантолгой XXXIII талбайд 10 цооног нийт 7,262.5 тууш.м өрөмдлөг;
- Гурвантэс XXXV талбайд 20 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 5 цооног нийт 2,321.8 тууш.м өрөмдлөг;
- Т1 талбайд 100 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 1 цооног 163 тууш.м өрөмдөж, орон нутгийн эсэргүүцлийн улмаас зогссон;
- Богд IV талбайд 66 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа,
- Онги V талбайд 2 цооног нийт 1,271 тууш.м өрөмдлөгийн ажил тус тус хийгдсэн.

Эрлийн гэрээ хэрэгжиж буй 6 гэрээ:

- Газрын тосны эрлийн 1 гэрээ
- Нүүрсний давхаргын метан хийн эрлийн 5 гэрээ

Хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын үйл ажиллагаа

Тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэсэн тайлан, зардал хянуулсан, баталгаажуулсан байдлын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүрийн хайгуулын ажлын төлөвлөгөө, 48.1.2-д заасны дагуу хайгуулын ажлын жил тайланг хүлээн авч хянах бөгөөд 33.1, 33.2-т заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянаж, санхүүгийн жилийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулдаг.

2022 онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хайгуулын ажилд 157,707,6 сая төгрөг зарцуулсан ба явуулсан үйл ажиллагааны задаргаагаар өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 44. Геологи, хайгуулын ажилд зарцуулсан, гүйцэтгэсэн ажлын төрлөөр, сая төгрөгөөр

Ажлын төрөл	2021		2022	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Бүгд	102,519.5	100	157,707.6	100
Бэлтгэл ажил	2,827.9	2.8	2,041.2	1.3
Талбайн зураглал	1,581.6	1.5	1,266.7	0.8
Эрлийн маршрут	1,325.4	1.3	761.0	0.5
Талбайн сорьцлолт	1,069.3	1.0	126.2	0.1
Геофизикийн ажил	3,625.7	3.5	4,685.4	3.0
Уулын ажил	1,219.2	1.2	1,214.0	0.8
Өрөмдлөг	63,058.2	61.5	108,498.6	68.8
Сорьцлолт	3,247.7	3.2	5,831.3	3.7
Лабораторийн ажил	6,811.3	6.6	9,227.7	5.9
Тээвэр	3,017.3	2.9	3,145.3	2.0
Топогеодезийн ажил	885.6	0.9	898.8	0.6
Гидрогеологийн судалгаа	992.0	1.0	953.8	0.6
Геоэкологийн судалгаа	69.7	0.1	167.1	0.1
Археологи, палеонтологийн судалгаа	354.5	0.3	201.1	0.1
БОНС-ын зардал	517.3	0.5	1,042.4	0.7
Суурин боловсруулалт	5,130.4	5.0	5,372.6	3.4
Магадалшгүй зардал	544.4	0.5	35.8	0.0
Бусад	6,241.9	6.1%	12,238.7	7.8%

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022 он АМГТГ

2022 онд зарцуулсан геологи хайгуулын зардлыг өмнөх онтой харьцуулахад 53.8 орчим хувиар өссөн бөгөөд өрөмдлөг, БОНС-ын зардал болон бусад зардлуудын хэмжээ хамгийн их нэмэгджээ.

5.3.2. Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Уул уурхай олборлох салбар нь 2022 оны байдлаар ДНБ-ны 23.6 хувийг бүрдүүлж байна нь эдийн засгийн үндсэн салбар болж хөгжиж байгааг илтгэж байна.

Хүснэгт 45. Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая төгрөгөөр

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
ДНБ	36,958.6	43,555.4	53,851.5
Уул уурхай, олборлох /үнээр/	7,994.0	10,753.7	12,402.4
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	16,700.0	18,538.0	20,537.8

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
ДНБ-д УУО салбарын эзлэх хувь	21.6%	25.4%	23.6%
ДНБ-д Аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь	56.5%	42.6%	38.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын цаг агаарын эрс тэрс уур амьсгалаас шалтгаалан нүүрсний олборлолт болон борлуулалтын хэмжээ өсөж буурдаг байна. 10-12 сард нүүрсний олборлолт борлуулалт хамгийн их байдаг бол 3-5 сард хамгийн бага үзүүлэлттэй байдаг байна.

Хүснэгт 46. Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспорт

Хугацаа	Олборлолт /мян.тн/	Борлуулалт /мян.тн/	Экспорт /мян.тн/
2022	39,340.0	39,122.9	27,545.1
2022.I	2,163.5	1,636.2	443.1
2022.II	1,626.4	1,571.1	503.1
2022.III	2,046.8	1,949.1	981.6
2022.IV	2,344.6	1,427.2	680.0
2022.V	1,923.6	1,433.9	832.3
2022.VI	2,129.5	2,287.1	1,757.4
2022.VII	2,304.8	2,936.1	2,434.6
2022.VIII	3,601.9	3,821.1	3,083.2
2022.IX	4,249.4	4,941.4	3,849.9
2022.X	5,128.2	5,295.3	3,954.4
2022.XI	5,417.9	5,530.4	4,181.5
2022.XII	6,403.4	6,294.7	4,844.2

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022 АМГТГ

Хүснэгт 47. Уул уурхайн голлох бүтээгдэхүүний олборлолт

№	Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2021	2022
1	Нүүрс	мян.тн	43,079.3	37,294.7
2	Зэсийн баяжмал	мян.тн	1,326.3	1,189.8
3	Алт	тн	19.1	19.4
4	Молибдений баяжмал	мян.тн	6,326.0	5914.2
5	Төмрийн хүдэр	мян.тн	9,171.9	7659.9
6	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	3,676.8	1728.1
7	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	118.3	122.9
8	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	60.3	24.5
9	Цайрын баяжмал	мян.тн	75.2	399.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайгаас үндсэн 9 төрлийн ашигт малтмалыг олборлож байгаа бөгөөд 2022 оны олборлолтыг өмнөх онтой харьцуулахад нүүрс 5,784.6 мян.тн буюу 13.4 хувь, алт 1,171.1 кг буюу 5.8 хувь, төмрийн хүдэр 52.5 мян.тн буюу 0.6 хувь, төмрийн хүдрийн баяжмал 136.5 тн буюу 10.3 хувь, хайлуур жоншны хүдэр 9.0 мян.тн буюу 7.1 хувь, хайлуур жоншны баяжмал 24.7 мян.тн буюу 29.1 хувь, цайрын баяжмал 1.1 мян.тн буюу 1.5 хувиар буурсан байна.

5.3.3. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт (шаардлага 6.3)

Доорх хүснэгтэд Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнийг харуулав

Хүснэгт 48. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ /ам.доллар/

Барааны төрөл	Хэмжих нэгж	12 дугаар сар (өссөн дүнгээр)		Өөрчлөлт	
		2021	2022	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	175.8	205.0	29.1	16.6
Зэсийн баяжмал	тн/ам.дол	2,261.1	1,881.8	-379.2	-16.8
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	134.0	82.6	-51.4	-38.3
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,566.6	2,006.5	440.0	28.1
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	223.4	285.0	61.5	27.5
Алт	тн/ам.дол	58,234.4	57,345.0	-889.4	1.5

Эх сурвалж: Уул уурхайн яам

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 3,026.0 сая ам.доллар буюу 40.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 49. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Барааны төрөл	12 дугаар сар (өссөн дүнгээр)		Өмнөх оны мөн үеэс	
	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	2,899.9	2,734.8	-165.0	-5.7
Нүүрс	2,763.9	6,495.1	3,731.1	135.0
Төмрийн хүдэр	952.2	391.0	-561.2	-58.9
Цайрын баяжмал	176.4	283.3	106.9	60.6
Алт	1,004.5	1,127.4	122.9	12.2
Боловсруулаагүй нефть	273.4	241.8	-31.5	-11.5
Катодын зэс	88.5	82.5	-6.0	-6.8
Жоншны баяжмал	144.1	110.5	33.6	-23.3


Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 50. Уул уурхайн гол бүтээгдэхүүнүүдийн сүүлийн 10 жилийн үйлдвэрлэл

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Нүүрс /мян.т/	28561	29163.6	24927.1	24148.9	35488.9	43899.8	48863.8	50011.57	42863.63	30124.37	37294.7
Газрын тос /мян.баррел/	3635.9	5129	7405.3	8769.1	8249.8	7624.3	6388.5	6876.06	4105.88	4667.13	2565.4
Зэсийн баяжмал, металл агуулгаараа /мян.т/	517.9	803	1080.4	1334.7	1445.1	1317.6	1310.8	1262.4	1276.75	1326.31	1183.8
Молибдений баяжмал, металл агуулгаараа /т/	3933.9	3732.1	4054	5207	5174.4	5759.6	5486.1	5302.8	6147.7	6326.06	5914.2
Алт /кг/	5977.2	8900.8	11503.8	14532.8	18435.7	19849	20655.23	16251.31	20225.55	19054.41	19382.7
Төмрийн хүдэр /мян.т/	6898	5011.9	6293.1	4273.6	4936.2	7694.7	6225.37	8572.2	9224.44	9171.93	7659.9
Төмрийн хүдрийн баяжмал /мян.т/	5214.1	6124	3967.4	1899.8	2209.9	3675	3405.6	3386.36	4716.44	3676.78	1734.7
Хайлуур жонш /мян.т/	484.4	161.7	303	183.5	167.7	108.9	101.2	156.15	127.28	118.28	122.9
Хайлуур жоншны баяжмал /мян.т/	157.2	76.4	71.9	47.3	34.1	55.2	80.7	47.5	84.98	60.25	24.5
Цайрын баяжмал /мян.т/	119.1	104.1	93.2	89.6	100.2	82.7	87.9	83.08	76.29	75.2	400.1
Буталмал чулуу /мян.м³/	232.5	230.4	249	141	101.4	151	177.2	213.53	324.34	247.17	181.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Уул уурхайн гол бүтээгдэхүүний сүүлийн 10 жилийн үйлдвэрлэл



Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 21,244.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 3,836.0 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 18.9 их наяд төгрөг буюу 62.2 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Харин гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 18.0 их наяд төгрөг буюу 95.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлжээ.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 84.1 хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 51. Экспортоор тэргүүлэгч бүтээгдэхүүний 2022 оны экспортын тоо хэмжээ

Барааны төрөл	Хэмжих нэгж	12 дугаар сар (өссөн дүнгээр)		Өмнөх оны мөн үеэс	
		2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,282.5	1,453.3	170.8	13.3
Нүүрс	сая.тн	15.7	31.7	16.0	101.7
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	7.1	4.7	-2.4	-33.4
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	112.6	141.2	28.6	25.4
Алт	тн	17.2	19.7	2.4	14.0
Боловсруулаагүй нефть	сая.баррель	4.3	2.6	-1.7	-40.1
Катодын зэс	тн	9.8	10.0	0.2	1.6
Жоншны баяжмал	мян.тн	644.7	387.7	-256.9	-39.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Чулуун нүүс, хүрэн нүүрс, тунгаасан зэс ба хайлш, хайлуур жонш зэрэг 4 бүтээгдэхүүн хамгийн их дүнгээр экспортод гарсан байна.

График 4. 2022 оны уул уурхайн салбарын экспортын гүйцэтгэл


Эх сурвалж: УУХҮЯ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдээллээр манай улсын уул уурхайн салбарын экспортын гүйцэтгэл урьдчилсан төсөөлөлтэй уялдуулан харахад алт, нүүрс болон зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний хувьд хангалтгүй үр дүнг үзүүлсэн байна. Уул уурхайн экспортын гол бүтээгдэхүүний нэг болох нүүрсний экспортын төсөөллийн хэмжээ +176.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.4. Газрын тос болон байгалийн хий

5.4.1. Газрын тосны тухай тойм

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.9 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна. 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,723.5 сая ам.долларын 1,832.8 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 68.8 мян.тн буюу 3.9 хувиар, үнийн дүнгээр 591.8 сая ам.доллар буюу 52.3 хувиар тус тус өссөн байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 88.3 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 32.6 хувийг автобензин, 55.7 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 561.5 сая ам.долларын 680.5 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 107.8 мян.тн буюу 18.8 хувиар, үнийн дүнгээр 170.4 сая ам.доллар буюу 43.6 хувиар тус тус өссөн байна.

Дизель түлшний импорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 959.7 сая ам.долларын 982.0 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 369.6 сая ам.доллар буюу 62.6 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 6.9 мян.тн буюу 0.7 хувиар буурсан байна.

Газрын тосны ашиглалт: Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 33 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар 28 талбайд 31 гэрээлэгч Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ажиллаж байна. Үүнээс Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, БХГ-97 талбайд “Доншен Газрын тос (Монгол)” ХХК, Матад XX талбайд “Петроматад” ХХК тус тус газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

Газрын тосны олборлолт, экспортын талаар: ГЕГ, МХЕГ, ХХЕГ, ИХШХЕГ-ын орон нутаг дахь салбар байгууллага болон Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох хэлтсийн төлөөлөгч, мэргэжилтнүүд газрын тосны экспортын үйл ажиллагаанд газар дээр нь тогтмол хяналт тавьж ажилладаг. Хөндлөнгийн хяналтын эрх бүхий Амбер ХХК нь 1997 оны БХГ-т талбайгаас олборлон, экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг 2009 оноос, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлон экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг 2011 оноос тус тус хийж эхэлсэн. Түүнчлэн 2013 онд гаалийн хяналтын талбайг барьж дуусган, 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулсан.

Монгол Улсын хэмжээнд 1996-2022 оны хооронд нийт 75.98 сая баррель буюу 10.28 сая тонн тос олборлож, 72.81 сая баррель буюу 9.85 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолж газрын тосны орлогоос нийт 2.18 их наяд төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн.

Монгол Улсын хувьд газрын тосыг импортоор оруулж ирдэггүй зөвхөн газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж ирдэг учир газрын тосны экспорт болон газрын тосны бүтээгдэхүүний импортын сүүлийн 2 жилийн харьцуулалтыг дараах графикаар харуулав.

График 5. Газрын тосны экспорт болон газрын тосны бүтээгдэхүүний импорт



5.4.2. Байгалийн хийн тухай тойм

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй гурван компани 2019 оноос хойш Монгол Улсад метан хийн хайгуул хийж, туршилтын цооног өрөмдөх ажлыг эхлүүлжээ. Ингэснээр манай улсад метан хийн нөөцийг тогтоож, тэрхүү нөөцийг ашиглах боломжийг тодорхой болгох юм.

Дэлхийн улс орнууд метан хийг эрчим хүч, дулаан, химийн салбарт түгээмэл ашиглаж, үр ашгийг нь хүртсээр байна. Хийн түлшийг эрчим хүчнийхээ салбарт хэрэглэснээр томоохон хотууд агаарын бохирдлоосоо салж чадсан түүх бий. Монгол Улс нүүрсний арвин нөөцтэй. Энэ нөөцөө түшиглэн нүүрсний давхаргын метан хий олборлох бүрэн боломжтой гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна.


Метан хийн цооног өрөмдлөгийн ажлыг Өмнөговь аймгийн сав газрыг түшиглэн нэр бүхий гурван компани гүйцэтгэж байгаа нь "Жи Өү Эйч", "Метан газ ресурс", "Тэлмэн ресурс" аж. Австралийн Засгийн газрын техникийн туслалцааны хүрээнд Монгол орны нүүрсний давхаргын метан хийн хэтийн төлөвийн судалгааг метан хийн чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад дотоодын мэргэжилтнүүдээр хийлгэж, 7.4 триллион метр куб метан хийн баялаг байгааг тогтоосон байна.

5.4.3. Газрын тосны нөөц

Газрын тосны нөөцийн талаар: Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ)-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-өөр 2010-2012 оны хооронд Тосон-Уул XIX, Тамсаг-XXI болон 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-т талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг хэлэлцүүлж, дээрх талбайнуудын газрын тосны нөөцийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд хүлээн авсан. 2021 онд Матад XX талбайн нөөцийг нэмж хүлээн авсан.

Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн санд нийт 333.789 сая тонн газрын тос бүртгэгдсэнээс ашиглалтын баталгаат нөөц нь 43.4 сая тонн газрын тос байна. Энэхүү мэдээ нь АМГТГ-ын цахим хуудсанд 2022 оны байдлаар шинэчлэгдэж ороогүй байна.

График 6. Монгол Улсын хэмжээнд ашиглалтад шилжсэн орд газруудын газрын тосны нөөц, сая тонн



Эх сурвалж: АМГТГ

Газрын тосны бүтээгдэхүүний сүүлийн 2 жилийн нөөцийг харьцуулан авч үзвэл Автобензин А-80, Автобензин АИ-95, Дизель түлшний нөөц буурсан бөгөөд бусад бүтээгдэхүүний нөөц өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 52. Газрын тосны бүтээгдэхүүний сүүлийн 2 жилийн нөөц /тн/

Төрөл	2021 он	2022 он
Автобензин А-80	10,142	6,333
Автобензин АИ-92	40,355	43,209
Автобензин АИ-95	5,207	3,903
Дизелийн түлш	54,028	43,157
Онгоцны түлш ТС-1	1,706	4,718

Эх сурвалж: АМГТГ


Улсын хэмжээнд 2022 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд 1,875,343.0 тонн түлш, шатахуун импортолсон байгаа нь өмнөх оноос 68,469 тонн буюу 3.7 хувиар өссөн байна.

2021 оны 12 сарын 28-нд АИ-92 шатахууны үнэ литр тутамд 2370 төгрөгөөр худалдаалагдаж байсан бол үүнээс хойш жилийн дараа буюу 2022 оны 12 сарын 27-ны өдрийн АИ-92 шатахууны үнэ 162 төгрөгөөр нэмэгдэж 2532 төгрөг болжээ.

5.4.4. Газрын тосны хайгуул

Доорх зургаас Монгол улс дах газрын тосны ашиглалтын талбай, БХГ-т газрын тосны хайгуулын талбай, БХГ-НДМХ хайгуулын талбай, БХГ цуцлах нөхцөл бүрдсэн, гэрээлэгчгүй хайгуулын талбай, Улсын тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг мэдээллийг харж болно.

Зураг 3. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул ашиглалтын талбайн байршил



Эх сурвалж: АМГТГ

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 33 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар 28 талбайд 31 гэрээлэгч Засгийн газрын баталсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ажиллаж байна.

5.4.5. Газрын тосны тусгай зөвшөөрөл

Газрын тосны тусгай зөвшөөрөл болон эрэл хайгуул болон олборлолт, үйлдвэрлэлийн үйл явцтай холбоотой харилцааг Газрын тосны тухай хуулиар зохицуулдаг.

Газрын тосны эрлийн үйл ажиллагаа нь тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг хэлнэ.

Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа нь газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг багтаадаг. Газрын тосны ашиглалт гэдэгт газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг оруулна.

2015 оны 11 дүгээр сард орон нутгийн засаг захиргаа болон газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 430 тоот тогтоолоор баталсан. 2016 оны 3 дугаар сард орон нутгийн засаг захиргаа болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 179 тоот тогтоолоор баталсан.

Тусгай зөвшөөрөл олгох болон олгосон тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын Тосны Газар байсан бол 2016 оноос энэ газар нь АМГ-тай нийлж, АМГТГ болсон.

5.4.6. Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц (шаардлага 2.2.а)

Хүснэгт 53. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Үе шат	Үйл ажиллагаа
Төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/-д хүсэлт гаргах	Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
	Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө
	Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын 3 хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны 1 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт
Төрийн захиргааны төв байгууллага (УУХҮЯ)тусгай зөвшөөрөл олгох	Баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар дараах этгээдэд олгоно:
	Эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шууд байгуулсан, Нээлттэй сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрээ байгуулсан.

Үе шат	Үйл ажиллагаа
	Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.
	Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.
	Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно.
	Засгийн газраас давуу эрхээр олгосон талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрт олгоно.
Төрийн захиргааны төв байгууллага (УУХҮЯ) хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлах	Төрийн захиргааны байгууллага эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш 120 хоногийн дотор, дараагийн жилээс хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батална

Эх сурвалж: АМГТГ

Эдгээр шат дамжлагаар газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг олгодог бол дараах байдлаар газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгадаг байна.

Хүснэгт 54. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл сунгах үйл явц

Үе шат	Үйл ажиллагаа
Төрийн захиргааны төв байгууллага УУХҮЯ-д хүсэлт гаргах	Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан
	Сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл
Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг сунгах	Баримт бичгийг хянан үзээд эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шууд байгуулсан, нээлттэй сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдийн тусгай зөвшөөрлийг сунгах үндэслэлтэй гэж үзвэл хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгана.
	Төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ
Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг сунгахгүй байх	Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй.

Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үе шат нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үе дамжлагаас цөөн бөгөөд дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 55. Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Үе шат	Үйл ажиллагаа
Төрийн захиргааны төв байгууллага УУХҮЯ д хүсэлт гаргах.	Газрын тосны нөөцийг хүлээн авах тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.
Төрийн захиргааны төв байгууллага УУХҮЯ д	Газрын тосны нөөц бүртгэсэн тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр
	Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл
	Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө

Үе шат	Үйл ажиллагаа
баримт бичиг ирүүлэх.	Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
	Байр зүйн зураг ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг тэмдэглэсэн зураг
	Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт
Төрийн захиргааны төв байгууллага УУХҮЯ хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлах.	Төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгах үйл явцыг дараах хүснэгтээс дэлгэрэнгүй харна уу.

Хүснэгт 56. Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц

Үе шат	Үйл ажиллагаа
Төрийн захиргааны төв байгууллага (УУХҮЯ)-д хүсэлт гаргах.	Төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад дараах баримт бичгийг ирүүлнэ:
	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт, үндэслэл;
	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;
	Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл
Төрийн захиргааны төв байгууллага (УУХҮЯ) хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлах	Төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ

Хүснэгт 57. Тусгай зөвшөөрөл олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
АМГТГ	ГТГ нь нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
АМГТГ	ГТГ сонгон шалгаруулалтын материалыг 60 хүртэл хоног байх бөгөөд сонгон шалгаруулалтын эхний захиалга хүлээн авсан өдрөөс хойш тав хоногийн дотор захиалга хүлээн авах эцсийн хугацааг зарлана. Оролцогч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ: - Эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг; (Улсын бүртгэлийн гэрчилгээ) - Хөрөнгө оруулагчийн танилцуулга;

Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
	- Төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт; - Техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг; - Ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа; - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө төсөв; - Хуульд заасан хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс 20,000 ам доллар төлсөн баримт; - Оролцогч нь бизнесийн түншлэлтэй бол түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ;
АМГТГ	ГТГ нь өргөдлийг хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор оролцогчид бичгээр мэдэгдэнэ
УУХҮЯ ба АМГТГ	Оролцогчийн талаарх мэдээллийг гэрээ байгуулах хүртэл гуравдагч этгээдэд задруулахгүй.
УУХҮЯ ба АМГТГ	Үнийн саналыг Төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу тоо болон үсгээр зөрүүгүй үйлдэж төслийн үндсэн баримт бичгээс тусад нь эх болон хуулбар хувь тус бүрд битүүмжлэн хийсэн байна. Сонгон шалгаруулалтын талбайн босго үнэ 2240 төг/га, хэрэв эрдсийн хуримтлал бүхий талбай бол 4500 төг/га байхаар тус тус тооцох бөгөөд тухайн зарлагдсан талбайн хэмжээнд дүйцэх мөнгөн дүнг "босго үнэ" гэнэ .
АМГТГ	Сонгон шалгаруулах комиссын гишүүд нь сонгон шалгаруулалтын техникийн саналд үнэлгээ өгөхдөө - Геологи хайгуулын ажлын арга аргачлал төлөвлөлт оновчтой өмнөх судалгааны материалыг судалсан байдал - Байгаль орчны хамгаалалт нөхөн сэргээлтийн төлөвлөлт ажлын нэр төрөл түүнд зарцуулах зардлын хэмжээ хэрэгжүүлэх хугацаа - Орон нутгийг хөгжүүлэх хамтран ажиллах төлөвлөгөө - Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар - Геологи хайгуулын үйл ажиллагааны туршлага - Төсөлд ажиллах үйл ажиллагааны явуулах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал
АМГТГ	ГТГ нь дараах шалгуурыг үндэслэн ЗГ хамгийн ашигтай санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар тодруулан энэ тухай сонгоно: - ЗГ-т ногдох ашиг газрын тосны ногдох хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ; - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг; - ЗГ-т санал болгох бусад ашигтай нөхцөл.

5.4.7. Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Монгол Улсад байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой хууль тогтоомж, журмыг дараах хүснэгтэд оруулав.

Хүснэгт 58. БХГ-тэй холбоотой хууль тогтоомж

Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
Монгол Улсын Үндсэн хууль	6.1-р зүйл: Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
	6.2-р зүйл: Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.
	16.17-р зүйл: Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.
Ашигт малтмалын тухай хууль	5.3-р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тухайн ордыг ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.
	5.4 -р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.
	5.5-р зүйл: Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.
	42.1-р зүйл: Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	40-р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газарт олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлнө.
Газрын тосны тухай хууль	12 дугаар зүйл. Гэрээг цуцлах
	12.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээг доор дурдсан үндэслэлээр Засгийн газрын шийдвэрээр цуцална:
	12.2. Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт явуулах нь эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн, эсхүл онц байдал, давагдашгүй хүчин зүйл нэг ба түүнээс дээш жил үргэлжилбэл гэрээг цуцлах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлж болно.
	12.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 12.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
	12.4.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.3-т заасан дүгнэлтийг 30 хоногийн дотор хянан үзэж, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.
	12.5.Энэ хуулийн 12.1-д заасан үндэслэлээр бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхөж олгохгүй бөгөөд энэ хуулийн 11.2.9-д зааснаар эскроу дансанд байршуулсан мөнгийг байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад зарцуулж, үлдсэн мөнгийг гэрээлэгчид буцаан олгоно.
	13 дугаар зүйл.Гэрээний биелэлтийг дүгнэх
	13.1.Гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дараах үзүүлэлтээр дүгнэнэ:
	13.2.Төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дүгнэхдээ холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.
	13.3.Гэрээг хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн бол энэ хуулийн 11.1.4-т заасан эрх үүснэ.
	14 дүгээр зүйл.Гэрээлэгч эрх, үүргээ бусдад шилжүүлэх
	14.1.Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхлээр нь, эсхүл гуравны нэг буюу түүнээс дээш хувийг Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх эрхгүй.
	14.2.Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг бусдад шилжүүлэх тохиолдолд хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад гаргана
Газрын тосны тухай хууль(үргэлжлэл)	14.3.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.
	14.4.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлтийг хянан үзээд 30 хоногийн дотор Засгийн газарт саналаа хүргүүлж, холбогдох шийдвэр гаргуулна.
	14.5.Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх тохиолдолд гэрээлэгч, төрийн захиргааны байгууллага болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээдийн хооронд гурван талт гэрээ байгуулна.
	14.6.Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг шилжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 34.7, 34.8-д заасан төлбөрийг төлнө.
	14.7.Гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх, үүрэг шилжүүлэхэд төлсөн төлбөрийн хэмжээг шударгаар мэдээлнэ.
	14.8.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлт гаргахдаа хайгуул хийсэн хугацаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн эсэх талаарх байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг харгалзан үзнэ.
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	Уг хууль бүхэлдээ хамаарна.
Шилэн дансны тухай хууль	6-р зүйл: Шилэн дансны мэдээлэл
	6.4.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
	6.5.9. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор; 6.5.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулсан тухай бүрд хувийн хэвшлийн түншлэгч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор;
Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам	Уг журам бүхэлдээ хамаарна.
Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	7. ОУИТБС-ын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнд хүргэж хэрэгжүүлэн, шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, түүнийг эзэмших, шилжүүлэх үйл ажиллагаа, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах талаар байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэдгээрийн хэрэгжилт, ашиглалтын өмнөх гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах ажлын явц, үр дүн, түүнд зарцуулсан зардал зэргийг тус санаачилгад нэмж хамруулахаар тогтоосугай. 8. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эзэмших, шилжүүлэх (тусгай зөвшөөрлийг компанийн нэр, баримт бичигтэй нь хамт худалдах асуудал энд бас хамаарна), стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилт, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, экспортын хэмжээг нийтэд ил тод болгох ажлыг 2012 оноос туршилтын журмаар хэрэгжүүлж, үр дүнг Ажлын хэсэг, улмаар Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж жил бүр нийтэд ил тод мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.
Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.

Эх сурвалж: legalinfo.mn

2022 онд шинээр БХГ хийгдээгүй бөгөөд 2020 оны байдлаар БХГ байгуулсан компаниудыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 59. БХГ байгуулсан компаниуд

№	БХГ-т талбай	БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар	Гэрээлэгч компани	Оператор компани	Гэрээлэгчийн харьяалал	Талбайн хэмжээ, км.кв
1	Тосон-Уул XIX	1993.04.26	Daqing Oil Field Ltd	Петрочайна Дачин Тамсаг ХХК	БНХАУ	650
2	1997БХГ	1997.02.19-ЗГ-ын тогтоол №47	Доншен Жингүн Девелопмент Групп	Доншен газрын тос (Монгол) ХХК	БНХАУ	239,5
3	Матад XX	2006.07.19-ЗГ-ын тогтоол №170	Petromatad Invest Limited	ПетроМатад ХХК	Их Британий Мэний арал	10343,2
4	Нялга XVI	2007.06.20-ЗГ-ын тогтоол №148	Panasian Energy Ltd	Шэйман ХХК	Канадын Невисийн арал	9239,4
5	Цагаан-элс XIII	2009.05.20-ЗГ-ын тогтоол №148	DWM Petroleum AG	Гоби энерги партнерс Гмбх ХХК	Швейцарь	1980
6	Зүүнбаян XIV					1030
7	Галба XI	2009.05.20-ЗГ-ын тогтоол №147	Zong Heng You Tian Ltd	Зон Хэн Юу Тиан ХХК	БНХАУ	9769,2
8	Сулинхээр XXIII	2009.07.22-ЗГ-ын тогтоол №224	Шунхлай Энержи ХХК	Шунхлай Энержи ХХК	Монгол улс	13576
9	Борзон VII	2009.07.29-ЗГ-ын тогтоол №236	Импайр Газ Монголиа ХХК	Импайр Газ Монголиа ХХК	Мэний арал	31432
10	Хөхнуур XVIII	2009.07.29-ЗГ-ын тогтоол №238	Эн Пи Ай ХХК	Эн Пи Ай ХХК	БНХАУ	5276
11	Төхөм Х(хойд)	2009.07.29-ЗГ-ын тогтоол №237	Сансарын геологи хайгуул ХХК	Сансарын геологи хайгуул ХХК	Монгол улс	9813
12	Цайдам XXVI					11175
13	Богд IV	2009.07.29-ЗГ-ын тогтоол №235	Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед	Капкорп монголиа ХХК	Их Британий Кэйманий арал	28998.6
14	Онги V					21148
15	Баянтүмэн XVII	2010.12.08-ЗГ-ын тогтоол №316	Магнай трейд ХХК	Магнай трейд ХХК	Монгол улс	7832
16	Дарьганга XXIV	2011.02.09-ЗГ-ын тогтоол №39	Алекспро инвестмент лимитед	Эй Пи Экс Пи Эр Өү ХХК	Британий Виржини арал	17178
17	Төхөм Х (урд)	2012.07.25-ЗГ-ын тогтоол №253	Монголын алт (МАК) ХХК	Монголын алт (МАК) ХХК	Монгол улс	24706,2

№	БХГ-т талбай	БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар	Гэрээлэгч компани	Оператор компани	Гэрээлэгчийн харьяалал	Талбайн хэмжээ, км.кв
18	Сүхбаатар XXVII	2013.01.05-ЗГ-ын тогтоол №39	Вульф петролеум ХХК	Вульф петролеум ХХК	Австрали	23047,5
19	Номгон IX	2014.02.09 ЗГ-ын тогтоол №39	Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК			29866
20	Увс I	2015.04.20, ЗГ-ын тогтоол №162	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Хонгконг	19720
21	Хэрлэнтохой XXVIII	2015.04.20-ЗГ-ын тогтоол №162	Хонгконг Вэлпэк Индастриал ХХК	Хонгконг Вэлпэк Индастриал ХХК	Хонгконг	14280
22	Хар-ус II	2015.06.15-ЗГ-ын тогтоол №246	Ренова илч ХХК	Ренова илч ХХК	БНХАУ	27409,3
23	Эргэл-XII	2016.06.20-ЗГ-ын тогтоол №337,	Макс ойл ХХК	Макс ойл ХХК	Монгол улс	/875+894.416/ 1769.416
24	Ар булаг-XXIX	2016.08.24-ЗГ-ын тогтоол №53	Смарт ойл инвестмент лимитед	Смарт ойл инвестмент ХХК	БНХАУ	11035

Эх сурвалж: *iltodgeree.mn*

5.4.8. БХГ-ний талаарх ил тод байдал (шаардлага 2.4)

Монгол Улсын Засгийн газар нь бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ил тод болгоход татгалзах зүйлгүй байгаа бөгөөд бүтээгдэхүүн хуваах гэрээг олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон Засгийн газрын 222 тоот тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 4-нд баталсан.

Хүснэгт 60. 2022 оны байдлаар ил тод болсон БХГ-үүдийн жагсаалт

№	Гэрээ	Он	Эрдсийн төрөл	2022 онд хүчинтэй байсан эсэх
1	Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайн талаар Газрын тосны газар "Шунхлай энерги" ХХК-ийн хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
2	Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Газрын тосны хэрэг эрхлэх газар болон Нескор энерги компанийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	1997	Газрын тос	Тийм
3	Тосон уул XIX гэрээт талбайн талаар Монгол газрын тос компани болон Медаллион Монгол Ойл компанийн хооронд байгуулсан БХГ	1993	Газрын тос	Тийм
4	"Эргэл XII" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, Газрын тосны газар "Смарт ойл	2016	Газрын тос	Тийм

№	Гэрээ	Он	Эрдсийн төрөл	2022 онд хүчинтэй байсан эсэх
	инвестмент лтд" компанийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах тухай гэрээ			
5	"Ар булаг-XXIX" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Макс ойл" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2017	Газрын тос	Тийм
6	Газрын тосны хайгуулын Номгон - IX талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2014	Газрын тос	Тийм
7	Газрын тосны хайгуулын Төхөм хойд - X талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
8	Газрын тосны хайгуулын Хөх нуур - XVIII талбайн талаар Газрын тосны газар болон БНХАУ-ын "Эн Пи Ай" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
9	DWM Petroleum AG, Tsagaan Els XIII Area, PSA, 2009	2009	Газрын тос	Тийм
10	Газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч нарын хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар	2015	Газрын тос	Тийм
11	Хөх нуур XVIII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Эн Пи Ай ХХК хооронд шинэчлэн байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2017	Газрын тос	Тийм
12	Газрын тосны хайгуулын Галба-ХI талбайн талаар Газрын тосны газар, "Зон хэн юу тиан" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
13	Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайн талаар Газрын тосны газар, "Шунхлай энерги" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
14	Матад-XX талбайд Петро матад ХХК болон Газрын тосны газар хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2006	Газрын тос	Тийм
15	Газрын тосны хайгуулын Цайдам - XXVI талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
16	Сүхбаатар-XXVII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар "Ашигт малтмал, газрын тосны газар" болон "Вульф петролеум" ХХК-ийн хооронд шинэчлэн байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2017	Газрын тос	Тийм
17	Борзон VII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Импейр Газ Монголиа ХЙХК-ийн хооронд шинэчлэн байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2017	Газрын тос	Тийм
18	Газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайн талаар Газрын тосны газар болон "Магнай трейд"	2009	Газрын тос	Тийм

№	Гэрээ	Он	Эрдсийн төрөл	2022 онд хүчинтэй байсан эсэх
	ХХК-ийн хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ			
19	Нялга-XVI гэрээт талбайн талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад улсын "Шаман ресурсэс ЛТД" компанийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2007	Газрын тос	Тийм
20	"Хар ус - II" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Ренова-Илч" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2015	Газрын тос	Тийм
21	"Хэрлэн тохой XXVIII" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Хонконг Вэлпэк Индастриал" компанийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2015	Газрын тос	Тийм
22	Төхөм X урд талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК хооронд шинэчлэн байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2017	Газрын тос	Тийм
23	Газрын тосны хайгуулын Богд-IV талбайн талаар Газрын тосны газар болон "Сентрал Азиан Петролеум корпорэйшн лимитэд" компанийн хооронд байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
24	Монгол газрын тосны товчоо болон Команд петролиум лимитед, Цагаан шонхор ойл корпораци, Соко Тамсаг Монголиа Инк. нарын (гэрээлэгч) хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ	1995	Газрын тос	Тийм
25	Газрын тосны хайгуулын Дарьганга-XXIV талбайн талаар Газрын тосны газар, "Апекспро Инвестмэнт Лимитэд"-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2010	Газрын тос	Тийм
26	Газрын тосны Онги-V талбайн талаар Газрын тосны газар болон Сентрал Азиан Петролеум корпорэйшн лимитэд компанийн хооронд байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм
27	Газрын тосны хайгуулын Цагаан элс - XIII талбайн талаар Газрын тосны газар, "DWM петролеум AG"-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ	2009	Газрын тос	Тийм

Эх сурвалж: iltodgeree.mn

Ил тод гэрээний цахим хуудсанд ил болгосон Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний жагсаалтыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 61. Ил тод болгосон эрлийн ажил гүйцэтгэх гэрээ

№	Гэрээлэгч талууд	Гарын үсэг зурсан огноо	Эрдсийн төрөл
1	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Нэйшнал газ ойл энерги ХХК	2018-12-20	Газрын тос
2	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Эрдэнэс метан ХХК	2017-02-24	Нүүрсний давхаргын метан хий
3	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Зэ честнат фанд Монголиа ХХК	2019-01-18	Нүүрсний давхаргын метан хий

№	Гэрээлэгч талууд	Гарын үсэг зурсан огноо	Эрдсийн төрөл
4	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Юу Жи Эс ХХК	2018-08-16	Шатдаг Занар
5	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Зэ честнат фанд Монголиа ХХК, Матад	2019-01-18	Нүүрсний давхаргын метан хий
6	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Юу жи Эс ХХК	2018-06-19	Нүүрсний давхаргын метан хий
7	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Бигстоне	2019-01-25	Газрын Тос
8	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Сарны сувдан чулуу ХХК	2018-09-13	Газрын Тос
9	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Эс би петролиум ХХК	2018-08-08	Шатдаг Занар
10	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Коммон макс ХХК	2018-12-17	Шатдаг Занар
11	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Азтек Монголиа Эксплорэйшн	2019-01-28	Нүүрсний давхаргын метан хий
12	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Эс би петролиум ХХК	2018-08-18	Шатдаг Занар
13	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Тэлмэн ресурс	2019-01-21	Нүүрсний давхаргын метан хий
14	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Фронтиер Петролеум ХХК	2018-06-07	Газрын Тос
15	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Тэмүүжин металс ХХК	2018-10-29	Нүүрсний давхаргын метан хий
16	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Софтрок ХХК	2018-09-17	Газрын Тос


Эх сурвалж: *iltodger.ee.mn*

5.4.9. Газрын тосны бүтээгдэхүүний орлого

ГЕГ, МХЕГ, ХХЕГ, ИХШХЕГ-ын орон нутаг дахь салбар байгууллага болон Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох хэлтсийн төлөөлөгч, мэргэжилтнүүд газрын тосны экспортын үйл ажиллагаанд газар дээр нь тогтмол хяналт тавьж ажилладаг. Хөндлөнгийн хяналтын эрх бүхий Амбер ХХК нь 1997 оны БХГ-т талбайгаас олборлон, экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг 2009 оноос, Тосон-Уул XIX, Тамсаг ХХI талбайгаас олборлон экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг 2011 оноос тус тус хийж эхэлсэн. Түүнчлэн 2013 онд гаалийн хяналтын талбайг барьж дуусган, 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулсан.

Монгол Улсын хэмжээнд 1996-2022 онд 75.98 сая баррель буюу 10.28 сая тонн тос олборлож, 72.81 сая баррель буюу 9.85 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолж газрын тосны орлогоос нийт 2.18 их наяд төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн.

Зураг 4. Газрын тосны олборлолт экспорт, төсөвт төвлөрүүлсэн орлого




Эх сурвалж: Газрын тосны ашиглалтын хэлтэс

5.4.10. Газрын тосны үйлдвэрлэл, экспорт

2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,565.4 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2,101.7 (45.0%) мян.бар-аар буурсан байна.

Газрын тосны экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 241.8 сая ам.долларын 2,605.7 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1,743.2 мян.бар буюу 40.1 хувиар, үнийн дүнгээр 31.5 сая ам.доллар буюу 11.5 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

График 7. Сүүлийн 4 жилийн газрын тосны олборлолт экспорт, мян.бар



Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ 2022, АМГТГ

Сүүлийн 4 жилийн газрын тосны олборлолт экспортыг харьцуулж үзэхэд 2021 онд бага зэрэг өсөж байсан хэдий ч 2022 онд үлэмж хэмжээгээр буурсан байна.

2022 оны газрын тосны олборлолт экспортыг сар бүрээр нь задалж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 62. 2022 оны газрын тосны олборлолт экспорт

Он/сар	Олборлолт		Экспорт	
	Баррель	Хувь	Баррель	Хувь
2022	2,566,089	100%	2,605,910	100%
1 сар	17 544	0.68%	-	

Он/сар	Олборлолт		Экспорт	
	Баррель	Хувь	Баррель	Хувь
2 сар	9,921	0.39%	-	-
3 сар	9,257	0.36%	-	-
4 сар	1,001	0.04%	-	-
5 сар	1,290	0.05%	-	-
6 сар	38,184	1.49%	114,102	4.38%
7 сар	351,008	13.68%	359,232	13.79%
8 сар	457,301	17.82%	492,619	18.90%
9 сар	424,986	16.56%	428,311	16.44%
10 сар	417,283	16.26%	364,645	13.99%
11 сар	410,196	15.99%	432,823	16.61%
12 сар	428,119	16.68%	414,179	15.89%

Эх сурвалж: АМГТГ

5.4.11. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт Засгийн газар нь “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам батлах” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын болон компанийн нөөцөөс бүрдэнэ”, 13.2 дахь хэсэгт “Улсын нөөцийг Засгийн газраас баталсан журмын дагуу бүрдүүлнэ.” гэж тус тус заасан байдаг. Монгол Улсад борлуулагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үнийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 63. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ 2021, 2022 оны сар бүрээр /төгрөгөөр/

Сар	Автобензин А-80	Автобензин АИ-92	Автобензин АИ-95	Дизелийн түлш
2021 он				
1-р сар	1483	1559	2083	2025
2-р сар	1492	1560	2174	2112
3-р сар	1505	1563	2183	2123
4-р сар	1508	1563	2183	2123
5-р сар	1513	1545	2163	2233
6-р сар	1513	1545	2313	2262
7-р сар	1812	1846	2418	2352
8-р сар	2112	2144	2513	2545
9-р сар	2129	2161	2702	2545
10-р сар	2150	2181	2608	2541
11-р сар	2256	2303	2759	2778
12-р сар	2370	2397	2864	2883
2022 он				
1-р сар	2370	2416	2855	2836
2-р сар	2419	2464	2954	2924
3-р сар	2516	2560	3144	3117
4-р сар	2517	2561	3353	3369
5-р сар	2517	2561	3351	3425
6-р сар	2994	2559	4000	3736
7-р сар	2996	2559	4341	4045
8-р сар	2525	2558	4025	3736
9-р сар	2525	2554	4030	3587
10-р сар	2532	2552	4037	3771
11-р сар	2532	2552	4029	3962
12-р сар	2532	2552	4029	4004

Эх сурвалж: АМГТГ

Газрын тосны бүтээгдэхүүний үнэ нь тээвэрлэлтийн асуудлаас болоод холын аймгуудад үнийн зөрүү нь өндөр байдаг бөгөөд Монгол улсын дундаж үнэ болон аймаг бүсийн хэмжээнд 2022 онд зарагдаж байсан үнийн хамт дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 64. Газрын тосны бүтээгдэхүүний үнийг улс аймаг бүсээр /төгрөгөөр/

Газар нутаг	Автобензин А-80	Автобензин АИ-92	Автобензин АИ-95	Дизелийн түлш
Улсын дундаж	2532	2552	4029	4004
Улаанбаатар	2370	2390	3910	3850
Баруун бүс	2802	2818	4150	4180
Баян-Өлгий	2680	2700	4000	4140
Говь-Алтай	2780	2800	4150	4270
Завхан	2870	2890	4200	4200
Увс	2880	2900	4200	4140
Ховд	2800	2800	4200	4150
Хангайн бүс	2492	2512	4047	3985
Архангай	2480	2500	4040	3970
Баянхонгор	2510	2530	4050	4130
Булган	2470	2490	4040	3910
Өвөрхангай	2450	2470	4030	4020
Орхон	2470	2490	4040	3910
Хөвсгөл	2570	2590	4080	3970
Төвийн бүс	2479	2499	4010	3947
Төв	2420	2440	3980	3940
Дархан	2450	2470	4020	3910
Сэлэнгэ	2480	2500	4030	3910
Говьсүмбэр	2460	2480	4010	3940
Дундговь	2510	2530	4010	3960
Дорноговь	2510	2520	4030	3980
Өмнөговь	2530	2550	3990	3990
Зүүн бүс	2520	2540	4030	4057
Дорнод	2510	2530	4030	4100
Сүхбаатар	2550	2570	4070	4110
Хэнтий	2500	2520	3990	3960

Эх сурвалж: АМГТГ

Мөн дэлхийн томоохон биржид борлогдож буй газрын тосны дундаж үнэ (ам.доллар, тонноор) мэдээллийг дараах эх сурвалжаас харна уу.

www.wtrg.com, www.bloomberg.com, www.reuters.com, www.topoilnews.com, www.oil.in-en.com, www.nymex.com, www.finmarket.ru, www.ineng.org, www.quandl.com.

5.4.12. Газрын тосны салбар дахь төрийн оролцоо

Төрөөс газрын тосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого

Зорилго: Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах. ЗГ-ын 2018 169 дүгээр тогтоолд

- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх,

- Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх,
- Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах,
- Салбарын хүний нөөц, ажиллах хүчийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх,
- Газрын тосны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих,
- Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх зэрэг асуудлыг тусгасан байна.


Манай улс нь дотоодын түүхий эдийн нөөцөд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, түлш шатахууны хэрэгцээгээ ханган, эдийн засагт нефть-химийн шинэ салбарыг бий болгох зорилготой бүтээн байгуулалтын цогц төсөл Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжиж байна. Энэ бол “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” (МГТБҮ) ТӨХХК-ийн төсөл юм. 2025 онд ашиглалтад бүрэн оруулахаар төлөвлөж байгаа ба 2017 оноос эхэлсэн БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр үе шаттайгаар хэрэгжүүлэх МГТБҮ-ийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 15- ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан байна. “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг ХЗДХЯ, СЯ, УУХҮЯ, АМГТГ, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулж УИХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан байна. Мөн “Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг боловсруулан Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11- ний өдрийн хуралдаанаар баталсан байна.

5.5. Олборлох салбараас эдийн засагт оруулсан хувь нэмэр

5.5.1. Эдийн засгийн өсөлт (шаардлага 6.3.а)

2022 оны улсын төсвийн 24.3 хувийг олборлох үйлдвэрлэл бүрдүүлсэн бөгөөд манай орны эдийн засаг, олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортоос шууд хамааралтай байдаг.

График 8. ДНБ болон уул уурхай, олборлох салбарын орлогын сүүлийн 7 жилийн харьцуулалт /их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 65. Сүүлийн 3 жилийн ДНБ болон ДНБ-ий өсөлт

	2020	2021	2022
ДНБ, оны үнээр /тэрбум төгрөг/	37,453.3	43,555.5	53,851.5
ДНБ, өсөлт /хувь/	-1.01	16.3	23.63

2022 оны олборлох салбарын гол бүтээгдэхүүнүүдийн экспортыг харуулбал:

Зураг 5. 2022 онд олборлох үйлдвэрлэлийн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт

Алт	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,127.4 сая ам.долларын 19,660.3 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 122.9 сая ам.доллар буюу 12.2 хувиар, биет хэмжээгээр 2,410.7 кг буюу 14.0 хувиар тус тус өссөн байна. Алтны 91.0 хувийг Швейцар, 9.0 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.
Чулуун нүүрс	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 6,502.7 сая ам.долларын 31,814.0 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3,728.7 сая ам.доллар буюу 2.3 дахин, биет хэмжээгээр 15,696.4 мян.тн буюу 2.0 дахин тус тус өссөн байна. Чулуун нүүрсний 94.0 хувийг БНХАУ, 3.8 хувийг Сингапур Улс, 2.1 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.
Хайлуур жоншны хүдэр	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 110.5 сая ам.долларын 387.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 256.5 мян.тн буюу 39.8 хувиар, үнийн дүнгээр 33.5 сая ам.доллар буюу 23.2 хувиар тус тус буурсан байна. Хайлуур жоншны 46.0 хувийг ОХУ, 53.8 хувийг БНХАУ руу тус тус экспортолсон байна.
Төмрийн хүдэр	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 391.0 сая ам.долларын 4,732.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 561.2 сая ам.доллар буюу 58.9 хувиар, биет хэмжээгээр 2,374.0 мян.тн буюу 33.4 хувиар тус тус буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.
Зэсийн баяжмал	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,734.8 сая ам.долларын 1,453.3 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 165.0 сая ам.доллар буюу 5.7 хувиар буурч, биет хэмжээгээр 170.8 мян.тн буюу 13.3 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.
Цайрын баяжмал	2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 176.4 сая ам.долларын 112.6 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 21.4 мян.тн буюу 16.0 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 8.7 сая ам.доллар буюу 5.2 хувиар өссөн байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,566.6 ам.доллар болж, 315.8 ам.доллар буюу 25.3 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.
Молибдены баяжмал	2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 87.2 сая ам.долларын 6,451.1 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 4.8 сая ам.доллар буюу 5.9 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 885.5 тн буюу 12.1 хувиар буурсан байна. Молибдены баяжмалын 89.7 хувийг БНХАУ, 10.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

5.5.2. Үйлдвэрлэл (шаардлага 6.3а)

Экспорт

Экспортын худалдаа 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,540.0 сая ам.доллар болж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас өмнөх буюу 2019 онтой харьцуулахад 4,920.0 сая ам.доллар буюу 64.6 хувиар өссөн бол 2021 оноос 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 10,542.0 сая ам.доллар болж, өмнөх оноос 3,031.6 сая ам.доллар буюу 40.4 хувиар өссөн, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,998.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 267.7 сая ам.доллар буюу 15.5 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 91.9 хувь болж, өмнөх оноос 10.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 66. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

Үзүүлэлт	Он					Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	6,070.3	6,377.5	5,256.0	7,510.4	10,542.0	3,031.6	40.4	91.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	941.4	1,242.3	2,320.3	1,730.7	1,988.4	267.7	15.5	8.1
Нийт экспорт	7,011.8	7,619.8	7,576.3	9,241.1	12,540.4	3,299.3	35.7	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр экспортын орлогын 51.8 хувийг нүүрс, 21.8 хувийг зэсийн баяжмал, 8.9 хувийг боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспортын орлого эзэлж байна.

Хүснэгт 67. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Барааны төрөл	Он						Өөрчлөлт (Сая ам.дол)
	2020		2021		2022		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	2022/2021
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	432.0	8.0	590.0	9.0	960.0	11.0	370.0
АИ-92, 95	222.0	4.0	353.0	5.0	535.0	6.0	182.0
А80 ба бусад	163.0	3.0	189.0	3.0	228.0	3.0	40.0
Нийт дүн	817.0	15.0	1,132.0	17	1,724.0	20.0	592.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импорт

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт импортын худалдаа 8,704.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оноос 27.2 хувь буюу 1,859.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 68. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

Үзүүлэлт	Он					Өөрчлөлт		Нийт экспорт эзлэх хувь
	2018	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	6,070.3	6,377.5	5,256.0	7,510.4	10,542.0	3,031.6	40.4	91.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	941.4	1,242.3	2,320.3	1,730.7	1,988.4	267.7	15.5	8.1
Нийт экспорт	7,011.8	7,619.8	7,576.3	9,241.1	12,540.4	3,299.3	35.7	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт импортын 22.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.5 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,960.3 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 621.7 сая ам.доллараар буюу 46.4 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 6,744.1 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 1,237.2 сая ам.доллар буюу 22.5 хувиар өсжээ.

Импортоор нийлүүлэгдсэн барааны нийт дүнд эрдэс бүтээгдэхүүн 22.5 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 14.5 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 9.0 хувь, авто агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 19.5 хувь, хуванцар болон хуванцар эдлэл, хаймар түүгээр хийсэн эдлэл 4.0 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.3 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 6.9 хувийг тус тус эзэлж, эдгээр бүтээгдэхүүн нийт дүнгийн 85.7 хувийг эзэлж байна.

2022 оны байдлаар импортын 31.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 38.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 11.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 20.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

Хүснэгт 69. Нефтийн бүтээгдэхүүний импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Барааны төрөл	Он						Өөрчлөлт (Сая ам.дол)
	2020		2021		2022		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	2022/2021
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	432.0	8.0	590.0	9.0	960.0	11.0	370.0
АИ-92, 95	222.0	4.0	353.0	5.0	535.0	6.0	182.0
А80 ба бусад	163.0	3.0	189.0	3.0	228.0	3.0	40.0

Барааны төрөл	Он						Өөрчлөлт (Сая ам.дол)
	2020		2021		2022		2022/2021
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	
Нийт дүн	817.0	15.0	1,132.0	17	1,724.0	20.0	592.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оноос 592.0 сая ам.доллараар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нөлөөлжээ. Дизель түлшний импорт 370.0 сая ам.доллар, бензин 282.0 сая ам.доллараар нэмэгджээ. 2022 оны эцэст нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 131.9 ам.дол/баррель болсон байна. Энэ нь 2021 оны жилийн эцсээс 46.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

Уул уурхай олборлолтын гол бүтээгдэхүүнүүд болон боловсруулах хүнд үйлдвэрийн гол бүтээгдэхүүнүүдийн сүүлийн 2 жилийн олборлолтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 70. Уул уурхай олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2021	2022
1. Уул уурхай, олборлолт				
1.1	Нүүрс	мян.тн	30,124.3	37,282.0
1.2	Газрын тос	мян.бар	4,667.1	2,565.4
1.3	Зэсийн баяжмал	мян.тн	1,326.3	1,189.8
1.4	Молибдений баяжмал	тн	6,326.0	5,914.2
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	19,054.4	19,382.7
1.6	Төмрийн хүдэр	мян.тн	9,171.9	7,659.9
1.7	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	3,676.8	1,728.1
1.8	Хайлуур жоншн	мян.тн	118.3	95.6
1.9	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	60.3	24.5
1.10	Цайрын баяжмал	мян.тн	75.2	199.3
2. Боловсруулах үйлдвэр, Хүнд үйлдвэр				
2.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	3,815.0	3,169.1
2.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	729.8	592.4
2.3	Катодын зэс	тн	9,689.9	9,736.0
2.4	Металл бэлдэц	тн	35,917.1	24,988.1
2.5	Металл цувимал	тн	35,574.7	26,140.9
2.6	Ган төмөр хийц	тн	4,101.9	3,691.1

Эх сурвалж: Уул уурхай хүнд үйлдвэрийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 7,157.6 мян.тн буюу 23.8 хувь, алт 328.3 кг буюу 1.7 хувь, цайрын баяжмал 124.1 мян.тон буюу 2.7 дахин их, катодын зэс 46.2 тн буюу 0.5 хувиар тус тус өссөн байна. Харин газрын тос 2,101.7 мян.тн буюу 45.0 хувь, зэсийн баяжмал 136.5 мян.тн буюу 10.3 хувь, молибдений баяжмал 411.9 тн буюу 6.5 хувь, төмрийн хүдэр 1,512.0 мян.тн буюу 16.5 хувь, төмрийн хүдрийн баяжмал 1,948.7 мян.тн буюу 53.0 хувь, хайлуур жонш 22.7 мян.тн буюу 19.2 хувь, хайлуур жоншны баяжмал 35.7 мян.тн буюу 59.3 хувь, баяжуулсан нүүрс 645.9 мян.тн буюу 16.9 хувь, нүүрсэн шахмал түлш 137.4 мян.тн буюу 18.8 хувь, металл бэлдэц 10,937.6 тн буюу 30.4 хувь, металл цувимал 9,433.8 тн буюу 26.5 хувь, ган төмөр хийц 410.8 тн буюу 10.0 хувиар буурсан байна.

5.5.3. Олборлох салбараас орсон Засгийн газрын нийт орлого (шаардлага 6.3b)

2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр улсын төсөвт олборлох салбар 4,606.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеийнхээс 544.7 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар, газрын тосны салбар 95,4 тэрбум төгрөг буюу 92.8 хувиар тус тус өсжээ.

Хүснэгт 71. Төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл / I-XII /		Гүйцэтгэл	
	2021 Тодотгол	2022 Тодотгол	2021	2022	Өсөлт бууралт	Хувь
Нийт орлогын дүн	4,795.9	4,358.3	4,114.4	4,606.9	492.5	12.0%
Уул уурхай, олборлох салбар						
Нийт дүн	4,530.5	4,066.3	3,845.5	4,390.2	544.7	14.2%
Алт	183.8	247.4	227.3	258.0	30.7	13.5%
Зэс	2,684.2	1,966.7	2,421.8	1,717.2	-704.7	-29.1%
Нүүрс	1,287.8	1,346.5	756.9	2,062.4	1,305.5	172.5%
Бусад	374.7	128.4	439.4	115.7	62.8	118.7%
Газрын тосны салбар						
Газрын тос	213.2	215.4	198.1	161.0	-37.1%	-18.7%
Тусгай зөвшөөрөл болон бусад орлого						
Нийт дүн	52.2	76.6	70.7	55.7	-15.0	-21.2%
Тусгай зөвшөөрлийн төлбөр	31.2	31.4	32.8	35.6	2.8	8.6%
УТ-ийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2.5	17.5	4.4	2.0	-2.4	-55.4%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	16.0	25.0	29.6	14.5	-15.1	-50.9%
Бусад орлого	2.5	2.7	3.9	3.6	-0.3	-7.2%

Эх сурвалж: Уул уурхай хүнд үйлдвэрийн яам

5.6. Засгийн газрын байгууллагууд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход оршино.

Уул уурхай, түлш, газрын тос, хүнд үйлдвэр, геологийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, дунд, урт хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ хийх, төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах нь тус яамны зорилго юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтийг 95.51 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)



Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд зорилт тавьж ажилладаг.

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалт болон Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсүүд нь Газрын тосны тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудын дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

2022 онд ашигт малтмал, газрын тосны газар нь улсын төсөвт нийт 291,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан бөгөөд гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 182.8 тэрбум төгрөг буюу 62,63%-тай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БОАЖЯ-ны үндсэн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой үндэсний бодлого, хууль журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалахад оршино. Түүнчлэн, БОАЖЯ нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой тусгай асуудлуудын хүрээнд нийслэлийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын дагаж мөрдвөл зохих дүрэм журам, бодлогыг боловсруулж батлах, түүнтэй холбогдох шийдвэрийг гаргадаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрөлдөө хүлээж аваад 30 хоногийн дотор байгаль хамгаалах төлөвлөгөө БОАЖЯ-нд ирүүлэх ёстой байдаг ба яам уг тайланг хүлээн авч, хянах үүрэгтэй. Яам нь компаниудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд төсөвлөсөн зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тухайн компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлээгүй нөхцөлд уг 50 хувийг төсөвлөсөн зориулалтаар нь БОАЖЯ зарцуулах эрхтэй.

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ)



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХНХЯ-ны үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах явдал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх явдал юм. ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцөл ба амьжиргааны өртгийн асуудлыг сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн ажил

эрхлэлтийн асуудал болон гадаад улсад хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. ХНХЯ-ны эрхэм зорилго нь хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.

2022 онд Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны онцлох ажлуудын нэг нь залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төслийн хүрээнд нийт 4 ээлжээр 1231 залуус төсөлд хамрагдсан. Үүний 740 эмэгтэй, 491 эрэгтэй байсан бол нийт залуусын 725 (61%) 18-25 насны, 321(27%) 25-30 насны, 158 (12%) 30-34 насны залуус хамрагдаад байгаа аж.

Татварын Ерөнхий Газар (ТЕГ)



Татварын ерөнхий хуульд зааснаар Үндэсний татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ТЕГ), аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. ТEG нь ЗГ-ын санхүүгийн асуудал хариуцсан байгууллага болох Сангийн Яамны харьяа байгууллага бөгөөд түүний удирдлагад ажилладаг.

ТЕГ-ын үндсэн чиг үүрэг нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм.

Гаалийн ерөнхий газар (ГEG)



Монгол Улсын Гаалийн үйл ажиллагааг гаалийн төв байгууллага болох ГEG удирдан чиглүүлдэг бөгөөд түүний харьяанд аймаг, нийслэлийн гаалийн албууд хамаарна. ГEG нь гаалийн хууль тогтоомжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд Сангийн Яамны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

ГEG-ын үндсэн чиг үүрэг нь гаалийн хуулийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, түүний нийцлийг хянах, гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, гаалийн алба хэлтсийн үйл ажиллагааг зохицуулах, Гаалийн Хөгжлийн Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх юм.

2022 онд Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны орлогын дүн 108,590.3 сая төгрөг байсан ба өмнөх онтой харьцуулахад 37,469.09 сая төгрөгөөр өссөн байна.

Үндэсний аудитын газар (ҮАГ)



Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагдана.


Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх бүрэн эрхтэй байдаг.

ҮАГ нь Гүйцэтгэлийн аудитын газар, Санхүүгийн аудитын газар, Нийцлийн аудитын газар, Бодлого, төлөвлөлтийн газар, Хуулийн хэлтэс гэсэн таван газар, хэлтсээс бүрддэг.

Төрийн аудитын байгууллага 2022 онд 4,284 аудитыг хийж гүйцэтгэжээ. Үүнээс бүх шатны төсөв захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд бие даасан 4,069 дүгнэлт гаргасан бол гүйцэтгэл, нийцлийн 215 аудитаар 4,957 байгууллага, хуулийн этгээдийг хамруулсан байна. ТАБ-аас 2022 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 13,479.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлжээ.

Цөмийн Энергийн Комисс (ЦЭК)



Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг.

Цөмийн Энергийн Комиссын үндсэн үйл ажиллагаанууд нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн ашиглалтыг зохицуулах Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлэх; цөмийн байгууламж, материал, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой тусгай зөвшөөрлийг олгох эсвэл цуцлах; Монгол Улсын цөмийн энергийн салбарын шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг зохицуулах, хянах; цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Цөмийн Энергийн Комисс нь Тамгын газар, Цөмийн технологийн бодлогын газар, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс гэсэн дөрвөн газар, хэлтсээс бүрддэг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг

нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 59,237.2 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 14,552.6 тэрбум төгрөгийн орлого олж, 2,075.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2021 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад орлого 36.7 хувиар буюу 3,903.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 100.4 хувиар буюу 1,040.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

5.7. Олборлох салбар дахь төрийн оролцоо

5.7.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн тодорхойлолт

ОУИТБС-ын Стандарт-д ОУИТБС-ын тайлагналын зорилгоор төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүдийг “Засгийн газрыг төлөөлөн олборлох үйл ажиллагаа эрхэлдэг бүхэлдээ эсхүл ихэнх нь төрийн эзэмшлийн компани” хэмээн тодорхойлсон. ОУИТБС-ын Стандартаар ОТОБ нь үндэсний хууль эрх зүй, ЗГ-ын бүтэц, зохион байгуулалтын онцлогт нийцүүлэн ТӨААН-ийн тодорхойлолтыг баримтжуулахыг хөхүүлэн дэмждэг.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчит аж ахуйн нэгжийг дараах байдлаар ангилж, тодорхойлсон. Үүнд:

- төрийн өмчит,
- төрийн өмчийн оролцоотой,
- төрийн өмчит үйлдвэрийн газар,
- төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар,
- орон нутгийн өмчит үйлдвэрийн газар,
- орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар зэргээр ангилна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ” болон 21.1 дугаар зүйлд “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ” гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу, төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

Компанийн тухай хуулийн 12.5 дугаар зүйлд төр, түүний байгууллага нь дараах тохиолдолд Компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувьцаа эзэмшигч байж болно гэж заасан. Үүнд:

- төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон
- төрийн өмчит үйлдвэрийн газрыг Компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит
- хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа Компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан (Энэ тохиолдолд төр тухайн хувьцааг гурван жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй);
- гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан
- хуульд заасан бусад

5.7.2. Олборлох салбар дахь төрийн оролцоог зохицуулах хууль эрх зүй

Монголд төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, “Компанийн тухай” хуулиар зохицуулдаг. Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өмчит компани байгуулах үйл явц ба тэдгээрийн төрийн төлөөллийн асуудлыг зохицуулдаг. Мөн энэ хууль төрийн ба орон нутгийн өмч, түүний дотор ТӨК-ийн өмчлөх эрхийн асуудлыг хамардаг.

Олборлох салбар дахь төрийн оролцоог зохицуулсан дараах хууль тогтоомжууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль

УИХ-ын тогтоолууд:

- Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай
- Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай
- Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай

Засгийн газрын тогтоол

- Эрдэнэс-таван толгой ХК байгуулах тухай
- Эрдэнэс-Оюутолгой ХХК байгуулах тухай
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Одоогийн хууль эрх зүйн орчинд Монгол Улс нь “Эрдэнэс Монгол” ХХК болон тэдгээрийн охин компаниудаар дамжуулан стратегийн ордууд дээр хувь эзэмшиж, оролцож байна.

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Өнөөдрийн байдлаар компани нь “Эрдэнэс

Тавантолгой” ХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК-иудын 50 буюу түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж байна. Мөн “Оюу толгой” ХХК-ийн Монголын талын 34 хувийг өөрийн охин компаниар дамжуулан эзэмшиж, Тавантолгой -Гашуунсухайт чиглэлийн авто замын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг “Гашуун Сухайт Авто Зам” ХХК-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулан ажиллуулж байна.

5.7.3. 3Г болон ТӨААН-ийн олборлох салбарын компаниуд дахь эзэмшил, эзэмшилд гарсан өөрчлөлтийн шилжүүлгийн нөхцөл

ОУИТБС-ын Стандартын 2.6.a.ii-д 3Г болон ТӨААН нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн түвшнийг ил тод болгоно. Энэ нь ТӨААН-үүдийн салбар болон хамтарсан аж ахуйн нэгжид бас хамааралтай бөгөөд тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг ил тод болгох шаардлагатай.

Компанийн тухай хуулийн 2.6-ын дагуу төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь 3Г болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас эрх олгосон этгээд байж болно.

Нэгтгэл тайланд хамрагдсан ТӨААН-д 2022 онд эзэмшлийн ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 72. ТӨААН-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

№	ТӨААН	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшлийн хувь
1	Тавантолгой	1	Нүүрс	Шандас импекс ХХК	16.31%
				Ажнай корпораци ХХК	19.73%
				Орон нутгийн өмч	51%
				Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	12.96%
2	Монголросцветмет	26	Нүүрс, зэс, алт, жонш, гянтболд, төмөр, шохойн чулуу	Засгийн газар	100.00%
3	Эрдэнэс Монгол	1	Нүүрс, мөнгө	Засгийн газар	100.00%
4	Эрдэнэс тавантолгой	8	Нүүрс	Засгийн газар	85.20%
				ААН	0.50%
				иргэд	14.70%
5	Эрдэнэт үйлдвэр	10	Зэс, дайрга	Засгийн газар	100.00%
6	Багануур	3	Нүүрс, хайрга, элс	Засгийн газар	75.00%
				Монголиан нэшнл коал корпорэйшн	21.06%

№	ТӨААН	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшлийн хувь
				Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	3.94%
7	Шивээ-Овоо	1	Нүүрс	Эрдэнэс МГЛ ХХК	90.00%
				Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	10.00%
8	Оюутолгой	3	Дайрга, Алт, Зэс, Холимог металл, шавар элс	Засгийн газар	34.00%
				Туркойз Хилл Ресурс Рио тинто	66.00%

5.7.4. Төрийн эзэмшилд гарсан өөрчлөлт

2022 онд нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдийн эзэмшилд ямар нэгэн өөрчлөлт гараагүй бөгөөд ТӨААН-үүдийн эзэмшлийн мэдээллийг 5.7.3 хэсгээс үзнэ үү.

5.7.5. Олборлох салбар дахь ТӨААН-ийн гүйцэтгэх үүрэг

Эдийн засагт төрөөс зах зээлийн бус зарчмаар оролцох нэг хэлбэр нь төрийн өмчийн аж ахуйн нэгж байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх арга бөгөөд улс орнуудад төрийн өмчийн аж ахуйн нэгжийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэг, тухайн нэг зах зээлд эзлэх хувь, оролцоо харилцан адилгүй байна. Сүүлийн жилүүдэд улс орны хувьд стратегийн шинжтэй, технологийн шинэчлэл, судалгаа хөгжилд шаардагдах хөрөнгө оруулалт өндөр байдаг салбаруудад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулахыг дэмжихийн сацуу засаглалыг сайжруулах, эзэн-агентын харилцааны сорилт, асуудлуудыг шийдвэрлэж, ил тод байдлыг дээшлүүлэхэд анхаарч байна. Манай улсын хувьд ТӨААН-ийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо нэгдүгээрт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, тухайн зах зээлийн нийт нийлүүлэлт, бүтээмжид нөлөөлөх нөлөөг тодорхойлох, хоёрдугаарт, төсвийн орлого бүрдүүлэлтэд гүйцэтгэх үүргийг тооцох, гуравдугаарт, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт нөлөөлж тогтворжуулах чиг үүргийн хүрээгээр хязгаарлаж шинжлэхээр арга зүйгээ боловсруулсан бөгөөд төрийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохын тулд төрийн өмчийн аж ахуйн нэгжийн эдийн засгийн харилцаанд оролцох нөхцөлийг зохицуулж буй эрх зүйн орчныг судлах шаардлагатай болсон.

ТӨААН-ийн төсвийн орлого бүрдүүлэлтэд үзүүлэх нөлөө өндөр байгаа хэдий ч төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн бүтцийн хувьд авч үзвэл, төрийн өмчийн ногдол ашгийн хэмжээ харьцангуй бага байгаа нь төрийн өмчийн компаниудын хувьд өмчийн өгөөж буюу хувьцаа эзэмшигчийн хүртэх үр өгөөж хангалтгүй байна гэж шууд дүгнэхэд хүргэж байна. Иймд ялангуяа зохицуулалттай зах зээлд ажиллаж байгаа, эсвэл гадаад зах зээлээс бүтээгдэхүүний үнэ ханш хамааралтай байдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд зардлын хяналтыг сайжруулах, бүтээмжийг дэмжсэн технологийн шинэчлэлийг хийх, бүтцийг оновчтой тогтоож, ажиллах хүчний зардлыг хянах замаар ашгийг өсгөх зорилтыг хатуу тогтоож өгдөг, улмаар гүйцэтгэх удирдлагад бүрэн эрхийг оновчтой шилжүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн зорилтыг нь тооцож гүйцэтгэлд нь хяналт тавьдаг зарчимд шилжих нь зүйтэй. Ингэснээр ашиг өсөх, улмаар төрийн өмчийн ногдол ашиг,

аж ахуйн нэгжийн ашгийн татварын хэлбэрээр төсөвт төвлөрүүлэх орлогын дүнг нэмэгдүүлэх боломжтой.

5.7.6. Уул уурхай олборлох салбарын нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүд

“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ



Эрдэнэт Үйлдвэр нь дэлхийд томоохонд тооцогддог зэсийн уурхай, баяжуулах үйлдвэр юм. Анх 1978 онд Монгол – Орос хоёр орны ЗГ хоорондын гэрээний дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

2016 онд Оросын ЗГ-ын эзэмшиж байсан 49 хувь Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн ба энэхүү хэлэлцээр нь хууль шүүхийн байгууллага дээр маргаантай байна. Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан.

Эрдэнэт үйлдвэр нь 2022 онд 3.7 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой байсан нь өмнөх оноос 700 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт ажээ.

“Монголросцветмет” ТӨҮГ



Монголросцветмет нь хайлуур жоншны уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд одоогийн байдлаар гурван далд уурхайн орд, хоёр ил уурхайн орд болон боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай компани юм. Компани нь хүчил болон төмөрлөгийн хайлуур жоншны, мөн алтыг баяжуулан боловсруулах үйл

ажиллагаа явуулдаг.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотод Захиргаа, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр”уулын баяжуулах үйлдвэр, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шижир алт” ХХК, “Зэрэгцээ” алтны үйлдвэрүүдийг багтаан үйл ажиллагаа явуулж байна.

Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49 хувь Монгол улс дахь хувийн эзэмшилд 2016 онд шилжсэн ба Монгол улсын Засгийн газар 100 хувь эзэмшиж байна.

Үйлдвэрийн газар нь:

- Хайлуур жоншны хүдэр олборлолт, баяжуулалт;
- Төмрийн хүдрийн олборлолт, баяжуулалт;
- Алт олборлолт, баяжуулалт;
- Хайрга, дайрга, элс үйлдвэрлэл,
- Геологи хайгуулын ажлын чиглэлээр тус тус үйл ажиллагаагаа явуулан, жилд 550-600 мянган тонн хайлуур жоншны хүдэр, 2.4 сая тонн төмрийн хүдэр олборлон, 320-400 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал боловсруулж, 110-120 мянган тонн жоншны баяжмал үйлдвэрлэн, 2.0 сая тонн алт агуулсан элс угааж нийт 1550 гаруй хүнийг ажлын байраар тогтмол ханган ажиллаж байна.

“Эрдэнэс тавантолгой” ХК



"Эрдэнэс тавантолгой" төсөл 2010 оны 08 дугаар сарын 27-нд хэрэгжих эхлэл тавигдаж, уурхайн уулын ажил албан ёсоор эхлэв. Энэ дагуу Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий "Эрдэнэс Тавантолгой" ХК-г УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-нд байгуулж, үйл ажиллагаагаа эхэлсэн.

"Эрдэнэс тавантолгой" ХК нь Ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлээр 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 9010001097 дугаар бүхий гэрчилгээ авч 5435528 регистрийн дугаартайгаар албан ёсоор Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн бөгөөд "Эрдэнэс тавантолгой" ХК нь "Ашигт малтмалын тухай" хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын нүүрс олборлолтын 28.7 хувийг тус компани дангаар гүйцэтгэсэн бөгөөд сүүлийн таван жилийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой"-н олборлосон нүүрсний хэмжээ 60.4 сая тоннд хүрсэн байна.

“Тавантолгой” ХК



Тус уурхай нь зах зээлийн нөхцөлд зохицон 1994 оны 12 дугаар сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссын хурлын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК болсон байна. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймагт, Хятад – Монголын хилээс ойролцоогоор 270 км-ийн зайтай байрладаг.

Таван толгой компани нь 2022 оны бизнес төлөвлөгөөнд нийт 3.3 сая.тн нүүрс олборлолтын ажил хийхээр төлөвлөж, нийт 2.52 сая.тн нүүрс олборлон бизнес төлөвлөгөөгөө 76 хувьтай биелүүлсэн байна.

“Багануур” ХК



Компани нь 1978 онд үүсгэн байгуулагдаж 1995 онд хувьцаат компани болж 2012 онд “Эрдэнэс монгол” ХХК-ийн охин компани болсон байна. Нөхөн сэргээлтийг 1999 оноос эхлэн 190.5 га талбайд хийсэн байна.

Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулдаг. Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн. 0-200 мм бутармагтай нүүрсийг вагон болон бусад жижиг авто тээврийн хэрэгслээр хэрэглэгчдэд нийлүүлдэг.

“Улаанбаатар төмөр зам” ТӨҮГ



Монгол Улсын төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани болох “Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани нь Төмөр замын салбарт улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр үүссэн өмчийг эзэмших, ашиглах, бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох, төмөр замын салбарт үндэсний компани бий болгох зорилгоор 2008 оны гуравдугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 82 дугаар тогтоол, мөн сарын 20-ны өдрийн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр байгуулагдсан.

УБТЗ нь Монгол Улсын импорт, экспортын ачаа тээврийн 70 гаруй хувийг зөвхөн дангаараа гүйцэтгэдэг, дэлхийн томоохон зах зээл болох Ази, Европыг холбосон төмөр замын хамгийн дөт гүүр гэдгээрээ давуу талтай. Гол замын урт нь 1111, дэлгэмэл уртаараа 1815 км төмөр замтай.

“Шивээ-Овоо” ХК



Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 260 км-т Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт Улаанбаатар-Бээжингийн олон улсын төмөр замын дэргэд далайн төвшнөөс 1180-1230 метрт оршино. Орд нь зүүн хойноосоо баруун урагшаа сунаж тогтсон уртаараа 35 км өргөнөөрөө 15 км хэмжээтэй. Шивээ Овоогийн нүүрсний орд нь нийт 29500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2,708.7 сая тонн нүүрсний нөөцтэй буюу Шинэ-Ус, Өөхийн цагаан, Ногоон тойрмын гэсэн 3 хэсгүүдээс бүрдэнэ. 1986 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлөөс Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын геологи-хайгуулын ажлыг хурдан хугацаанд гүйцэтгэхээр шийдвэрлэж уг шийдвэрийн дагуу тухайн үеийн ГУУҮЯ-наас Төвийн Геологийн Экспедицид нь 1986-1988 онуудад Шивээ Овоогийн нүүрсний орд газрын геологи хайгуулын нарийвчилсан судалгааг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж, 1989 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Улсын нөөцийн комисс”-ын 33 дугаар тогтоолоор ордын геологийн нөөцийг тогтоосноор “Шивээ Овоо”-гийн нүүрсний уурхай нээх эхлэлийг тавьсан юм. Тус компани 2022 оны статистикийн мэдээгээр 2,170 мян.тн нүүрс олборлож 108 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

“Эрдэнэс Монгол” ХК



“Эрдэнэс Монгол” ХХК нь 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. “Эрдэнэс Монгол” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд болон тэдгээртэй хамаарал бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төрд ногдох хувь, төрийн мэдлийн хувьцааг эзэмшиж, тэдгээрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь өргөтгөж ашигт ажиллагааг сайжруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө босгох, нэмүү өртөг бий болгох боловсруулах үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг

нэмэгдүүлэх, компаниудын үйл ажиллагаанд Засгийн газрын бодлогыг уялдуулах зэргээр нэгдсэн стратеги, удирдлагаар хангахад анхаарч ажиллаж ирлээ.

Өнөөдрийн байдлаар компани нь “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК-иудын 50 буюу түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж байна. Мөн “Оюу толгой” ХХК-ийн Монголын талын 34 хувийг өөрийн охин компаниар дамжуулан эзэмшиж, Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн авто замын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг “Гашуун Сухайт Авто Зам” ХХК-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулан ажиллуулж байна.

5.7.7. Засгийн газар болон ТӨААН-ийн санхүүгийн харилцаа

5.7.7.1. ЗГ болон ТӨААН-ийн санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам

ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Компанийн тухай хууль болон тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн Компанийн дүрмээр зохицуулдаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.15-т Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина гэж заасан.

Хуулийн 21.16-д Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана. Гэхдээ тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаасанд хамаарахгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дугаар заалтад Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана. Харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг тогтооно гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд дараах бүрэн эрхтэй гэж заасан. Үүнд:

- 1/ төрийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

- 2/ төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох;
- 3/ төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах;
- 4/ хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг батлах;
- 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;
- 6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 7/ хуульд заасан тохиолдолд бусдын өмчлөлийн зүйлийг төрийн өмчид дайчлан авах шийдвэр гаргах, нийгэмчлэх санал, төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- 8/ төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогын дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 9/ төрийн өмчит хуулийн этгээдийн улсын ба орон нутгийн төсөвтэй харилцах хуваарийг тогтоох, өөрчлөх;
- 10/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны төрийн өмчид ногдох хэсгийг хувьчлах хөтөлбөр, банкин дахь төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх журмыг Монгол банктэй зөвшилцөн батална
- 11/ хуульд заасан бусад бүрэн эрх.

Дээрх хуулийн заалтад үндэслэн Засгийн газар нь тогтоол гарган Төрийн өмчит ААН-ийн санхүүгийн харилцааг зохицуулж байна.

5.7.7.2. Хуримтлагдсан ашиг, ногдол ашиг

ТӨААН-ийн ногдол ашгийн бодлого нь холбогдох статусаасаа хамааран ялгаатай хууль эрх зүйгээр зохицуулагдана.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.3-т заасны дагуу ТӨБЗГ нь төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоодог. Компанийн тухай хуулийн 46.1-д Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх, өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх, эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх зэрэг нөхцөл бүрдсэн үед энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна.

5.7.7.3. Зээл, зээлийн баталгаа

Банкны тухай хуулийн 7.2.Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг 7.2.1-7.2.11-д дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж

өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно гэж заасан. Эдгээр тохиолдлуудад ОУИТБС-ын тайлагналын зорилгоор ил тод болгох талаар зохицуулалт байхгүй байна.

Улаанбаатар төмөр зам, Тавантолгой ХК-уудын санхүүгийн аудитлагдсан 2022 оны тайлан шилэн данс дээр байршаагүй байгаа бөгөөд бусад ТӨААН-ийн зээлийн мэдээллийг шилэн дансны аудитлагдсан тайлангаас авч хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 73. ТӨААН-ийн 2022 онд төлсөн өр төлбөр, зээлийн хэмжээ (сая.төг)

ТӨААН	Зээлийн төрөл	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
Багануур	Богино хугацаат өр төлбөр	139,353.3	164,935.2
	Урт хугацаат өр төлбөр	45,614.1	56,666.6
	Нийт өр төлбөр	184,967.4	221,601.9
Монголросцветмет	Богино хугацаат өр төлбөр	70,859.2	163,686.0
	Урт хугацаат өр төлбөр	202.0	-
	Нийт өр төлбөр	71,061.2	163,686.0
Эрдэнэс монгол	Богино хугацаат өр төлбөр	42,860.0	12,039.8
	Урт хугацаат өр төлбөр	1,006,061.2	977,610.5
	Нийт өр төлбөр	1,048,921.2	989,650.4
Эрдэнэс тавантолгой	Богино хугацаат өр төлбөр	1,415,927.4	2,523,300.5
	Урт хугацаат өр төлбөр	1,644,971.9	1,402,982.1
	Нийт өр төлбөр	3,060,899.3	3,926,282.6
Эрдэнэт	Богино хугацаат өр төлбөр	752,533.3	681,079.5
	Урт хугацаат өр төлбөр	237,927.9	352,973.4
	Нийт өр төлбөр	990,461.2	1,034,052.9
Шивээ овоо	Богино хугацаат өр төлбөр	49,455.5	57,998.7
	Урт хугацаат өр төлбөр	84,470.8	95,730.0
	Нийт өр төлбөр	133,926.3	153,728.8

Эх сурвалж: old.shilendans.gov.mn

5.7.8. ТӨААН-ийн хоорондын гүйлгээ (шаардлага 4.5)

ОУИТБС стандартын шаардлага 4.5-н дагуу Олборлох компаниудын зүгээс ТӨААН-дэд хийсэн төлбөр, ТӨААН-ээс төрийн байгууллагууд, төрийн байгууллагаас ТӨААН хооронд хийгдсэн материаллаг төлбөрийг ил тод болгодог.

Мөн шилэн дансны тухай хуулийн 6.4.5-р заалтын хүрээнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгох шаардлагатай.

Хүснэгт 74. ТӨААН хоорондын гүйлгээний ил тод байдал

Компанийн нэр	ТӨААН хоорондын гүйлгээг ил тод болгосон эсэх	ТӨААН хоорондын гүйлгээг ил тод болгосон линк
Багануур	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5244?group=0&year=2022
Монголросцветмет	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5240?group=0&year=2022

Компанийн нэр	ТӨААН хоорондын гүйлгээг ил тод болгосон эсэх	ТӨААН хоорондын гүйлгээг ил тод болгосон линк
Улаанбаатар төмөр зам	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5241?group=1&year=2022
Шивээ-Овоо	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5229?group=0&year=2022
Эрдэнэс Монгол	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5231?group=0&year=2022
Эрдэнэс таван толгой	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5232?group=0&year=2022
Эрдэнэт	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5239?group=0&year=2022
Тавантолгой	тийм	https://old.shilendans.gov.mn/org/7174?group=0&year=2022

Эх сурвалж: shilendans.gov.mn

5.7.9. ТӨААН-д санхүүгийн тайлангаа олон нийтэд ил тод болгосон байдал (шаардлага 2.6.b)

ОҮИТБС-н шаардлага 2.6б-н дагуу компаниуд санхүүгийн тайлангаа ил тод болгох ёстой бөгөөд нэгтгэл тайланд хамрагдсан ТӨААН-үүдийн санхүүгийн тайлангаа аудит хийлгэсэн болон ил тод болгосон эсэхийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 75. ТӨААН-үүдийн тайлангаа ил тод болгосон эсэх

ТӨААН нэр	ТӨААН нь санхүүгийн тайлан бэлтгэдэг эсэх	Санхүүгийн тайлан аудитлагдсан эсэх	НББ-ийн Олон улсын стандартын дагуу тайлангуудыг бэлтгэсэн эсэх	Олон улсын стандартын дагуу аудитласан эсэх	ТӨААН- ийн тайланг олон нийтэд ил тод болгосон эсэх
Багануур	тийм	тийм	тийм	тийм	тийм
Монголросцветмент	тийм	тийм	тийм	тийм	тийм
Улаанбаатар төмөр зам	тийм	тийм	тийм	тийм	тийм
Шивээ-Овоо	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэс Монгол	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэс таван толгой	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэт	тийм	тийм	тийм	тийм	тийм
Тавантолгой	тийм	тийм	тийм	тийм	тийм

Эх сурвалж: ТӨААН

5.7.10. ТӨААН-ийн санхүүгийн тайлан

ОҮИТБС-ын Стандартын шаардлагаар ТӨААН-үүд нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан боломжгүй бол өөрийн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авдаг. Нэгтгэлд хамрагдсан 8 ТӨААН-ийн ил тод болгосон байдлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 76. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн ил тод байдал

Компанийн нэр	Шилэн дансанд санхүүгийн тайланг ил болгосон эсэх	Санхүүгийн тайланг ил тод болгосон линк	Компанийн цахим хуудсанд ил болгосон эсэх	Санхүүгийн тайланг ил тод болгосон линк
Багануур	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5244?for m=6357715&year=2022&month=12&group=0&task=725	тийм	https://baganuurmine.mn/category/санхүүгийн-тайлан/
Монголросцв етмет	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5240?for m=6361790&year=2022&month=12&group=0&task=728	үгүй	
Улаанбаатар төмөр зам	үгүй		тийм	https://www.ubtz.mn/details/35fd2ed5273a9ba908a8da028ae58fd8b8be5f9821fc58e1d7da160695a4cf2b
Шивээ-Овоо	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5229?for m=6360798&year=2022&month=12&group=0&task=632	тийм	https://shivee-ovoo.mn/news/tailan/360-2022-ony-sanhgiyn-taylan.html
Эрдэнэс Монгол	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5231?for m=6364030&year=2022&month=12&group=0&task=695	үгүй	
Эрдэнэс таван толгой	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5232?for m=6365509&year=2022&month=12&group=0&task=697	тийм	https://ett.mn/mn/files-by-category/109
Эрдэнэт	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5239?for m=6364776&year=2022&month=12&group=0&task=731	үгүй	
Тавантолгой	үгүй		тийм	http://mse.mn/mn/company/458?type=5#idd=9975

Эх сурвалж: *shilendans.gov.mn*

5.7.11. ТӨААН-ийн аудитын тайлан

5.7.11.1. ТӨААН-ийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журам

Төрийн аудитын тухай хууль нь аудитын тайланг цахим хуудсаараа ил тод болгохыг шаарддаг бөгөөд энэ хуулийн зорилго нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино. 2022 онд төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

5.7.11.2. ТӨААН-үүдийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журмын практик хэрэгжилт

Үндэсний Аудитын Газрын цахим хуудсанд 2019 оноос хойш ТӨААН-ийн аудитын тайлан ороогүй байна. Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдийн 8 нь шилэн дансны цахим хуудсанд аудитын тайлангаа оруулсан байна.

Хүснэгт 77. ТӨААН-үүд аудитын тайлангаа ил тод болгосон эсэх

Компанийн нэр	ТАБ-ын цахим хуудсанд ил тод болгосон эсэх	Шилэн данс цахим хуудсанд ил тод болгосон эсэх	Ил тод болгосон линк
Багануур	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5244?group=0&year=2022
Монголросцветмет	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5240?group=0&year=2022
Улаанбаатар төмөр зам	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5241?group=1&year=2022
Шивээ-Овоо	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5229?group=0&year=2022
Эрдэнэс Монгол	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5231?group=0&year=2022
Эрдэнэс таван толгой	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5232?group=0&year=2022
Эрдэнэт	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/5239?group=0&year=2022
Тавантолгой	Үгүй	Тийм	https://old.shilendans.gov.mn/org/7174?group=0&year=2022

Эх сурвалж: audit.mn, shilendans.gov.mn

5.7.12. ТӨААН-ийн үйл ажиллагаа, хөрөнгийн зардал, худалдан авалт, туслах гүйцэтгэгч, Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам, практик үйл ажиллагаа (шаардлага 2.6.с)

5.7.12.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах суурь бичиг баримт нь компанийн дүрэм байна.

Хүснэгт 78. ТӨААН-ийн дүрэм ил тод болгосон эсэх

Компанийн нэр	Компанийн дүрмээ ил тод болгосон эсэх	Ил тод болгосон линк
Багануур	Тийм	http://baganuurmne.mn/ёс-зүйн-дүрэм/
Монголросцветмет	Тийм	http://www.mongolros.mn/a/11
Улаанбаатар төмөр зам	Тийм	https://www.ubtz.mn/content/71e5ea7239f61bff4444e2c8c37fabcf8f
Шивээ-Овоо	Тийм	https://shivee-ovoo.mn/duramjuram
Эрдэнэс Монгол	Тийм	http://www.erdenesmongol.mn/index.php?view=article&type=item&val=197
Эрдэнэс таван толгой	Тийм	https://ett.mn/mn/files-by-category/10

Компанийн нэр	Компанийн дүрмээ ил тод болгосон эсэх	Ил тод болгосон линк
Эрдэнэт	Тийм	https://www.erdenetmc.mn/transparency/code-of-ethics
Тавантолгой	Тийм	https://www.tavantolgoi.mn/rules-and-regulations

Нэгтгэлд хамрагдсан 9 ТӨААН-ийн 6 нь дотоод дүрмээ цахим хуудсандаа ил тод болгосон байна.

5.7.12.2. ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлагад (үйл ажиллагаа /урсгал/ болон хөрөнгө оруулалтын) хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлага нь Шилэн дансны тухай хуулиар зохицуулагддаг.

Хүснэгт 79. 2022 онд Шилэн дансны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт

Нэмэлт өөрчлөлт	Огноо	Агуулга
Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2022 оны 12 сарын 09 өдөр	1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9, 6.5.10 дахь заалтын "концессын гэрээ" гэснийг "төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ" гэж, мөн зүйлийн 6.2.4, 6.5.8 дахь заалтын "концессын зүйлийн жагсаалт" гэснийг "төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт" гэж, мөн зүйлийн 6.5.10 дахь заалтын "концесс эзэмшигч" гэснийг "хувийн хэвшлийн түншлэгч гэж, "концессын зүйл" гэснийг "төр, хувийн хэвшлийн түншлэлийн зүйл" гэж тус тус өөрчилсүгэй.
		2 дугаар зүйл. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалтын "концесс", 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын "концесс," гэснийг тус тус хассугай.
		3 дугаар зүйл. Энэ хуулийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эх сурвалж: legalinfo.mn

5.7.12.3. ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын практик үйл ажиллагаа

Нэгтгэл тайланд хамрагдсан 8 ТӨААН-ийн хувьд хөрөнгийн зарцуулалтыг шилэн дансны портал сайтад байршуулан олон нийтэд ил тод мэдээлж байлаа.

Хүснэгт 80. Шилэн дансанд ил тод болгосон эсэх

Компанийн нэр	Шилэн дансанд ил болгосон эсэх	Санхүүгийн тайланг ил тод болгосон линк
Багануур	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5244?group=0&year=2022
Монголросцветмет	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5240?group=0&year=2022
Улаанбаатар төмөр зам	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5241?group=1&year=2022
Шивээ-Овоо	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5229?group=0&year=2022
Эрдэнэс Монгол	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5231?group=0&year=2022
Эрдэнэс таван толгой	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5232?group=0&year=2022

Компанийн нэр	Шилэн дансанд ил болгосон эсэх	Санхүүгийн тайланг ил тод болгосон линк
Эрдэнэт	тийм	https://old.shilendans.gov.mn/org/5239?group=0&year=2022
Тавантолгой	үгүй	https://old.shilendans.gov.mn/org/7174?group=0&year=2022

Эх сурвалж: shilendans.gov.mn

5.7.12.4. ТӨААН-ийн худалдан авалтад хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авалтыг явуулна. ТӨААН-үүд уг хуульд нийцүүлэн дотооддоо худалдан авалтын дүрэм журам батлан мөрддөг.

Шилэн дансны тухай хуулиар

- худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Хуулийн 6.1.1 заалтын хүрээнд),
- худалдан авах ажиллагааны тайлан (Хуулийн 6.1.1, 6.1.2 заалтын хүрээнд)
- худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг тухай бүр /хэрэв байгаа бол/
- хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг (Хуулийн 6.3.6, 6.4.3, 6.8.2 заалтын хүрээнд) тухай бүр ил болгох шаардлагатай.

Хүснэгт 81. Худалдан авалтын ил тод байдал

Компанийн нэр	Шилэн дансанд ил болгосон эсэх				Ил тод болгосон линк
	1	2	3	4	
Багануур	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5244?group=0&year=2022
Монголросцветмет	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5240?group=0&year=2022
Улаанбаатар төмөр зам	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5241?group=1&year=2022
Шивээ-Овоо	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5229?group=0&year=2022
Эрдэнэс Монгол	+	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5231?group=0&year=2022
Эрдэнэс таван толгой	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5232?group=0&year=2022
Эрдэнэт	-	+	-	+	https://old.shilendans.gov.mn/org/5239?group=0&year=2022
Тавантолгой	-	+	-	-	https://old.shilendans.gov.mn/org/7174?group=0&year=2022

Эх сурвалж: shilendans.gov.mn

5.7.12.5. ТӨААН-ийн туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулахтай холбоотой дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-ийн туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулахтай холбоотой хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй. ТӨААН-үүдээс “Эрдэнэс Тавантолгой” ХК туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний мэдээллийг тайлагнасан бөгөөд нийт компаниудын туслан гүйцэтгэгчийн мэдээллийг энэхүү тайлангийн Хавсралт 28-д харуулав.

5.7.13. Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон практик үйл ажиллагаа

5.7.13.1. ТУЗ-ийн бүрэлдэхүүн томилох дүрэм журам, практик үйл ажиллагаа

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүдийн тоог Компанийн дүрмээр тодорхойлох бөгөөд хувьцаат компани болон төрийн өмчийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлд ТУЗ-ийг сонгох, эрхийг хугацаанаас нь дуусвар болгохтой холбоотой асуудлыг тусгасан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно.

ХХК-иудын хувьд Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно. Хувьцаат Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байна. Нэгтгэлд хамрагдсан 9 ТӨААН-с “Багануур” “Шивээ-Овоо” “Эрдэнэс Монгол” “Эрдэнэс Тавантолгой” “Тавантолгой” эдгээр компаниуд ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг явуулсан бөгөөд Хавсралт 19-д харуулав.

5.7.14. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд

ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд ордог. Эдгээр зардлуудыг шилэн дансны цахим хуудаснаас үзэх боломжтой бөгөөд холбогдох линкийг доорх хүснэгтэд оруулав.

Хүснэгт 82. ТӨААН-ийн шилэн дансны мэдээлэл

Компанийн нэр	Холбогдох линк
Багануур	https://old.shilendans.gov.mn/org/5244
Монголросцветмет	https://old.shilendans.gov.mn/org/5240
Улаанбаатар төмөр зам	https://old.shilendans.gov.mn/org/5241
Шивээ-Овоо	https://old.shilendans.gov.mn/org/5229
Эрдэнэс Монгол	https://old.shilendans.gov.mn/org/5231
Эрдэнэс таван толгой	https://old.shilendans.gov.mn/org/5232
Эрдэнэт	https://old.shilendans.gov.mn/org/5239

Компанийн нэр	Холбогдох линк
Тавантолгой	https://old.shilendans.gov.mn/org/7174

5.8. Төсвийн үйл явц болон орлогын хуваарилалт

5.8.1. Олборлох салбарын орлогын хуваарилалт

Сангийн яамны ирүүлсэн мэдээгээр Монгол Улсын 2022 оны төсвийн бодлоготой холбоотой хууль тогтоомжид “Орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, ажлын байр бий болгох, уул уурхайн салбарт салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн орон нутагт өгсөн хандив, тусламжийг бүртгэх, ил тод, нээлттэй болгох зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгох зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 дэх заалтаар нэмж оруулсан” болохыг мэдээлэв. Харин сангийн зарцуулалтын хувьд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.3-д тус тус заасны дагуу 2022 онд Улсын төсвийн алдагдлыг нөхөхөд 751.7 тэрбум төгрөгийн зардал гарсан байна.

Олборлох салбараас орж ирж буй орлогыг улсын төсвийн санхүүгийн тайланд бүртгэхдээ Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөж дараах байдлаар бүртгэж байна. Үүнд:

- Дт Мөнгөн хөрөнгө
Кт АМНАТ орлого
- Замд яваа АМНАТ-ын оролгыг
Дт Замд яваа мөнгөн хөрөнгө
Кт АМНАТ орлого

5.8.2. Олборлох салбараас орж ирсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдол (шаардлага 5)

5.8.2.1. Орон нутгийн шилжүүлэг

Орон нутгийн хөгжлийн сан бол иргэдийн саналаар шийдэж зарцуулах төсөв юм. Тус сан нь засаг захиргааны нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон бие даан хэрэгжүүлэх ёстой чиг үүргүүдээ санхүүжүүлэх боломж бүрдүүлдгээрээ давуу талтай юм.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС)-ийн эх үүсвэрийг дотоодын НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг.

Хүснэгт 83. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2022 оны орлогын шилжүүлгийн мэдээлэл /мян.төг/

Аймаг		ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг		УТ-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг		ОУ-н байгууллагаа с сумдын ОНХС-д олгох урамшуулал	Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
		ГТНАТ -н 70%	АМНАТ-н 10%	МХТЗ-н 100%	АМАТЗ 50%		НИЙТ
1	Архангай	161.0	5,935.5	6.3	104.8	608.2	6,815.9
2	Баян-Өлгий	156.0	5,751.7	268.0	158.8	79.8	6,414.3
3	Баянхонгор	214.6	7,911.2	229.6	1,080.8	704.2	10,140.5
4	Булган	140.7	5,185.5	100.3	414.6	225.5	6,066.6
5	Говь-Алтай	223.6	8,241.3	856.6	610.0	211.2	10,142.7
6	Дорноговь	1,135.5	12,483.3	1,547.2	1,926.2	289.8	17,382.5
7	Дорнод	1,146.4	12,307.8	632.1	563.3	302.5	14,952.2
8	Дундговь	157.8	5,817.0	624.4	1,038.7	237.4	7,875.3
9	Завхан	174.9	6,446.9	233.3	201.5	128.0	7,184.6
10	Өвөрхангай	173.7	6,402.9	143.3	162.3	903.0	7,785.1
11	Өмнөговь	273.3	15,078.0	552.6	2,675.2	282.4	18,861.4
12	Сүхбаатар	173.5	10,883.1	262.7	538.4	201.0	12,058.7
13	Сэлэнгэ	155.2	11,069.4	70.1	434.8	390.0	12,119.5
14	Төв	177.9	10,484.2	329.2	1,106.9	426.1	12,524.3
15	Увс	170.5	6,2866.2	463.2	175.9	115.2	7,211.0
16	Ховд	173.2	9,911.6	274.3	136.4	299.0	10,794.5
17	Хөвсгөл	217.1	8,001.5	-	61.8	542.5	8,823.0
18	Хэнтий	173.6	6,398.3	419.6	430.6	434.1	7,856.3
19	Дархан-Уул	123.8	7,979.4	2.1	59.2	302.6	8,467.2
20	Улаанбаатар	686.7	25,311.8	-	49.5	-	26,048.1
21	Орхон	120.7	9,454.2	-	108.3	232.3	9,915.5
22	Говьсүмбэр	78.5	2,893.4	6.9	141.2	85.1	3,205.1
Нийт		6,208.3	200,235.2	7,021.6	12,179.3	6,999.9	232,644.3

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 84. Монгол улсын 2022 оны төсөвт аймгуудад олгохоор батлагдсан санхүүгийн дэмжлэгийн дүн /мян.төг/

№	Харьяалал	Санхүүгийн дэмжлэг
1	Архангай	15,390.5
2	Баян-Өлгий	8,776.3
3	Баянхонгор	17,678.0
4	Булган	5,751.2
5	Говь-Алтай	15,103.7
6	Дорноговь	-
7	Дорнод	-
8	Дундговь	11,936.1
9	Завхан	14,834.7
10	Өвөрхангай	18,581.1
11	Өмнөговь	-
12	Сүхбаатар	6,690.8
13	Сэлэнгэ	-
14	Төв	9,202.6
15	Увс	14,755.3
16	Ховд	6,890.4
17	Хөвсгөл	21,748.7

№	Харьяалал	Санхүүгийн дэмжлэг
18	Хэнтий	11,865.4
19	Дархан-Уул	-
20	Улаанбаатар	-
21	Орхон	-
22	Говьсүмбэр	1,376.5
Нийт		180,581.3

Эх сурвалж: Сангийн яам

5.8.3. Орлогын менежмент ба зарцуулалт

5.8.3.1. Төсвийн орлого бүрдүүлэлтэд олборлох салбарын оролцоо

2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр улсын төсөвт 4,390.2 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Нүүрс 2,062.4 тэрбум төгрөг,
- Зэс 1,717.2 тэрбум төгрөг,
- Алт 258.0 тэрбум төгрөг,
- Цайр 168.9 тэрбум төгрөг,
- Төмөр 41.6 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 26.4 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 115.7 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 544.7 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар өссөн байна. Үүнд:

- Зэс 704.7 (29.1%) тэрбум төгрөг,
- Төмөр 131.7 (76.0%) тэрбум төгрөг,
- Цайр 64.5 (61.8%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 82.3 (75.7%) тэрбум төгрөг
- Алт 30.7 (13.5%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 1,305.5 (172.5%) тэрбум төгрөг,
- Бусад 62.8 (118.7%) тэрбум төгрөг.

5.8.3.2. Орлогын тогтвортой байдал, байгалийн баялгаас хамааралтай байдал (Шаардлага 5.3)

Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг харуулав.

Хүснэгт 85. Уул уурхайн салбарын 2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын төрөл	Хэмжих нэгж	2022 оны батлагдсан төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Зөрүү
Газрын тосны орлого	тэрбум.төг	215.4	115.7	-99.7
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	тэрбум.төг	31.4	35.6	4.2
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	тэрбум.төг	17.5	2.0	-15.5

Орлогын төрөл	Хэмжих нэгж	2022 оны батлагдсан төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Зөрүү
Бусад орлого	тэрбум.төг	2.7	3.6	0.9
Өөрийн орлого	тэрбум.төг	25.0	14.5	10.5

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ 2022

5.8.3.3. Уул уурхайн салбарын хөгжлийн хандлага

Олон улсын уул уурхай, металлын зөвлөл (The International Council on Mining and Metals "ICMM")-ийн судалгаагаар бага болон дунд орлоготой ихэнх орны хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт (FDI)-ын 60-90 хувь, экспортын 30-60 хувь, татварын 20 хувь, Үндэсний нийт орлогын 10 хүртэлх хувийг уул уурхайн салбар нь дангаар бүрдүүлдэг гэж үзсэн байдаг.

Монгол Улсын уул уурхайн салбар 2000 оны эхнээс улам хурдацтай хөгжиж, 2014 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний дөрөвний нэгийг үйлдвэрлэх болсон.

Дэлхийн эдийн засгийн форумаас Монгол Улсыг уул уурхайн салбараас олох орлого нь нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах хамгийн өндөр боломжтой орнуудын тоонд оруулж, уул уурхайн хөгжлөөс орж ирэх баялаг нь улс орны хөгжил дэвшлийг хурдасгах нөлөөтэй ч сайтар удирдан зохицуулаагүй тохиолдолд байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөтэйг анхааруулсан. Мөн эдгээр сөрөг нөлөөг зөв зохицуулж, иргэдийнхээ ахуй амьдрал, эрүүл мэнд, нийгмийн сайн сайханд анхаарсан хөгжлийн бат бөх суурийг тавих нь Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болж байгааг цохон тэмдэглэсэн. /Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС/

Эрдэс баялгийн салбарын талаарх тэргүүлэгч орнуудын байр суурь:

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден Стратегийн эрдсийн /Critical minerals/ нөөцийг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалт хийхээ 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр мэдэгдсэн байна. Тухайлбал, Цагаан ордонд хийсэн мэдэгдэлд, Калифорни муж дахь MP Materials компанийн эзэмшдэг Mountain Pass уурхайн газрын хүнд ховор элемент (HREEs)-ийг арилжааны хэмжээний боловсруулах байгууламж барихад дэмжлэг үзүүлэхээр зорилгоор Батлан хамгаалахын яамнаас 35 сая долларын санхүүжилт хийхээ мэдэгджээ. Цагаан ордон MP Materials корпорацийн санхүүжилтээс гадна Berkshire Hathaway Energy (BHE) Renewables компани энэ хавар Калифорни мужийн Импераил хотод газрын гүний дулаанаас тогтвортой литийн олборлох үйл явц нь боломжтой эсэхийг судлах шинэбайгууламжийг барих төсөлд хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа зарлав. Энэ нь ирэх таван жилд литийн тогтвортой үйлдвэрлэлийг хангах төслүүдэд хийгдэхолон тэрбум долларын хөрөнгө оруулалтын нэгээхэн хэсэг болох юм.Хэрэв энэ төсөл амжилттай болбол 2026 он гэхэд батареин зэрэглэлийн литийн гидроксид болон литийн карбонатыг үйлдвэрлэн арилжаалах боломжтой болох юм. Энэ хөндийд хамгийн том литийн ордууд байдаг бөгөөд BHE Renewables-ийн үйлдвэрүүд жилд 90000 тн лити үйлдвэрлэх боломжтой билээ.

Канад Улс

Канадын стратегийн голлох эрдэс нь эдийн засгийн хөгжилд нэн чухал үүрэгтэй. Учир нь тухайн голлох ашигт малтмалууд нь нүүрс төрөгч багатай, дижитал эдийн засагт шилжихэд нэн чухал ач холбогдол үзүүлэх юм. Канад Улс нь өссөн нэмэгдэж буй дэлхийн эрэлт, хэрэгцээг хангах үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрээ оруулахад бэлэн байгаа билээ. Сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологи (батарей, соронз, нарны хавтан, салхин турбин), батлан хамгаалах болон аюулгүй байдлын салбарт хэрэглэгддэг тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний цахилгаан бараа, хөдөө аж ахуй, эмнэлгийн тоног төхөөрөмж болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэлтэд голлон ашиглагддаг ашигт малтмалууд юм. Энэхүү бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хангах гинжин хэлхээнд өөрийн улс орны байр суурийг хурдан баталгаажуулж чадсанаар Канад Улсын эдийн засаг нь урт хугацаандаа тогтвортой, өсөлттэй байж чадах юм.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин: Эдийн засагт голлох нөлөө үзүүлдэг уул уурхай, олборлох салбарт шинэ стандарт, өндөр технологи нэвтрүүлнэ.

2022 оны ОХУ-ын онцлох стратегийн эрдэс:

1. Лити-дахин цэнэглэх аккумуляторт ашиглагддаг
2. Газрын ховор элемент
3. Тантал-электрон эд ангиудад ихэвчлэн конденсаторууд болон супер хайлшуудад ашиглагддаг
4. Ниоби-ихэнхдээ ган болон супераллойд ашигладаг
5. Төмрийн хүдэр-бүх төрлийн металл хийц


5.8.3.4. Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс: Монгол Улсын хувьд 2021 онд зэсийн баяжмалын үнэ 2,261.1 ам.доллар байсан ба энэ үед 1,282.5 мян.тонн зэсийн баяжмал экспортолж, 2,421.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харин 2022 онд зэсийн баяжмалын үнэ 1,881.8 ам.долларт хүртлээ буурч, 1,453.3 мян.тн зэсийн баяжмал экспортолж, 1,717.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Зэсийн баяжмалын экспортын хувьд энэ нь өмнөх онтой харьцуулахад 13.3 хувь буюу 170.8 мянган тонноор өссөн хэдий ч улсын төсөвт төвлөрүүлсэн орлогынхоо хувьд 704.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Алт: Монголбанк 2022 оны арванхоёрдугаар сард 3,032.2 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр 22.9 тонн үнэт металл худалдан авлаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлт болов. Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс оны эхнээс өссөн дүнгээр 3,264.9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 1,436.0 кг үнэт металл тус тус худалдан авсан байна.

Монголбанк үнэт металл худалдан авах үнийг дэлхийн зах зээл дээрх үнээр тогтоогдог бөгөөд өнгөрсөн арванхоёрдугаар сард дундаж үнэ 207,625 төгрөг байв.

График 9. 2018 оноос 2022 он хүртэлх Монголбанкны худалдан авсан үнэт металлын мэдээ /кг/



Эх сурвалж: Монголбанк

Төмрийн хүдэр: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 391.0 сая ам.долларын 4,732.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 561.2 сая ам.доллар буюу 58.9 хувиар, биет хэмжээгээр 2,374.0 мян.тн буюу 33.4 хувиар тус тус буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Газрын тос: 2021 онд Ковид-19-ийн хөл хорио суларч эдийн засгийн хориг нээгдсэнээр агаар, усан зам болон газрын тээвэр эрчимжсэн нь газрын тосны үнийг хурдтай өсгөх нэг гол шалтгаан болжээ. Тухайлбал, брент маркийн газрын тосны хаалтын үнэ 2021 оны 12 сарын 27-ны өдөр 79.61 доллар байсан бол 2022 оны 12 сарын 27-ны өдөр 84.98 доллар болж өсжээ.

5.8.3.5. Системтэйгээр ил тод болгосон байдал

Олборлох салбараас олсон орлогыг төвлөрүүлж буй сангуудын орлого, зардал, үйл ажиллагааны тухай мэдээллийг ил тод болгох (Шаардлага 5.3.а).

Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны тухай тайлбар болон төсөв боловсруулах, зарцуулах, төслийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн тухай олон нийт дараах сувгуудаас нээлттэй мэдээлэл авч болно (Шаардлага 5.3.а).

Хүснэгт 86. Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны нээлттэй мэдээлэл

Цахим хуудас	Тайлбар
www.mof.gov.mn	Сангийн яамны үндсэн цахим хуудас бөгөөд яамны бүтэц, бодлого, чиглэл, төсвийн талаарх мэдээ, мэдээлэл
www.iltod.gov.mn	Төсвийн тухай цаг үеийн мэдээ, мэдээлэл, жил бүрийн төсвийн мэдээлэл, төсвийн холбогдолтой хууль, тогтоол, заавар журам
www.shilendans.gov.mn	Бүх төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээ мэдээлэл
www.tusuv-oronnutag.mof.gov.mn	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл
https://publicinvestment.gov.mn "Төсвийн хөрөнгө оруулалт" аппликэйшн	Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааны онлайн веб хуудас болон гар утасны "Төсвийн хөрөнгө оруулалт" аппликэйшн

Цахим хуудас	Тайлбар
www.e-balance.mof.gov.mn	Аж ахуйн тайлангийн нэгдсэн систем бөгөөд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар, тушаал зөвлөгөө
www.audit.mn	Аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмж
www.tender.gov.mn	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем
www.1212.mn	Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сан
www.worldbank.org/mn/country/mongolia	Дэлхийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.imf.org/en/Countries/ResRep/MNG	Олон улсын валютын сангийн Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.adb.org/countries/mongolia/main	Азийн хөгжлийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.internationalbudget.org	Интернэйшнэл Баджет Партнершип ТББ-ын цахим хуудас

БҮЛЭГ 6. БУСАД АСУУДАЛ

6.1. Эцсийн өмчлөгч (Шаардлага 2.5)

Эцсийн өмчлөгчид гэдэг нь аливаа компанийг жинхэнэ эзэмшдэг, удирддаг, эсвэл түүнээс ашиг хүртдэг хүмүүсийг хэлэх ба хууль ёсны хувьцаа эзэмшигчид болон компанийг төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтнуудаас өөр хүмүүсийг хэлдэг. Эцсийн өмчлөгч нь тухайн компанид заавал хувь эзэмшсэн байх шаардлагагүй бөгөөд компанийн шийдвэр гаргалтад оролцож, нөлөөлж, нарийн төвөгтэй өмчлөлийн бүтцийн ард нуугдаж, шууд болон шууд бусаар ашиг хүртэж байдаг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын стандартаар 2020 оны 1 дүгээр сарын 1 гэхэд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч компаниудын ашиг хүртэгч эцсийн эзнийг олон нийтэд нээлттэй болгох, холбогдох бүртгэлийн сантай байхыг хэрэгжүүлэгч улс орнууддаа шаардлага болгосон. Үүнээс шалтгаалан эцсийн өмчлөгчийн талаар ОУИТБС-ын Олон улсын хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүснэгт 87. Эцсийн өмчлөгчийг ил тод болгох талаар хэрэгжүүлж байсан арга хэмжээ

Он/сар	Авсан арга хэмжээ
2013 оны 5-р сар	ЭӨ-ийн бүртгэлийг тайлагнахыг шаардах болсон.
2013 оны 10-р сар	ОУИТБС-ын 11 орон ЭӨ-ийн туршилтын төслийг хэрэгжүүлсэн
2016 оны 1-р сар	ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 29 орон тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. 9 орон тайландаа энэ мэдээллийг оруулж байна.
2016 оны 2-р сар	ОУИТБС-ын шинэ стандартаар 2020 оны 1-р сарын 1 гэхэд ЭӨ-ийг ил тод болгохыг шаардсан.
2023 он	ОУИТБС-аар ЭӨ-ын асуулгын маягыг шинэчлэх санаачилга дэвшүүлж, загвар маягт гаргасан.

2016 онд ОТАХ-ээс ашиг хүртэгч эзэд буюу эцсийн өмчлөгч гэдэг ойлголт, түүний эрх зүйн орчин, боломж, сорилт, асуудал, ашиглаж болох тогтолцоо зэргийг судлах ажлын дэд хэсэг томилсон ба тус дэд ажлын хэсгээс эцсийн өмчлөгчдийн мэдээллийг ил тод болгох Замын зургийн төслийг боловсруулж, 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, 2017 оны 12-р сарын 21-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 4-р сарын 12-ны 114 тоот тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэхүү тогтоолын хавсралт төлөвлөгөөний 4.1.6.5-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох ба 2020-2022 онд хэрэгжүүлж, МОУИТБС-ын Ажлын алба хариуцахаар тусгасан байна.

Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлөөс “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (ҮАҮТ)”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаар ҮАҮТ-ний төслийг дэмжиж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан ба нийт 13 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг Үндэсний зөвлөл 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хуралдан хэлэлцэж, баталсан. Энэхүү төлөвлөгөөний 12 дахь зорилтот үйл ажиллагаа нь Байгалийн баялгийг ашиглагч этгээдийн эздийг буюу эцсийн өмчлөгчдийг ил болгох тухай бөгөөд Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар даалгажээ.

6.1.1. Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар ашиг хүртэгч эцсийн эзний ил тод болгохтой холбоотойгоор нэр томьёо, тодорхойлолт, хамрах хүрээ, материаллаг босго, цуглуулах мэдээлэл зэргийг хэлэлцэж, эцэслэн баталсан. Энэхүү хуралдаанаар батлахаас өмнө төр, компани, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 9 цуврал хэлэлцүүлгээр нийт 260 гаруй оролцогчид хэлэлцэж, саналыг тусган, эцсийн хувилбарыг боловсруулсан байна. Мөн дараах тодорхойлолтуудыг тохирсон. Үүнд:

“Ашиг хүртэгч эцсийн эзэн” гэдэгт эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч, хөрөнгө оруулагч, тендерт оролцогч, гэрээлэгч хуулийн этгээдийн 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эсхүл түүнтэй адилтгах үнэт цаасыг, 20 хувь буюу түүнээс дээш саналын эрхийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, өмчилдөг, хүртдэг, удирдлага, хяналтыг шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг, эсхүл бусад хэлбэрээр эрхээ хэрэгжүүлдэг хувь хүнийг ойлгоно.

“Эзэмшил, өмчлөлийн эрхийг шууд бус хэлбэрээр хэрэгжүүлэх” гэдэгт өөрийн эзэмшлийн хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаас, саналын бусад эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, холбогдох этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх эсхүл 1 буюу түүнээс дээш үргэлжлэх гинжин холбоо бүхий хуулийн этгээдийн үүсгэн байгуулахыг ойлгоно.

“Шууд удирдлага, хяналтын эрх” гэдэгт Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл болон Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, их хэмжээний хэлцлийг байгуулах шийдвэрийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран гаргах эрхийг ойлгоно.

“Шууд бус удирдлага, хяналт” гэдэгт Компанийн удирдлага, хяналтын эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр эсхүл өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх нөхцөл байдлыг ойлгоно

Хэрэв ашиг хүртэгч эцсийн эзэн нь улс төрд нөлөө бүхий этгээд бол түүнд болон түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдийн хувь эзэмшилд босго тогтоох шаардлагагүй (0 хувь) бөгөөд нийтэд заавал ил тод мэдээлнэ.

“Улс төрд нөлөө бүхий этгээд” гэдэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан албан тушаалтнуудыг ойлгоно.

Эцсийн өмчлөгчийн ил тод байдал


2020 оны ОУИТБС-ын тайланд зориулан нэг үе шат бүхий асуулгаар шууд эцсийн өмчлөгчийг тодорхойлох маягтыг боловсруулж, цахим тайлангийн системд оруулсан. 2021 онд ОУИТБС-ын шаардлагын дагуу холбогдох мэдээллүүдийг цуглуулж байсан бол энэ жил илүү дэлгэрэнгүй ил тод болгох үүднээс ОУИТБС-аар эцсийн өмчлөгчийн

маягтыг шинэчлэхээр урьдчилсан байдлаар загвар маягтаа батлан түүгээрээ холбогдох мэдээллүүдээ цуглуулсан. Үүнд:

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн өмчлөлийн хэлбэр
- Компанийн хууль ёсны өмчлөл
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх
- Овог нэр
- Үндэс угсаа
- Эцсийн өмчлөгчийн овог, нэр
- Иргэний харьяалал, давхар иргэншил
- Оршин суугаа улсын нэр
- Улс төрд нөлөө бүхий этгээд эсэх
- Компанидаа удирдах албан тушаал хашдаг эсэх
- Одоо хашиж буй ажлын газрын хаяг
- Хувьцааны тоо
- Эзэмшлийн хувь хэмжээ
- Өмчлөлийн хувь хэмжээ
- Шууд саналын эрхийн хувь хэмжээ
- Шууд бус саналын эрхийн хувь хэмжээ
- Компанийн хяналтыг бусад аргаар хэрэгжүүлдэг эсэх

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 576 компанийн 2472 эцсийн өмчлөгчийн мэдээлэл ирсэн нь өмнө жилтэй харьцуулахад 38.7 хувиар өсжээ.

График 10. 2020-2022 оны эцсийн өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн байдал



Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын эцсийн өмчлөгч эздийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 20(б,в)-д харуулсан. Харин дараах хүснэгтээр эцсийн өмчлөгчдийг иргэний харьяаллаар нь харууллаа.

Хүснэгт 88. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эцсийн өмчлөгч

№	Улс, орон	Иргэншил	Улс төрд нөлөө бүхий албан тушаалтан эсэх	Энэ компанид удирдах албан тушаалтан эсэх
1	Монгол	2021	12	12
2	Австрали	21	19	0
3	Канад	6	0	0
4	Тайланд	36	0	0

№	Улс, орон	Иргэншил	Улс төрд нөлөө бүхий албан тушаалтан эсэх	Энэ компанид удирдах албан тушаалтан эсэх
5	АНУ	19	0	0
6	БНХАУ	245	0	0
7	Болгар	2	0	0
8	Испани	10	0	0
9	Казак	21	0	0
10	Нидерланд	4	0	0
11	ОХУ	8	0	0
12	Солонгос	5	5	0
13	Филиппин	1	0	0
14	ХонгКонг	20	0	0
15	Швейцарь	19	0	0
16	Япон	32	0	0
Нийт		2472	36	12

Мөн Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар 2019 оны 3-р сараас эхлэн эцсийн өмчлөгчдийн талаар зарим мэдээллийг <http://opendata.burtgel.gov.mn> сайтад төвлөрүүлж эхэлсэн бөгөөд уг сайтад одоогийн байдлаар буюу 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 223,695 хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, бүртгэгдсэн огноо, компанийн хэлбэр (ХХК), компанийн төрөл (ашиг, ашгийн бус), үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүний тоо, удирдлагын овог, нэр, албан ёсны хаяг болон үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаар мэдээллүүд байна.

6.2. Гэрээний ил тод байдал

Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн салбарт баримтлах бодлогын гол баримт бичигт ил тод байдал, хариуцлагын зарчмуудыг тусгасан, гэрээний ил тод байдлыг хангах, бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцлалын заалтыг арилгах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авсан билээ.

Нээлттэй нийгэм форумаас (ННФ) “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг ОУИТБС-ын Ажлын алба, Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА)-тай хамтран УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яамны дэмжлэгтэйгээр 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Энэхүү олон талт хэлэлцүүлэг нь эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлаар оролцогч талууд, түүний дотор төр, олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд, иргэний нийгмийн ойлголт, байр суурийг нэгтгэн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан юм. Хэлэлцүүлэгт оролцсон талууд гэрээний ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтыг хангах зорилгоор Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, Засгийн газар, түүний холбогдох байгууллагаас ашигт малтмал, газрын тосны салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан бүхий л гэрээг байршуулах талаар хамтран ажиллахаа илэрхийлж, Зөвлөмж гаргасан болно. Хэлэлцүүлгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг http://forum.mn/index.php?sel=project&menu_id=29&obj_id=5007 цахим хуудаснаас авна уу.

Мөн нээлттэй нийгэм Форум (ННФ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Ажлын алба хамтран www.iltodgereee.mn сайтыг байгуулсан. Уг санд ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмал гэх мэт байгалийн баялгийг ашиглахтай холбоотой Хөрөнгө оруулалтын болон Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Концессын гэрээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн захиргаатай байгуулдаг Орон нутгийн гэрээ зэрэг Монгол улсын эрдэс баялгийн салбарт байгуулагддаг гэрээнүүдийн эх бичвэрийг байршуулдаг. Олборлох салбарт хамаараалтай ил тод байршиж буй хууль эрх зүйн үндсэн заалтуудын жагсаалтыг доор харууллаа.

Хүснэгт 89. Гэрээний ил тод байдал


№	Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заал	Холбоос
Хууль			
1	Монгол Улсын Үндсэн хууль	6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэг	https://legalinfo.mn/mn/detail/367
2	Ашигт малтмалын тухай	5 дугаар зүйлийн 5.3-5.5 дахь хэсэг, 42 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/63?lawid=63
3	Байгууллагын нууцын тухай хууль	4 ба 6 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/102?lawid=102
4	Газрын тосны тухай	12,13,14, 17 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/10484?lawid=10484
5	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, 3 ба 4 дүгээр зүйл.	http://legalinfo.mn/law/details/224?lawid=224
6	Захиргааны ерөнхий хууль	11, 26-28 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/11259?lawid=11259
7	Концессын тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/312?lawid=312
8	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/374?lawid=374
9	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	40 дүгээр зүйл	http://legalinfo.mn/law/details/9750?lawid=9750
10	Хөрөнгө оруулалтын тухай	20 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/9491?lawid=9491
11	Цөмийн энергийн тухай	4 дүгээр бүлэг 2931 дүгээр зүйл	http://legalinfo.mn/law/details/97?lawid=97
12	Шилэн дансны тухай хууль	6 дугаар зүйлийн 6.4.8, 6.5.9-6.5.10, 7.1.1 дэх заалт	https://legalinfo.mn/mn/detail/10497
Төрийн бодлого			
13	Төрийн бодлого Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	3.1.7 ба 3.5.2 дахь заалт	http://legalinfo.mn/law/details/9756?lawid=9756
Дүрэм, журам			
14	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам		https://nda.gov.mn/backend/f/YvefVW2tL5.pdf

№	Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заал	Холбоос
Улсын Их Хурлын тогтоол			
15	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох тухай	Бүхэлдээ	https://legalinfo.mn/mn/detail/11651
16	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/6405?lawid=6405
17	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/6631?lawid=6631
18	“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/10318?lawid=10318
Засгийн газрын тогтоол			
19	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	7 ба 8 дахь заалт	http://legalinfo.mn/law/details/8791?lawid=8791
20	Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай	Бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/10568?lawid=10568

2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Нээлттэй нийгэм форум, ОУИТБС болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран ОУИТБС-ын стандарт 2.4 дэх шаардлагыг биелүүлэх, гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилгоор Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим санг байгуулсан. Энэхүү мэдээллийн цахим сан нь олон нийт, сэтгүүлчид, эрдэмтдэд эрдэс баялгийн гэрээнүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг бүрэн эхээр нь нээлттэй болгож өгсөн.

Сүүлийн 3 жилийн хугацаанд ил тод байдлын санаачилгын мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо дунджаар 8.5 хувиар нэмэгдсэн байгаа нь харагдаж байна.

График 11. Мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо



2023 оны 11-р сарын 24-ны байдлаар энэхүү мэдээллийн санд бүртгэгдсэн 973 гэрээ, 162 гэрээний заалтын тайлбар, 8 хууль тогтоомжийн дэлгэрэнгүй мэдээлэл байршуулсан байна.

Хүснэгт 90. Мэдээллийн санд байршуулсан гэрээ

№	Гэрээний төрөл	Тоо
1	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ	276
2	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ	97
3	Газар ашиглах тухай гэрээ	130

№	Гэрээний төрөл	Тоо
4	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ	67
5	Ус ашиглах тухай гэрээ	64
6	Ашиглалтын өмнөх гэрээ	41
7	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	27
8	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ	23
9	Тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ	29
10	Газрын тосны эрлийн гэрээ	16
11	Тогтвортой байдлын гэрээ	11
12	Бусад	112
13	Олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ	29
14	Концессын гэрээ	4
15	Хөрөнгө оруулалтын гэрээ	4
16	Усны сан бүхий газрын энгийн хамгаалалттай бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ	29
17	Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ	2
18	Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд хамтран ажиллах гэрээ	1
19	Гэрээний хавсралт	3
20	Нийгмийн хариуцлагын гэрээ	1
21	Орхон аймаг „ЭРДМИН” ХХК-ийн 2022 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө	1
22	Төлөвлөгөө	4
23	Үйлчилгээний гэрээ	1
24	Хамтын ажиллагааны санамж бичиг	1
Нийт		973

Эх сурвалж: <http://www.iltodgeree.mn/search>

Мэдээллийн санд байршуулсан нийт гэрээний жагсаалтыг Хавсралт 38-өөс үзнэ үү.

6.3. Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо (Шаардлага 4.3)

Зарим тохиолдолд улс орны байгалийн нөөц баялгийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд мөнгөн бус хэлбэрээр бараа болон үйлчилгээ үзүүлэх (дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх) гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтын жишээнд зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль болон эмнэлгүүд багтана.

Тухайн компаниудад ирэх өгөөж нь газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын нөөц бөгөөд газар, эрчим хүч болон усны нөөц ашиглах эрх гэх мэт бусад элементээс бүрддэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл “дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ” гэж нэрлэдэг.

2022 онд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар 33 компани 45 удаагийн 100 сая төгрөгөөс дээш дүнтэй дэд бүтцийн хөрөнгө оруулалт, бартерын солилцоо хийсэн гэж мэдээлсэн. Дэлгэрэнгүйг Хавсралт 33-с харна уу./ Эх сурвалж/

6.4. Тээвэрлэлтийн орлого (Шаардлага 4.4)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олсон орлого нь материаллаг байгаа үед ЗГ болон Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүд хүлээн авсан орлогоо толилуулах шаардлагатай байдаг.

ААН-үүдийн тээвэрлэлтийн орлогын мэдээлэл болох тээвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл, тээвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэмжих нэгж болон тээвэрлэлтийн орлогыг хүлээн авсан төрийн байгууллагуудын нэрийг дараах хүснэгтэд тайлагнасан байна.

Хэвлэн нийтэлсэн мэдээлэл нь өөр бусад орлогын урсгал, төлбөрийн урсгалын нэгэн адил хэмжээнд задаргаатай байх шаардлагатай (4.7). Олон талт оролцогчдын бүлэг нь тээвэрлэлтийн орлогын тухай мэдээллийн чанар, дээр заасан мэдээллийн баталгаажуулалттай холбоотой журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу гарган, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь дараах мэдээллийг ил болгоно. Үүнд:

- Тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл, үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани болон төрийн байгууллага (төрийн өмчит аж ахуйн нэгж мөн хамаарна);
- Тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар;
- Тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг ил тод болгон тайлагнах;
- Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлогыг ил тод болгон тайлагнах

6.5. Нөхөн сэргээлтийн мэдээлэл

Монгол Улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зэрэг үндсэн 3 байгууллага хариуцдаг.

Уул уурхайн салбар байгаль орчинд хамгийн их доройтол учруулдаг, байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг ашигладаг, Монголын ард түмний уламжлалт нүүдлийн мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлдэг. Ийм учраас уул уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажилд дагаж мөрдөх хууль, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах ажилд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байнга анхаарал хандуулж, ажиллаж ирсэн.

2022 онд ОУИТБС-ын стандартын шаардлага 6.1-ийн дагуу нөхөн сэргээлтийн мэдээллийг цахим тайлангийн маягаар нэгтгэсэн ба дэлгэрэнгүй байдлаар нийт 299 компани нөхөн сэргээлтийн мэдээлэл оруулсан. Компаниудын ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээллээр тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөн санд 3,162.03 сая төгрөг,

тусгай дансанд төвлөрүүлсэн байна. Уг төлбөрийн мэдээлэл болон нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээллийг Аймаг, сум, талбайн нэр бүрээр тайлангийн Хавсралт 23-аас үзнэ үү.

Байгаль орчны хамгаалах уул уурхайн нөхөн сэргээлтийн ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин 1988 оноос эхлэн бүрэлдэж, холбогдох хуулиуд батлагдаж, шинэчлэгдсээр байна. Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр мөрдөгдөж буй хуулиудыг дор харуулав.

Зураг 6. Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр мөрдөгдөж буй хуулиуд

1988 он	Газрын хэвлийн тухай хууль
2006 он	Ашигт малтмалын тухай хууль 1988 он
2009 он	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
2012 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчны бусад хуулиуд, эрх зүйн актууд	

Эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 30 гаруй журам, аргачлал батлан мөрдүүлж байгаагаас дараах журмуудыг онцлон харууллаа.

Зураг 7. Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх хуулиудын хүрээнд мөрдөгдөж буй журмууд

2014 он	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А/04 дүгээр тушаал</i>
2015 он	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал <i>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/138 дугаар тушаал</i>
2018 он	Газрын тос, уламжлалт бус газрын тос эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүн авах журам <i>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын хамтарсан А/50, А/31 дугаар хамтарсан тушаал</i>
2019 он	Уурхайн, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам <i>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181. А/458 дугаар тоот тушаал</i>
2019 он	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал</i>
Байгаль орчны бусад хуулиуд, эрх зүйн актууд	

Байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд БОАЖЯ-аас 2022 оны байдлаар нийт 19 аймгийн 46 сумд 93 аж ахуйн нэгж 6093.79 га талбай ашигласнаас, 727.57 га-д нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг https://eic.mn/box/box13.php?count=100&page=2&search_report_year=2022 холбоосоор боломжтой.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон менежментийн төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах эрхийг хангах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг

ашиглах, үйлдвэр, үйлчилгээ эрхлэх, салбарын хүрээнд баримтлах бодлого болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтоох зорилготой.

Уул уурхайн салбар нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-иас ихээхэн хамааралтай. Уг хуулийн дагуу аливаа уул уурхайн төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийлгэхийг шаарддаг бөгөөд үйл явцыг л доорх зургаар харууллаа.

Зураг 8. БОТБҮ хийх үйл явц

- 1 Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө БОТБҮ-г эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- 2 БОТБҮ-г үндэслэн БОАЖЯ болон аймаг, нийслэлийн Байгаль орчны алба ажлын 14 хоногт багтаан БОННУ-ний дүгнэлт гаргана.
- 3 БОННУ хийлгэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан ажиллах бөгөөд мэргэжлийн байгууллага нь БОННУ болон 5 жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулж хамтад нь БОАЖЯ-д хүргүүлнэ.
- 4 БОННУ-ний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
- 5 БОАЖЯ-ны БОНУ-ний мэргэжлийн зөвлөл нь БОННУ-ний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

Дээрх дурьдсан БОННУ-ээс БОМТ болон мониторингийн хөтөлбөр боловсруулдаг бөгөөд эдгээр нь БОННУ-д багтсан зөвлөмж, дүгнэлтүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дараах үе шаттайгаар боловсруулах шаардлагатай байдаг.

Зураг 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үе шат

- 1** Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн БОМТ-г Байгаль хамгаалах хууль тогтоомж, БОННУ-ний үр дүн, батлагдсан БОМТ-д үндэслэн ашиглалтын жил бүр шинэчлэн боловсруулна.
- 2** БОМТ-ний гүйцэтгэл, биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгуулж ажлын хэсгийн дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулна.
- 3** Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухайн оны жилийн мэдээ (маягт БОХ-3)-ний дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба уг маягтыг БОМТ-нд заавал хавсаргана.
- 4** Төсөл хэрэгжүүлэгч нь БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг хавсарган дараа жилийн БОМТ-г боловсруулан БОАЖЯ-нд 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.
- 5** Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр заалтын дагуу БОННУ-ний тайлан, БОМТ-ний хэрэгжилтэд 2 жил тутамд хийлгэсэн байгаль орчны аудитын тайланг тухайн жилийн БОМТ-ний хамт БОАЖЯ-нд ирүүлнэ.
- 6** БОАЖЯ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан, батална.

БОАЖЯ-аас мэдээлснээр Уул уурхайн олборлолтын төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэгт зааснаар байгаль орчны мэдээллийн сангийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн мэдээллийн хэсэгт хуримтлагддаг болно. Үүнийг <https://www.eic.mn/eia/> холбоосоор үзнэ үү. 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар тус мэдээллийн санд уул уурхайн чиглэлээр байгаль орчны үнэлгээ хийх 180 байгууллага байгаа бөгөөд уул уурхайн чиглэлээр хийсэн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 7,381 тайлан, уул уурхайн төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 2,598 тайлан байна.


График 12. Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, үнэлгээний чиглэлээр



Эх сурвалж: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан

Сүүлийн 2 жилд батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийн тоо буурч байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засаг унасантай холбоотой байж болох юм.


График 13. Батлагдсан нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, оноор



Эх сурвалж: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан

Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хувьд ч мөн адил дээрх хэлбэлзэл ажиглагдаж байна.

График 14. Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, оноор



Эх сурвалж: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан

Байгаль орчныг хамгаалах тусгай данс

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид ашигласан талбайг нөхөн сэргээхдээ Байгаль орчны тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар заалт нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийг тодорхойлсон бол 39 дүгээр заалт нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, “Ашигт малтмалын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу төвлөрүүлнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг хамгаалах шаардлага хангуулах зорилготойгоор хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аль аль нь холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд өөрсдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шаардагдсан тухайн жилийн төсвийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шилжүүлэх үүрэгтэй.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд /БОХТ/ тусгагдсан үүргээ биелүүлсэн тохиолдолд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж олгоно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОНБУ болон БОХТ-д тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгөн хөрөнгийг уурхайн хаалтын үе шатанд буцааж олгоно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОХТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглан шаардлагатай арга хэмжээг нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

6.6. Цахим тайлагналын систем

Цахим тайлангийн систем нь уул уурхай, газрын тосны компаниудын улс болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамж, хандив дэмжлэгийн мэдээлэл ба Монгол Улсын Засгийн Газрын хүлээн авсан татвар, төлбөр, хураамжийн тухай мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох зорилготой. Түүнчлэн тусгай зөвшөөрөл болон олборлох үйл ажиллагааны явцад хэдий хэмжээний байгалийн баялгийг ашигласан тухай мэдээллийг иргэний нийгмийн байгууллагууд болон сонирхсон хэрэглэгчдэд мэдээлэх гол хэрэгсэл нь байх болно. Үүний үр дүнд төр болон компани, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, итгэлцлийг нэмэгдүүлэх юм. Тиймээс энэхүү цахим тайлагналын систем нь улс орны хэмжээнд өндөр ач холбогдолтой. Тухайлбал:

- Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал нэмэгдэх;
- Мэдээллийг цаг алдалгүй, шуурхай авах;
- Өөр өөр эх үүсвэрийн мэдээллийг нэг дороос авах ;
- Лицензийн байршил, харьцуулсан үзүүлэлтийн мэдээллийг кадастрын зураглалаас харах;
- Уул уурхайн хайгуул олборлолт, газрын тосны үйлдвэрлэл борлуулалт, туршилтын талаарх нэгдсэн мэдээллийн сангаас хайлт, шүүлт хийж мэдээлэл авах боломжтой.

Зураг 10. Цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмууд

Нээлттэй ба үнэ төлбөргүй мэдээлэл

- Мэдээллийг интернетээр нийтлэх, ингэснээр олон нийтэд үнэ төлбөргүй мэдээллийг хүртээх боломжтой.

Олон нийт хандах боломжтой байх

- Компьютер ба цахимд суурилсан хэрэгслүүдийг ашиглан мэдээлэлд хандах боломжтой буюу оролцогч талууд өөрсдийн хэрэгцээт мэдээллийг бүх төрлөөр харж боломжтой.

Өөртөө үйлчлэх

- Хэрэглэгч өөрийн хүссэнээр дагуу мэдээллийг МОУИТБС-ын өгөгдлийн сангаас шууд татан авч, төрөл бүрийн байдлаар задлан шинжлэх хэрэглэх боломжтой.


Одоогоор <http://eitimongolia.mn/> цахим хуудсаар олон нийт, иргэдэд Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудыг хавсралтуудын хамт үнэ төлбөргүйгээр хүргэхээс гадна уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаар дараах гол статистик тойм мэдээллүүдийг толилуулж байна. Үүнд:

Цахим хуудаснаас
авах мэдээлэл

- Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл
- Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл
- Хайгуулын ажлын статистик мэдээлэл
- Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл
- Татвар төлбөрийн статистик мэдээлэл
- Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл
- Эдийн засагт оруулсан хувь нэмэрийн талаарх статистик мэдээлэл
- Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан гэрээ
- Ил тод, нээлттэй компаниуд
- Ашиг хүртэгч эздийн ил тод байдал
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ
- Бенефициар эзэд

Эх сурвалж: www.eitimongolia.mn, 2022

Зураг 11. ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага



Эх сурвалж: ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага

6.7. Ашигласан усны мэдээлэл

Ашигласан усны мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэдэг ба 2022 онд нийт 99,275,009.3 метр.куб ус ашиглахаар гэрээ хийснээс 58,832,521.1 метр.куб буюу гэрээлсэн усны 59.2 хувийг ашигласан байна. Мөн ус ашигласны төлбөр 41.3 тэрбум, бохирдуулсны төлбөр 1.6 тэрбум төгрөг төвлөрсөн.

Хүснэгт 91. 2022 оны ус ашиглалтын мэдээлэл

Утга	Хэмжээ
Гэрээнд заасан ашиглах усны хэмжээ (метр куб)	99,275,009.3
Ашигласан нийт усны хэмжээ (метр куб)	58,832,521.1
Ашигласан гадаргын усны хэмжээ (метр куб)	29,164,437.1
Ашигласан газрын доорх усны хэмжээ (метр куб)	29,668,084.0
Гэрээнд зааснаас дутуу ашигласан усны хэмжээ (м3)	44,660,319.4
Ус ашигласны төлбөр (сая.төгрөг)	41,333.2
Ус бохирдуулсны төлбөр (сая.төгрөг)	1,612.9

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

2022 онд 41,333.2 сая.төгрөгийн усны төлбөрийг хүлээн авсан ба доорх 10 компани 37,116.5 сая.төгрөгийн төлбөр төлсөн буюу нийт төлбөрийн 89.7 хувийг бүрдүүлж байна. Усны төлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 25а, б-ээс харна уу.

Хүснэгт 92. 2022 онд усны төлбөр төлсөн ТОП 10 компани


Компани	Ус ашигласны төлбөр (сая.төгрөг)	Дүнд эзлэх хувь	Ус бохирдуулсны төлбөр (сая.төгрөг)	Дүнд эзлэх хувь
Эрдэнэт	17,395.5	46.8	1,401.3	95.2
Оюу Толгой	14800.7	39.8	-	0.0
Петрочайна Дачин Тамсаг	1091.8	2.9	2.2	0.1
Энержи Ресурс	946.0	2.5	35.0	2.3
Бороо Гоулд	793.1	2.1	-	0.0
Багануур	675.1	1.8	-	0.0
Цайртминерал	421.9	1.1	8.0	0.5
Эрдэнэс Алт Ресурс	376.7	0.01	17.1	1.0
Энхтунх Орчлон	315.4	0.08	-	0.7
Батбродерс Майнинг	300.0	0.08	8.0	0.5
ТОП 10	37,116.5	89.7	1,471.9	91.2
Нийт компани	41,333.2	100	1,612.9	100

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

6.8. Хог хаягдлын мэдээлэл

2022 онд 185 компани нийт 1,347.2 сая төгрөгийг хог, хаягдлын төлбөрт төвлөрүүлсэн байна. Энэхүү төлбөр нь Улаанбаатар хот болон 19 аймагт төвлөрсөн бөгөөд хог хаягдлын хэмжээ болон төлбөрийн мэдээллийг Хавсралт 26-өөс дэлгэрэнгүй харна уу.

Зураг 12. Хог хаягдлын мэдээлэл, м³



Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Цахим тайлангийн системд ирүүлсэн мэдээллээс хамгийн өндөр төлбөр төлсөн 10 компанийн мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 93. Хог хаягдлын өндөр төлбөр төлсөн 10 компани

Компани	Аймаг / Нийслэл	Төлсөн төлбөр (сая.төгрөг)
Эрдэнэт	Орхон	431.1
Эрдэнэс Таван Толгой	Өмнөговь	287.7
Энержи Ресурс	Өмнөговь	206.8
Хос-Хас	Булган	60.0
Бүрдэл майнинг	Төв	34.8
Тэн Хун	Төв	23.8
Степ Голд	Дорнод	23.1
Бороо Гоулд	Сэлэнгэ	14.4
АУМ Алт	Өвөрхангай	13.4

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

6.9. ОУИТБС-ын тайлангийн задаргааны төвшин, хэлбэр (Шаардлага 4.7)

Энэхүү тайланд хамрагдах төлбөр, орлогын мэдээллийг компани, төрийн байгууллагууд болон орлогын урсгал, төсөл нэг бүрээр дэлгэрүүлэн тайлагнасан ба төслийн төвшнөөр мөн задалж харуулсан. Төслийн түвшнээр харуулсан дэлгэрэнгүйг Хавсралт 22-с үзнэ үү.

ОУИТБС-ын стандартад төсөл гэж юу болохыг тодорхойлсон ба стандартад өөрчлөлт орох болсон шалтгаан нь ЗГ төсөл тус бүрээс хэдий хэмжээний орлого авч байгаа талаар ил тод болгох, заавал ил тод болгох дүрэмд төсөл бүрээр, ОУИТБС-ын зөвлөл нь 2018 он болон түүнээс цааш орлогыг төслөөр нь задлан харуулах шаардлагыг 2017 онд баталсан.

МОУИТБС-ын ОТАХ төсөл, харилцан холбоотой гэрээг дараах байдлаар тодорхойлжээ.

Төсөл нь нэг гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрээр зохицуулагдан, төртэй хамаарах төлбөрийн үүрэг хариуцлагын үндсийг бүрдүүлж буй үйл ажиллагааг ойлгоно.

Харилцан холбоотой гэрээ нь үйл ажиллагаа болон газар зүйн хувьд уялдмал гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрүүд эсвэл ЗГ-тай байгуулж, төлбөрийн үүргийг тусгасан, агуулгын хувьд ижил нөхцөл бүхий хамаарах гэрээнүүдийг хэлнэ. Ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг нэг гэрээ, хамтарсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн хуваах гэрээ эсвэл бусад нийтлэг зохицуулах эрх зүйн гэрээ зэргээр ерөнхийлөн зохицуулсан байна.

ОУИТБС-ын маягтаар авч буй төслийн төвшний мэдээлэл

ОУИТБС-ын цахим тайлангийн маягтыг бөглөхдөө тухайн хэрэгжүүлж буй төслийн талаарх дараах үндсэн мэдээллийг оруулахаар зааж өгсөн. Үүнд:

- Компанийн нэр
- Регистр
- Төслийн нэр
- Төслийн гэрээний огноо
- Техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийн огноо
- Техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийн дугаар
- Ашиглах хугацаа
- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан нийт хөрөнгө оруулалт
- Хөрөнгө оруулалтын нийт гүйцэтгэл
- Тайлант оны төлөвлөсөн хөрөнгө оруулалт
- Тайлант оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан жилийн хүчин чадал
- Төсөл эхэлснээс хойших гаргасан бүтээгдэхүүний хэмжээ
- Тайлант онд гаргасан бүтээгдэхүүний хэмжээ
- Дараа онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ

БҮЛЭГ 7. ЗӨВЛӨМЖ

7.1 Өмнөх жилийн нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 94. ОУИТБС-ын 2018, 2019, 2020, 2021 оны нэгтгэл тайлангуудад болон 2022 оны Баталгаажуулалтын тайланд тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
Зорилт 19. 2018, 2019, оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	19.1. Олборлох салбартай холбоотой мэдээллийг УУХҮЯ-д төвлөрүүлэх, мэдээллийг хянаж, шалгасны дараа бусад Засгийн газрын байгууллагад түгээж байх;	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹ 13.2-д “Эрдэс баяаг олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг ГУУГТ-ны асуудал эрхэлсэн ТЗТ байгууллага хариуцна гэж заасан.	УУХҮЯ
	19.2. Орон нутгийн холбогдох төрийн байгууллагуудын хүлээн авсан хандивын мэдээллийг иж бүрнээр цахим сайтад байршуулах; аймгийн аудитын газар сангууд, хандивын асуудалд аудит хийх.	2023 улсын төсвийн тухай хуулиар хандивыг ОХС-д хүлээн авч, бүртгэн зарцуулна.	Аймгийн Аудит-ын газар УУХҮЯ
	19.3. Аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг ОУИТБС-ын вэбсайт дээр тусад нь байршуулах;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.4. ТӨААН-ийн ТУЗ-ийн гишүүдийг ил болгох, хөндлөнгийн хараат бус гишүүдийг сонгож байгаа аргачлал, журмыг олон нийтэд мэдээлэх;	“ТӨААН-ийн ТУЗ-ийн гишүүдийг ил болгох, хөндлөнгийн хараат бус гишүүдийг сонгож байгаа аргачлал, журмыг олон нийтэд мэдээлэх;- гэсэн 2021 оны тайлангийн зөвлөмж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.6-д тусгалаа олж, 2022 оны 5-р сараас хэрэгжиж байна.	УУХҮЯ
	19.5. ТӨААН-ийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг нээлттэй болгох;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.6. Компаниудын БОННУ, Менежментийн төлөвлөгөө, тайланг ОУИТБС-ын веб сайт дээр байршуулах;	ОУИТБ-ын хуулийн төслийн ² 7.1.10в, 7.1.15а-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ
	19.7.Боловсруулах салбарын томоохон үйлдвэрлэгч болон туслан гүйцэтгэгч нарыг ОТАХ судалж, улсын төсөвт томоохон хувь нэмэр оруулж буй компаниудыг урьдчилан сонгож, тэдэнд албан ёсоор мэдэгдэж, цахим тайлангийн системд үндсэн мэдээллийг оруулснаар, ил тодын тайланг тушаах нөхцлийг бүрдүүлж, улмаар ОУИТБС-ын нэгтгэлд хамруулах;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.8 Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил жилийн нэгтгэлийн тайлангаар зөвлөмж өгдөг боловч энэ тал дээр томоохон ахиц харагдахгүй байгаа нь Эрдэс баялгийн ил тод	ОУИТБ-ын хуулийн төслийн ³ боловсруулсан ХЗДХЯ-ны цахим сайт дээр санал авч байна.	УУХҮЯ

¹ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

² ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

³ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
	байдлын тухай хуулийг баталж мөрдүүлэх нь чухал болохыг харуулж байна.		
	19.9. Хуулийн өөрчлөлт нь ТЕГ-ын алтны компаниудын АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн горимд нөлөөлсөн боловч ОУИТБС-ын тайлангаа зөв дүнгээр тайлагнах, АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн байдалд тавих хяналтад нөлөөлөхгүй тул ТЕГ нь мэдээллийн системээ сайжруулж, ОУИТБС-ын тайлангаа үнэн зөв тайлагнах тал дээр цаашид анхаарах;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.10. АМГТГ-ын кадастрын систем, ОУИТБС-ын цахим систем дэх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, нэг эх үүсвэртэй мэдээлэл дээр цахим тайлангийн системийг ажиллуулах, хөдөө орон нутагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг кадастрын системд цаг алдалгүй оруулж, олон нийтэд мэдээлж байх;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.11. Цахимаар авч байгаа мэдээллийг оролцогч талууд баталгаажуулах, бүгдийг олон нийтэд ил тод болгох, эсвэл сонгогдсон компаниудын мэдээллийг хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох;	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
	19.12. Цаашид Хараат бус хянагч нэгтгэгчийн оролцоо багасах үед тоо мэдээний чанар, үнэн зөв байдал улам илүү тавигдах болно гэдгийн үйл ажиллагаандаа анхаарч ажиллахыг зөвлөж байна. Үүнд: 1. Хамгийн их зөрүү гаргаж буй, мэдээллээ ил тод нийтлэхгүй, тайлагналын хариуцлага хүлээхгүй байгаа байгууллагад сургалт зааварчилгаа өгөх, нөлөөллийн арга хэмжээнүүд авах. 2. Монголын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэлийн тайланг албан бичгийн хамт хүргүүлж, цаашид хэрхэн хамтарч ажиллахыг зөвлөх.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ
Зорилт 20. 2020 оны уян хатан нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	20.1 ЗГ-ын зүгээс тушааж байгаа ил тод байдлын тайланг Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулдаг байх, компаниудын тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулдаг тогтолцоог хэвшүүлэх шаардлагатай байна;	ОУИТБС-ын хуулийн төслийн ⁴ 17.3; 18.4-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ
Зорилт 21. 2021 оны уян хатан нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	21.1 Засгийн газрын орлого, компанийн төлбөрийн зөрүүтэй холбоотой асуудал жил бүр түгээмэл гарч байгаад анхаарч мэдээллийн чанарыг сайжруулах.	ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулж байна, ингэснээр алдаатай гаргах явдлыг бууруулна.	Сангийн яам, Холбогдох ААН-үүд
	21.2 Цахим тайлангийн системд байршуулж буй мэдээллийн бүрдлийг алдаагүй, иж бүрэн байх хүрээнд цахим тайлангийн системд программын тохиргоо хийх.	ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулж байна, ингэснээр алдаатай гаргах явдлыг бууруулна.	Сангийн яам
	21.3 Ирэх жилүүдэд ОУИТБС-ын нэгтгэл тайланг уян хатан бус буюу илүү олон ААН-ийг хамруулсан байдлаар хийх, үүнд зориулан төсөв хөрөнгийг шийдвэрлэх.	2022 оны нэгтгэл тайланг уламжлалт аргачлалаар боловсруулж байна. Энэ удаа 104 компани хамрагдаж байна.	УУХҮЯ, ОУИТБС
	21.4 Цаашид тайланг илүү сайжруулах, илүү олон төрлийн мэдээллийг ил тод болгох, хэрэглэгчдэд ойлгомжтой, тодорхой байдлаар тайлагнах талд анхаарах.	ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулж байна, ингэснээр	ОУИТБС

⁴ ОУИТБС-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
		хэрэглэгчдэд ойлгомжтой, тайлагнахад хөнгөн болно.	
	21.5 Гэрээний ил тод байдлыг илүү сайжруулах. Тухайлбал орд ашиглах гэрээнд нууцлах шаардлагагүй мэдээлэл, зохицуулалтуудыг ил тод болгох. Гэрээний мэдээллийн сангийн үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс төрд хүлээн авах.	ОУИТБ-ын хуулийн төслийн ⁵ 7.1.3-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, Холбогдох ААН-үүд
Зорилт 22. 2022 оны ОУИТБС-ын Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн дагуу авах арга хэмжээг хэрэгжүүлэх;	22.1 ОУИТБС-ын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө олон улсын стандартын дагуу боловсруулах, эхний хагас жилд хянан, үзэж, холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах тухай журамлах.	2023 оны Ажлын төлөвлөгөөг ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу боловсруулж батлуулан, мөрдөж байна. ⁶	ОУИТБС
	22.2 Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын гишүүдийн чадавхыг сайжруулах сургалтад хамруулах.	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж чадавхийг нэмэгдүүлж байна.	Аймгуудын ЗДТГ, ТББ-ууд
	22.3 ОУИТБС-ын болон бусад өгөгдөл мэдээллийг кодлон нээлттэй мэдээлэл болгох, олон нийтэд нээлттэй бусад өгөгдөл мэдээлэлтэй харьцуулах боломжийг хангах.	ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулж байна, ингэснээр нээлттэй өгөгдөл болгох суурийг тавина.	Сангийн яам
	22.4 Жил бүрийн ОУИТБС-ын тайлангаар өгч байгаа зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянах, өөрийн үнэлгээ хийх Ажлын дэд хэсэг байгуулах, үр дүнгээ Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулах тухай журамлах	Бүх зөвлөмжүүдийг хүлээн авч, ажлын төлөвлөгөөг болон ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна.	УУХҮЯ, ОУИТБС
	22.5 Монгол Улсад ОУИТБС-ын хэрэгжилтийг идэвхжүүлэх талаар Удирдах дээд түвшний албан тушаалтнаар мэдэгдэл хийлгэх.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ, ОУИТБС
	22.6 ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцогч байгаа Компанийн төлөөлөл, удирдлагын оролцоог сайжруулах, журамлах.	2024 онд шилжүүлэх.	УУХҮЯ, ОУИТБС
	22.7 Баталгаажуулалтын үр дүн, зөвлөмжийн талаар үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах.	Ажлын хэсгээр хэлэлцүүлж, 2023 оны ажлын төлөвлөгөөнд оруулсан байна.	УУХҮЯ, ОУИТБС
	22.8 Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн журмыг жендерийн төлөөллийг нэмэгдүүлэх, ёс зүйн дүрмийн чиглэлээр нэмэлт шаардлага оруулан шинэчлэх.	2024 онд шилжүүлэх	ОУИТБС
	22.9 Геологийн үндэсний албатай явагдаж буй, төлөвлөгдөж байгаа хайгуулын ажиллагаа, геологийн мэдээллийг системтэйгээр ил тод болгох чиглэлээр мэдээллээ солилцдог болох, хөгжүүлэх.	ОУИТБ-ын хуулийн төслийн ⁷ 7.1.5-д холбогдох заалтыг оруулсан.	АМГТГ
	22.10 Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийг хүйс, компани, ажлын байраар нь, мөн албан бус олборлолтын үйл задаргаатайгаар ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ⁸ 7.1.14-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОУИТБС
	22.11 Төрийн байгууллагууд системтэйгээр ил тод болгох, мониторингд иргэдийг оролцуулах, журамлах.	2024 онд шилжүүлэх	Төрийн байгууллагууд
	22.12 Ил тод гэрээний цахим сайтыг тогтмол шинэчлэх, 2021 оны 1-р сарын 1-нээс хойш байгуулагдсан гэрээ, нэмэлт, өөрчлөлт, тусгай зөвшөөрөл, хавсралтын хамт иж бүрнээр ил тод болгох.	2024 онд шилжүүлэх	Сангийн яам

⁵ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

⁶ <https://www.eitimongolia.mn/p/10>

⁷ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

⁸ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
	22.13 Олборлох салбарын байгаль орчны менежмент болон хөрөнгө оруулалтын мониторингтой холбоотой хууль эрх зүйн зүйл заалтууд, захиргааны актыг ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ⁹ 7.1.1, 8.1.1, 9.1.1, 10.1.1-д холбогдох заалтыг оруулсан	БОАЖЯ, Хууль зүйн яам
	22.14 Шинээр олгосон, шилжүүлсэн, шууд болон сонгон шалгаруулалтыг оруулан тусгай зөвшөөрлийн бүх мэдээллийг ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁰ 7.1.2-д холбогдох заалтыг оруулсан.	АМГТГ
	22.15 Тусгай зөвшөөрөл бүрийн өргөдөл гаргасан, олгосон, дуусах огноог ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹¹ 7.1.2-д холбогдох заалтыг оруулсан.	АМГТГ
	22.16 Эцсийн өмчлөгчийн мэдээлэл, эзэмшлийн түвшин, эзэмшил эсвэл хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг тухай дэлгэрэнгүй мэдээллийг /нэр, харьяалах улс, иргэншил, оршин суугаа улс болон улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэх/ ил тод болгох.	2022 оноос мөрдөж эхэлсэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8.6.19-д заасны дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг ил тод болгож эхэлсэн. ОУИТБ-ын хуулийн төслийн ¹² 7.1.11-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, Хууль зүйн яам
	22.17 Засгийн газар болон ТӨК хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан хамаарах дүрэм, журам, үүнд дахин хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилтийн талаар тайлбарласан жил тутмын ил тод мэдээллийг ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹³ 7.1.12-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОУИТБС
	22.18 Төрд ноогдох газрын тосыг компаниуд зах зээлд хүргэж, борлуулж буйг мэдээлж, худалдан авагч компанийг сонгох үйл явцыг ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁴ 7.1.12ж-д холбогдох заалтыг оруулсан	АМГТГ
	22.19 Материаллаг түвшнээс дээш буй компаниудын зүгээс ТӨК-д, ТӨК-ийн зүгээс төрийн байгууллагад, Засгийн газрын зүгээс ТӨК-д хийж буй шилжүүлгүүдийн иж бүрэн, үнэн зөв мэдээллийг ил болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁵ 7.1.12е-д холбогдох заалтыг оруулсан	УУХҮЯ, ОУИТБС
	22.20 Материаллаг түвшний төлбөр бүхий ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгох ОУИТБС-ын үйл явцыг хөгжүүлж, бусад төлбөр, орлогын урсгалтай ижил хэмжээнд ил тод болгож, үүнд ТӨК-ийн охин компаниуд болон салбарыг хамруулж байх.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁶ 7.1.12е-д холбогдох заалтыг оруулсан	УУХҮЯ, ОУИТБС
	22.21 Үйлдвэрлэж буй бүх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, үнийг бүтээгдэхүүн бүрээр цаг тухайд нь цуглуулан, олон нийтэд ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁷ 7.1.6-д холбогдох заалтыг оруулсан	УУХҮЯ, ОУИТБС
	22.22 Экспортын бүтээгдэхүүний мэдээллийг системтэйгээр ил тод болгож, энэхүү мэдээллийг бүс нутгаар, компани эвсэл төслөөр дэлгэрэнгүй задалж, экспортын хэмжээ болон үнийг тооцох арга зүйг	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁸ 7.1.6-д холбогдох заалтыг оруулсан	ГЕГ

⁹ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁰ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹¹ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹² ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹³ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁴ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁵ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁶ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁷ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

¹⁸ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
	ил тод болгох.		
	22.23 Уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудын зүгээс Засгийн газарт төлж буй бүх материаллаг төлбөр болон Засгийн газрын уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудаас хүлээн авч буй бүх материаллаг орлогыг иж бүрнээр нь олон нийтэд нээлттэй болгож, хүртээмжтэй, иж бүрэн нээлттэй байдлыг хангах.	ОУИТБ-ын хуулийн төслийн ¹⁹ 7.1.7-д холбогдох заалтыг оруулсан	АМГТГ
	22.24 Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий олборлох эрх олгосны төлөө бүхлээр нь эсвэл хэсэгчилсэн байдлаар бараа эсвэл үйлчилгээ (үүнд зээл, баталгаа, дэд бүтцийн бүтээн байгуулалт) авах эсвэл тухайн эрдэс баялгаас авах гэрээ хэлцэл буй эсэхийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд Шаардлага 4.3 дээр заасан бартерын төрлийн арилжаа гэсэн тодорхойлолтод нийцэх нөөцөөр баталгаажсан зээл багтах тул ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ²⁰ 7.1.13-д холбогдох заалтыг оруулсан	АМГТГ
	22.25 Олборлох салбарт хийгдэж буй тээвэрлэлтийн гэрээний талаарх нэмэлт мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах, үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүний төрөл, тээврийн маршрут, тээвэрлэлтэд оролцон буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах.	ОУИТБ-ын хуулийн төслийн ²¹ 7.1.6-д холбогдох заалтыг оруулсан	АМГТГ
	23.26 Засгийн газрын эрдэс баялгийн салбараас олж буй бүх орлого болон олборлох үйлдвэрлэлийн компаниудын төлж буй бүх татвар хураамжийг төсөл нэг бүрээр задаргаатай ил тод болгох.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ, ОУИТБС
	22.27 ОУИТБС-ын тайлагналын шинэлэг арга хандлагыг эрэлхийлж, одоо үйл ажиллагаа явуулж буй Засгийн газрын порталуудад суурилан төр, салбар болон иргэний нийгмийн талуудын хэрэгцээнд нийцсэн шуурхай өгөгдөл мэдээллийг, цаг тухайд нь ил тод болгох.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ, ОУИТБС
	22.28 Жил тутам компаниудын зүгээс төлсөн хэмээн, төрийн байгууллагуудын зүгээс хүлээн авсан хэмээн тайлагнаж буй мэдээлэл нь үнэн бодит, хараат бус аудитаар баталгаажсан, олон улсын аудитын стандартад нийцсэн байхыг хангах.	ОУИТБ-ын хуулийн төслийн ²² 17.3; 18.4-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОУИТБС
	22.29 Олборлох салбараас төвлөрүүлж буй ямар орлогыг, бэлэн болон бэлэн бусаас үл хамааран, улсын төсөвт бүртгэж буй талаар олон нийтэд ил тод болгох.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ, ОУИТБС
	22.30 ОУИТБС-ыг цаашид орлогын тогтвортой байдал, эрдэс баялгаас хамаарах хамаарал зэргийн талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах зорилго бүхий шуурхай ил тод мэдээллийн арга зүйл байдлаар ашиглах.	2024 онд шилжүүлэх	УУХҮЯ, ОУИТБС
	22.31 Орон нутгийн түвшинд материаллаг түвшнээс дээш компаниудын төлсөн татвар, төрийн хүлээн авсан орлогыг, аймаг болон сумаар нь иж бүрнээр нь ил тод болгох.	ОУИТБ-ын хуулийн төслийн ²³ 7.1.7-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОУИТБС

¹⁹ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

²⁰ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

²¹ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

²² ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

²³ ОУИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

	Зөвлөмж	Тайлбар	Хяналт тавих байгууллага
	22.32 Олборлох үйлдвэрийн салбараас Засгийн газрын олж буй орлогоос орон нутагт шилжүүлж буй (аймаг, сумд) бүх төлбөрийг ил тод болгох.	ОҮИТБ-ын хуулийн төслийн ²⁴ 7.1.8-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОҮИТБС
	22.33 Компаниудад хуулиар үүрэг болгосон, нийгмийн чиглэлтэй заавал төлөх материаллаг зарцуулалтыг, үүнд хуульд заасан Орон нутгийн хөгжлийн гэрээний хүрээнд заагдсан эсвэл хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд заагдсан дүнг ил тод болгох.	ОҮИТБ-ын хуулийн төслийн ²⁵ 7.1.3д-д холбогдох заалтыг оруулсан.	УУХҮЯ, ОҮИТБС

²⁴ ОҮИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

²⁵ ОҮИТБ-ын хуулийн төсөл- <https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da>

7.2 ОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж

Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК болон аудитын “Гроут финанс” ХХК-ын хамтарсан баг ОУИТБС-ын 17-р нэгтгэл тайлан буюу 2022 оны тайлангийн хараат бус нэгтгэгчээр сонгогдон ажилласан. ОУИТБС-ын 17-р нэгтгэл тайланг боловсруулах хүрээнд гарч байсан түгээмэл алдаа, хараат бус нэгтгэгчид тохиолдож байсан хүндрэл бэрхшээл, цаашид энэхүү ажлыг илүү үр дүнтэй, алдаагүй гүйцэтгэх хүрээнд гарсан санал хүсэлтийг нэгтгэн зөвлөмж боловсрууллаа.

ОУИТБС-ын стандартад өгөгдөл мэдээллийн чанарын асуудлыг чухлаар авч үздэг ба цаашид ЗГ болон компаниуд мэдээллээ системтэйгээр тайлагнах, Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хийх тохируулгын хэрэгцээг багасгах, мэдээллийн араас шалгах аас зайлсхийх олон улсын жишгийг дагаж мөрдөхийг зорьсон болно.

Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил бүрийн нэгтгэлийн тайланд зөвлөмж өгдөг боловч ахиц харагдахгүй байгаа талаар өмнөх 16-р тайланд дурдсан байсан. Энэ жилийн тайлангийн үр дүнд ч ахиц гараагүй байна. Засгийн газар болон компаниуд алдаатай тайлагнах, дутуу тайлагнах алдаа түгээмэл гарч байгаа нь зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад анхаарал бага хандуулж байгааг илэрхийлж байна. Тухайлбал **“Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах”, “Засгийн газрын орлого болон компанийн төлбөрийн зөрүүтэй холбоотой асуудал”, “Төслөөр салгаж тайлагнах боломжтой байдлаар мэдээллийг авах” “Засгийн газрын орлого, компанийн төлбөрийн зөрүүтэй холбоотой асуудал жил бүр түгээмэл гарч байгаад анхаарч мэдээллийн чанарыг сайжруулах”, “Цахим тайлангийн системд байршуулж буй мэдээллийн бүрдлийг алдаагүй, иж бүрэн байх хүрээнд цахим тайлангийн системд программын тохиргоо хийх”** зэрэг зөвлөмжүүдтэй энэ жил мөн ижил саналтай байна. Нөгөө талаар өмнөх жилүүдийн зөвлөмжийн хэрэгжилт тааруу байгаа нь тайлангийн ач холбогдлыг бууруулж байна.

Хараат бус нэгтгэгчийн хувьд өнгөрсөн жил мөн хараат бус нэгтгэгчээр ажилласан ба нэгтгэл хийж байх явцад зарим зүйлд ахиц гарсан боловч нийтлэг анхаарах асуудал хэвээр байлаа. Тухайлбал:

Засгийн газрын орлого, компанийн төлбөрийн зөрүүтэй холбоотой асуудал жил бүр түгээмэл гарч байгаад анхаарч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлд тодорхой ажлуудыг зохион байгуулахаар зөвлөж байсан хэдий ч энэ жил мөн давтагдлаа. Түүнчлэн нэгтгэл тайланд тодруулга мэдээлэл авахтай холбоотой асуудал буюу залруулга хийх хүрээнд төрийн болон хувийн хэвшлээс мэдээлэл авахад гардаг хүндрэл бэрхшээлд өөрчлөлт гарсангүй.

Иймд өнгөрсөн жилүүдэд өгч байсан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангахад цаашид анхаарч олон нийт болон холбогдох оролцогч талуудад ОУИТБС-ын ач холбогдол, үр нөлөөг тайлбарлан таниулах, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх талд санаачилгатай ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Өмнөх зөвлөмжүүдтэй

давхардахгүй байдлаар гол анхаарах асуудлыг эрэмбэлэн дараах зөвлөмжийг боловсрууллаа.

- ❖ Нэгтгэлд хамрагдсан бүх ТӨААН-үүд ил тод байдлын тайлангаа алдаагүй бүрэн баталгаажуулж ирүүлэх ажлыг хэвшүүлэх талаар УУХҮЯ, СЯ холбогдох бусад байгууллага онцгой анхаарал хандуулах
- ❖ Компаниуд болон төрийн байгууллагууд ОҮИТБС-ын тайланг өгөх үйл явцад чанарын өөрчлөлт авчрах, хэвшүүлэх, тайлангийн үнэн зөв байдлыг хангахад ахиц дэвшил гаргаж ажиллах
- ❖ ОҮИТБС-ын шаардлагуудын хэрэгжилтийн мэдээллийг ТӨААН-үүдээс бүрэн авах үйл явц тодорхойгүй байгаа тул стандарт, шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХАВСРАЛТУУД

Хавсралт	Мэдээлэл
Хавсралт 1	2022 оны МОҮИТБС-ын тайланд хамрагдсан компаниудын мэдээлэл
Хавсралт 2	Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн ЗГ-ын байгууллагуудын албан тушаалтан
Хавсралт 3	Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтан
Хавсралт 4	Компаниудад илгээсэн тайлангийн маягтуудын жагсаалт
Хавсралт 5	Төрийн байгууллагуудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц
Хавсралт 6	Компаниудын ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 7	ЗГ-ын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 8	Компанийн талд хийгдсэн тохируулга, төлбөрийн төрлөөр
Хавсралт 9	Тайлбарлагдаагүй зөрүү (компаниудаар)
Хавсралт 10	Анхны нэгтгэл, залруулга болон залруулгын дараах нэгтгэл (Компаниудаар)
Хавсралт 11	Тайлбарлаагүй зөрүү, компаниар
Хавсралт 12	Тохируулгын дараах улсын хэмжээний гол орлогын урсгалууд, ЗГ-ын дүнгээр
Хавсралт 13	Тохируулгын дараах орон нутгийн хэмжээний гол урсгалууд, ЗГ-ын дүнгээр
Хавсралт 14	Ажилчдын мэдээлэл
Хавсралт 15.а	Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт (2022 оны 12 сарын 31-ний байдлаар)
Хавсралт 15.б	Шинээр олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 15.в	Шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 15.г	Шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 15.д	2022 онд хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн жагсаалт
Хавсралт 15.е	Түгээмэл тархацтай ашигт малтмалын лиценз
Хавсралт 15.ё	Шалгараагүй аж ахуйн нэгжийн жагсаалт
Хавсралт 16.а	Нүүрсний олборлолт
Хавсралт 16.б	2022 оны дотоод болон экспортын борлуулалт, түүний дундаж
Хавсралт 17	Санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн байдал
Хавсралт 18.а	Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл (Нүүрсний салбараас бусад)
Хавсралт 18.б	Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл - Нүүрс
Хавсралт 19	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
Хавсралт 20.а	Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
Хавсралт 20.б	Ашиг хүртэгч эзэд (хувь хүн)
Хавсралт 20.в	Эцсийн өмчлөгчид (хуулийн этгээд)
Хавсралт 20.г	Ногдол ашиг
Хавсралт 21	Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээний мэдээлэл
Хавсралт 22	Төслийн түвшний мэдээлэл
Хавсралт 23	Компаниудын ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээлэл
Хавсралт 24.а	Нэгтгэлд хамрагдсан компаниудын ОҮИТБС-д оролцооны үнэлгээ
Хавсралт 24.б	ЗГ, Төрийн байгууллагуудын ОҮИТБС-д оролцооны үнэлгээ
Хавсралт 25.а	Ашигласан усны мэдээлэл
Хавсралт 25.б	ЗГ-т төлсөн ус ашигласны төлбөр (компаниудаар)
Хавсралт 26	Хог хаягдлын мэдээлэл
Хавсралт 27	Ашигласан эрчим хүч, түлш шатахуун, бүтээгдэхүүн
Хавсралт 28	Туслан гүйцэтгэгчийн мэдээлэл
Хавсралт 29	ТӨААН-үүдийн шилэн дансны мэдээлэл
Хавсралт 30	Төрийн Өмчит Аж Ахуйн Нэгжүүдийн зээлийн мэдээлэл
Хавсралт 31	Нөлөөллийн бүсийн мэдээлэл
Хавсралт 32	Баяжуулах үйлдвэр эрхлэгч ААН Байгууллагуудын ашигласан химийн бодисын мэдээлэл
Хавсралт 33	Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт болон бартерын гэрээ
Хавсралт 34	Ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл
Хавсралт 35	Ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл (Эрдэс түүхий эдийн худалдан авалт)
Хавсралт 36	Ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл (Борлуулалтын мэдээлэл)
Хавсралт 37	Төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-ын тээврийн төлбөр

Хавсралт	Мэдээлэл
Хавсралт 38	Иргэдэд ил тод болгосон гэрээний жагсаалт
Хавсралт 39	Тайлант оноос хойших ил тод болгосон гэрээний жагсаалт
Хавсралт 40	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2022 оны орлогын шилжүүлгийн мэдээлэл